

“ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026.01.26

“Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн дүрмийн 3.3.1.2 дахь заалт, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 97 дугаар тогтоолоор батлагдсан “Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам”-д заасны дагуу 2025 оны үйл ажиллагааны тайланг дараах агуулгын хүрээнд боловсруулав.

АГУУЛГА:

НЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	1
ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	8
ГУРАВ. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ	9
ДӨРӨВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	10
ТАВ. БОДЛОГО ШИЙДВЭР, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ	11
ЗУРГАА. АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	12
ДОЛОО. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТАЙЛАН	13

ХАВСРАЛТ:

1. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт
2. Бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлт
3. Эрсдэлийн удирдлагын тайлан
4. Аудитын зөвлөмжийн биелэлт
5. Төслийн мэдээлэл

НЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Эрдэнэс Оюу Толгой” ХХК нь Нэгдлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний зорилгод нийцүүлэн 2025 онд 7 үндсэн зорилгын хүрээнд 56 зорилт, 130 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж ажиллалаа. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 1 дүгээр зорилгын хүрээнд 90%, 2 дугаар зорилгын хүрээнд 86%, 3 дугаар зорилгын хүрээнд 97%, 4 дүгээр зорилгын хүрээнд 90%, 5 дугаар зорилгын хүрээнд 85%, 6 дугаар зорилгын хүрээнд 91%, 7 дугаар зорилгын хүрээнд 87%, нийт дүнгээр хэрэгжилт 91.2% байна. Зорилго тус бүрээр хийгдсэн ажлуудаас онцолж дурдвал: (*Хавсралт 1. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт*)

1. Бизнесийн өсөлтийг чухалчлан нэгдлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Оюу толгой ордын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

Тус зорилгын хүрээнд нийт 8 зорилт, 20 арга хэмжээг төлөвлөн ажиллаж жилийн эцсийн байдлаар ажлын гүйцэтгэл 90 хувь байна.

Антре гоулд (Онтрэ ХХК)-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн асуудлаар: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/46 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын дэд хэсгийн хүрээнд Онтрэ ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас Монголын талын хүртэх өгөөжийг Үндсэн хуулийн 6.2-д нийцүүлэх боломжит хувилбарууд (Засгийн газрын хувь эзэмшлийг тусгай АМНАТ-аар солих, Хөрөнгө оруулалтын гэрээ (ХӨОГ)-нд хамруулах эсэх болон өсөн нэмэгдэх АМНАТ ноогдуулах зэрэг)-ыг тодорхойлж, санхүүгийн тооцоолол, давуу сул тал, эрсдэлүүдийг багтаасан Дэд ажлын хэсгийн тайланг боловсруулан холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, түүнд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий дэд ажлын хэсгүүдтэй хамтран ажиллаж, холбогдох танилцуулга, мэдээлэл, судалгааг боловсруулан батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

“Оюу Толгой” ХХК-ийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх өөрчлөх чиглэлээр: Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.02.01-ний өдрийн А/29 тушаалаар байгуулагдсан “УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын 1 дэх заалтын 2, 3, 4 дэх дэд заалтын хэрэгжилтийг хангах, “Оюу Толгой” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах, шинэчлэх асуудлаар яриа хэлэлцээ хийх” үүрэг бүхий Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг 100% ханган ажилласан.

Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон (НӨОДТХНГ)-ний 11.3(ё) заалтын дагуу хэлэлцээрийг эхлүүлэх тухай “Мэдэгдэл”-ийг Монголын талаас 2025.04.10-нд хамаарал бүхий Талуудад хүргүүлсэн, тус мэдэгдлийн хариуд “яриа хэлэлцээ өрнүүлэхийг дэмжиж байгаа тухай” 2025.05.30-ны өдөр Рио Тинто талаас хариу албан бичгийг ирүүлсэн.

Оюу толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, санал боловсруулан ЗГ-ын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67-р захирамжаар байгуулсан. Тус Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх Дэд ажлын хэсгийг Сангийн сайдын 2025.09.22-ны өдрийн 169-р тушаалаар байгуулсан.

Дээрх ажлын хэсгүүд, дэд ажлын хэсгийн хүрээнд ХНЗ-ийн хүүг бууруулахтай холбоотой суурь судалгаануудыг хийж, хэлэлцээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоод зөвлөх үйлчилгээний багуудтай хамтран ажиллаж, зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг хүлээн авсан.

2025 оны 10-р сарын 30, 31-ний өдрүүдэд хөрөнгө оруулагч талтай хийх хэлэлцээг албан ёсоор эхлүүлсэн ба 2 талын хэлэлцээ хэвийн үргэлжилж байна.

“Оюу Толгой” ХХК-ийн санхүүгийн загвар боловсруулж, харьцуулалт хийх замаар хяналтыг сайжруулах хүрээнд ОТ төслийн богино болон урт хугацааны санхүүгийн загварыг боловсруулж, эх сурвалж, дата мэдээллүүдийг нэгтгэсэн мастер файл үүсгэн, автоматжуулах ажлыг эхлүүлээ.

2. Бизнесийн өсөлтийг чухалчлан нэгдлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд УИХ-ын 2021 оны 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулна.

Тус зорилгын хүрээнд нийт 4 зорилт, 7 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, 86 хувийн биелэлттэй байна.

Оюу Толгойн Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө (ДУББСТ), Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө (ДУББСНТ)-г хуульд нийцүүлэн цуцалж, хүчингүй болгох шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд:

- “Менежментийн үйлчилгээний гэрээ” (МҮГ)-г шинэчлэх үе шат, тэдгээр үе шат тус бүрд хийгдэх ажиллагаа, хугацаа, хүлээгдэж буй үр дүнгийн талаар гадаадын хөрөнгө оруулагч талтай тохиролцоонд хүрч, тус гэрээг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэхтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн ажлын даалгаврын төслийг хамтран боловсруулав. Үүний дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Ankura Consulting Group LLC-тэй хамтран ажиллаж, оношилгооны тайлангийн эхний төсөл бэлэн болсон.
- МҮГ-г шинэчлэх, сайжруулах, өөрчлөх чиглэлээрх төслийг боловсруулан “Эрдэнэс Монгол” ХХК болон бусад холбогдох яам болон газруудаас санал авахаар хүргүүлсэн.
- Хэлэлцээний бэлтгэл ажлын хүрээнд Анкура компанийн боловсруулсан тайлангаас олон улсын бэнчмарк мэдээллүүдийг боловсруулан нэгтгэж, Ажлын хэсгийн гишүүдэд эх сурвалж мэдээлэл болгон хүргэсэн.
- Ерөнхий сайдын 68 дугаар захирамжаар байгуулагдсан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар ахлуулсан Ажлын хэсэг нь МҮГ-г шинэчлэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч тал буюу Рио Тинто компанийн төлөөлөлтэй албан ёсны эхний хэлэлцээг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хийж, Талуудын тохиролцсон менежмент, засаглалын асуудлаар 11 дүгээр сард протокол байгуулсан.
- Ажлын хэсгийн хэлэлцээнд Талуудын санал харилцан тохиролцоонд хүрээгүй байгаа бөгөөд хэлэлцээ үргэлжилж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолын 1.6 дахь заалтад “татварын актуудын биелэлтийг хангуулах, цаашид нэг мөр ойлгож дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрүүлж, хэрэгжүүлэх.” гэсэн бөгөөд Лондонгийн Олон улсын арбитрын шүүхэд үүссэн “Оюу Толгой” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Монгол Улсын Засгийн газарт холбогдох татварын маргаантай холбоотой Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 74 дүгээр захирамжаар шинэчлэн байгуулсан ба тус Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж буй HSF зөвлөх компанийг шаардлагатай мэдээллүүдээр цаг тухайд нь хангаж, хамтран ажиллалаа.

3. Санхүү, үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангаж үр ашгийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд оюу толгой төслийн тогтвортой үйл ажиллагааг бэхжүүлнэ.

Тус зорилгын хүрээнд нийт 11 зорилт, 41 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, дунджаар 97 хувийн биелэлттэй байна.

Оюу толгойн ил уурхай, далд уурхайн үйл ажиллагаа, далд уурхайн төсөл, баяжуулах үйлдвэр, хаягдал хадгалах байгууламж, дэд бүтэц, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны чиглэлээр хэлтэс нэгжүүдийн сар бүрийн тайланд дүн шинжилгээ хийж гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Мөн холбогдох хэлтэс нэгжүүдтэй тогтмол давтамжтай тайлангийн уулзалт хийж, тодруулга мэдээлэл авч тайланд тусгав. Уурхайн талбарт ажиллаж, жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, тулгамдаж байгаа асуудалтай газар дээр нь танилцаж, холбогдох тайланг боловсруулав. Үүний үр дүнд тулгуурлан ОТ ХХК-ийн ТУЗ-ийн хурлын удирдамж, танилцуулгын төслийг боловсруулж, шийдвэр гаргалтад оролцож ажиллав. Мөн толгой компани, УИХ-ын намын бүлгүүд, Хянан шалгах түр хороо, ЗГ-ын ажлын хэсгүүдийг холбогдох мэдээллээр хангаж ажиллалаа.

4. Бизнесийн өсөлтийг чухалчлан нэгдлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд өсөлт хөгжлийг цогцлооно.

Тус зорилгын хүрээнд нийт 6 зорилт, 13 арга хэмжээг төлөвлөн ажиллаж гүйцэтгэл дунджаар 90 хувьтай байна.

Оюу Толгойн ил уурхайгаас ашиглалтын явцад баяжуулах үйлдвэрт боловсруулах боломжгүй исэлдсэн хүдрийг тусад нь овоолон хурааж байна. Уг исэлдсэн хүдрийн овоолго болон хоёрдогч сульфидын хүдрийг нуруулдан уусгах аргаар катодын зэс үйлдвэрлэхээр судалгаа хийж байна. Одоогийн байдлаар УТЭЗҮ тооцоогоор төслийн өнөөгийн үнэ цэнэ буюу эдийн засгийн үр өгөөжгүй талаар дүгнэгдсэн ба цаашид нэмэлт тооцоо судалгаа хийж, УТЭЗҮ-н хөрөнгө оруулалтын зардлыг бууруулж, эерэг мөнгөн урсгалтай болгох боломжийг судлахаар төлөвлөн ажиллаж байна.

Гаалийн ерөнхий газрын гэрээ бүртгэлийн нэгдсэн системд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн дагуу Оюу Толгойн борлуулсан зэсийн баяжмалыг тус системд биржийн борлуулалтын дугаартайгаар бүртгүүлж хилээр тээвэрлэх шаардлагатай болсон ба Оюу Толгой ХХК нь зэсийн баяжмалыг биржийн арилжаагаар борлуулдаггүй тул уурхайн цогцолборт баяжмал овоорох асуудал үүссэн. Тус асуудлыг оролцогч талууд болон АҮЭБ-ийн яамтай хамтран ажиллаж, баяжмалыг биржийн борлуулалтын дугааргүйгээр бүртгүүлэх хүрээнд асуудал шийдвэрлэгдсэн. Хилийн боомтын захиргаа болон ЭЗХЯ-ны захиалгаар Хилийн Гашуунсухайт боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байгаатай холбоотойгоор Оюу Толгойн экспортын логистикийн цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр хилийн тусгайлсан гарц гаргах талаар Хилийн боомтын захиргаа болон Эрдэнэс Монгол ХХК-ийн Дэд бүтэц, логистикийн групптэй хамтарсан уулзалт хийж, холбогдох хүсэлтийг хүргүүлэв.

Түүнчлэн Оюу Толгойн нийт эрчим хүчний хэрэглээний 30 орчим хувийг дотоодын сэргээгдэх эрчим хүчний төслөөс нийлүүлэх төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тус төсөл нь Салхин цахилгаан станц мөн батарей хуримтлуурын системтэй байх бөгөөд гадагш урсах валютыг бууруулах чухал ач холбогдолтой ба Сэргээгдэх эрчим хүч худалдан авах гэрээг ирэх онд байгуулахаар судлан ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 274 тогтоолын 6 дугаарт “Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагааны тогтвортой байдал болон байгаль орчин, нийгэм, засаглалын шалгуур үзүүлэлтийг сайжруулна гэж заасны дагуу ЭОТ ХХК, ОТ ХХК-ийн хооронд байгуулсан БОНЗ-ын гэрээний хүрээнд Өмнийн говийн бүсийн усны нөөцийн судалгаа, усны чанарын судалгааны ажлуудыг гүйцэтгэх талаар санамж бичиг байгуулсан бөгөөд Ажлын тодорхойлолтыг боловсруулан баталгаажуулахаар ажиллаж байна. Мөн холбогдох ажлын даалгавруудыг урьдчилсан байдлаар боловсруулаад байна.

- Говийн бүсийн газрын доорх усны нөөцийн судалгааны ажлын зорилго:

ГДУ-ны нөөцийн судалгааны ажлыг 2025 оны байдлаар гүйцэтгэх, усны нөөцийн одоогийн байдал болон хэтийн төлөвийг үнэлэх, усны эх үүсвэрийн байршлыг харуулах

- Говийн бүсийн усны чанарын судалгааны ажлын зорилго:

Өмнөх судалгаануудын үр дүнг нэгтгэн хянаж, ундны усны чанарын үнэлгээг илүү олон цэгт шинээр нарийвчлан хийх, ач холбогдол бүхий цэгүүдэд давтан шинжилгээ хийхэд оршино.

Мөн Хэрлэн тооно төслийн ТЭЗҮ тодотгол боловсруулах ажилд манай компани захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. ТЭЗҮ тодотгол 2025 онд багтаж эцсийн тайланг дуусах ба 2026 оны эхний улиралд багтаан Усны зөвлөлд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

5. Сайн засаглал, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд ОТ компанийн өнөөгийн засаглалд үнэлгээ хийн, гүйцэтгэл, хариуцлагыг сайжруулах чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Тус зорилгын хүрээнд нийт 2 зорилт, 2 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, гүйцэтгэл 85 хувь байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 68 дугаар захирамжаар байгуулагдсан “Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолын 1.5 дахь заалтад Оюу толгой ХХК-ийн засаглалыг сайжруулах талаар хамтран ажиллах гэсний дагуу хэрэгжилтийг хангахад Олон улсын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээс ОТ компанийн засаглалыг одоогийн нөхцөлд оношилгоо хийв. Энэ хүрээнд засаглал сайжруулах дүгнэлт, зөвлөмжийг талуудад (Эрдэнэс Монгол ХХК, ЭОТ ХХК, Рио Тинто, Оюу Толгой ХХК) танилцуулсны үндсэн дээр засаглалыг сайжруулах саналыг боловсруулан хамтран ажиллав.

УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор Ерөнхий сайдын 2025 оны 68 дугаар захирамж гарч Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж ОТ компанийн засаглалыг сайжруулах хүрээнд хөрөнгө оруулагч талтай хэлэлцээнд орох бэлтгэл ажлыг хангаж, зарчмын санал, дүгнэлт боловсруулан хэлэлцээ 2025 оны 10 дугаар сарын 30-нд эхлэв. Талуудын

хэлэлцээний бүрэлдэхүүн Оюу толгой ХХК-ийн засаглал сайжруулах асуудлаар 2025 оны 11 дүгээр сарын 20-нд протокол үйлдэв. Хэлэлцээ үргэлжилж байна.

6. Сайн засаглал, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан өмнийн бүсийн хөгжлийг хурдасгахад оролцогч талуудтай идэвхтэй ажиллана.

Тус зорилгын хүрээнд нийт 2 зорилт, 5 арга хэмжээг төлөвлөн ажиллаж ажлын гүйцэтгэл дунджаар 91 хувь байна.

Төсөл хэрэгжүүлж буй бүс нутгийн хамтын ажиллагаа

Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ (ХӨОГ)-ний дөрөвдүгээр бүлгийн хэрэгжилтийг хангах, УИХ-ын 103 дугаар тогтоолын холбогдох заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбоотойгоор БОНЗ гэрээний хүрээнд 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдөр “Говийн бүсийн хөгжлийн талаарх хамтын ажиллагаа”-ны санамж бичгийг “Эрдэнэс Оюу Толгой” ХХК, “Оюу Толгой” ХХК, “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ хамтран байгуулж Монгол Улсын Шадар Сайд санамж бичгийг батламжлав.

Санамж бичгийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор Говийн бүсийн (Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр) хөгжилд байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд хамтран ажиллах ажлуудын Ажлын тодорхойлолтыг 2025 оны 9 дүгээр сарын 18-ны ЭОТ ХХК болон ОТ ХХК-иас батлав. Энэ хүрээнд

- A. Говийн бүсийн аймгуудын орон нутгийн хөгжлийн төвүүдийн эдийн засгийн тэргүүлэх чиг үүргийг тодорхойлон, хөрш зэргэлдээ сумдтай кластераар хөгжүүлэх урт хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлох, Өмнөговь аймгийн Ханбогд сумыг эдийн засгийн чадамжтай хот болгон хөгжүүлэхэд холбогдох талуудтай хамтран ажиллах;
 - B. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэх, Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчдын хоршоодын чадавхыг жишиг болгон хөгжүүлэн, сайн туршлагыг Говийн бүсэд нэвтрүүлэх;
 - C. Орон зайн цахим платформ бүхий метаверс орчинд иргэд олон нийт мэдээлэл авах боломжтой төлөвлөлт, удирдлага, хяналтын системийг нэвтрүүлэх;
 - D. Хөгжлийн бодлого, төлөвлөгч нарыг чадавхжуулах сургалт, уулзалтыг үе шаттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлуудыг хэрэгжүүлэхээр тусгав Энэ хүрээнд талууд ажлын даалгавар боловсруулан ажиллаж байна.
- 7. Санхүү, үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангаж үр ашгийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд ЭОТ ХХК-ийн үйл ажиллагаа, менежментийг сайжруулна.**

Тус зорилгын хүрээнд нийт 23 зорилт, 42 арга хэмжээг төлөвлөн ажиллаж 3 дугаар улирлын байдлаарх ажлын гүйцэтгэл 87 хувьтай байна.

Нэгдлийн хэмжээний ERP систем нэвтрүүлэх баг болох “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Нэгдлийн удирдлагын нэгдсэн систем, цахим хөгжлийн зөвлөлийн холбогдох

мэргэжилтнүүд, ажлын даалгавар боловсруулах зөвлөх нартай уулзалт хийж компанийн системийн хэрэгцээ шаардлага, одоогийн нөхцөл байдлын талаар асуулгад холбогдох ажилтнууд оролцон, мэдээлэл өгч хамтран ажиллав.

Компанийн 2025 оны 1-р улирал, 2-р улирал, 3, 4 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг ЭМ-ийн ТУЗ-ийн хурлаар тухай бүрд батлуулсан ба компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл, цалин хөлс, бараа материал хөрөнгийн бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв хөтөлж, нийгмийн даатгалын тайланг сар бүр, санхүүгийн тайлан балансыг улирал бүр, үйл ажиллагаанд холбогдох бусад тайлан мэдээллийг тухай бүрд холбогдох байгууллагуудад хүргүүлж баталгаажууллаа.

Оюу толгой төслийн хэрэгжилт, орон нутагт хэрэгжиж буй томоохон хөрөнгө оруулалт, болон Монголын талын төслөөс хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой УИХ, ЗГ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй байгуулагдсан ажлын хэсгүүдийн хэрэгжүүлж буй арга хэмжээ, хөрөнгө оруулагч талтай хийж буй хэлэлцээний талаарх мэдээллийг боловсруулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж, холбогдох төрийн байгууллагуудтай уялдаатай ажиллав.

Уул уурхайн салбарын сүүлийн үеийн шинэ технологи, дэвшлийн талаар мэдээлэл авах, бусад ижил төстэй компанитай хамтын ажиллагаа өргөжүүлэх зорилгоор

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг Уул уурхайн долоо хоног арга хэмжээнд “Эрдэнэс Монгол” нэгдлийн удирдамжийн дагуу оролцож нэгдлийн бүрэлдэхүүн компаниудын нэгдсэн асарт компанийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа танилцуулав.

Компанийн гадаад харилцааг өргөжүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Чили Улсын төрийн өмчит Коделко ХХК-тай хамтын ажиллагаа эхлүүлэх санамж бичгийн төслийг боловсруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Гадаад харилцааны яамтай хамтран ажиллав. Үүний үр дүнд санамж бичиг байгуулах асуудал Монгол, Чили улсын Гадаад харилцааны яамд хоорондын улс төрийн зөвлөлдөх уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусч, Чили Улсын Коделко ХХК хамтран ажиллах манай саналыг албан ёсоор дэмжиж буйгаа илэрхийлээд байна.

Хөрөнгө оруулалт, санхүүжилт татах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил

Монгол Улсын Их Хурлын 2019 оны “Оюу толгой ордын ашиглалтад Монгол улсын эрх ашгийг хангуулах тухай” 92 дугаар тогтоол, 2021 оны “Оюу толгой ордоос Монгол улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд 2023.03.29-ний өдөр “Эрдэнэс Оюу Толгой” ХХК, “Оюу Толгой” ХХК-ийн хооронд “Байгаль орчин, нийгэм засаглалын түншлэлийн гэрээ”-г байгуулж, 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдөр “Говийн бүсийн хөгжлийн талаарх хамтын ажиллагаа”-ны санамж бичгийг “Эрдэнэс Оюу Толгой” ХХК, “Оюу Толгой” ХХК, “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТҮГ-тай байгуулсан.

УИХ тогтоол, Хөрөнгө оруулалтын гэрээний холбогдох заалт, БОНЗТ гэрээ, санамж бичгийн хүрээнд Говийн бүсийн (Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр) хөгжилд Оюу толгой төслийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, байгаль

орчин, нийгэм, засаглалын ажлуудын хэрэгжилт, гүйцэтгэлтийг хангахтай холбоотойгоор “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-аас “Оюу Толгой” ХХК-д БОНЗ-ын зарим үйлчилгээг төлбөртэйгээр үзүүлэх Ажлын тодорхойлолтыг батлав. Энэ нь компанийн үйл ажиллагаанд шаардагдах тодорхой санхүүжилтийг шийдвэрлэж, санхүүжилт татах гол нөхцөл болсон.

Төсөлд оролцогч талуудтай үр дүнтэй харилцаж, мэдээллээр хангах зэрэг төсөлд санаачилгатай оролцож буй байдал.

ЭОТ ХХК нь үндсэн чиг үүргийнхээ хүрээнд “Оюу Толгой” ХХК-ийн Хувь Нийлүүлэгчдийн зээлийн /ХНЗ/-ийн хүүг бууруулах, “Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх” тухай УИХ-ын 103 дугаар тогтоол, Онтрэ ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайнуудаас Монголын талын хүртэх өгөөжийг тодорхойлох хүрээнд Монгол Улсын Ерөнхий Сайдын захирамжаар байгуулагдсан 67, 68, 73 дугаар ажлын хэсгүүд, тус ажлын хэсгүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан дэд ажлын хэсгүүдэд орж ажиллах Оюу толгой төсөлтэй холбоотой мэдээллээр хангаж, ажлын хэсгүүдэд танилцуулга мэдээлэл өгч хамтран ажиллаж байна. Түүнчлэн дээрх асуудалтай холбоотойгоор хувьцаа эзэмшигч талууд Хэлэлцээ хийхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах, ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулах, нэгдсэн мэдээлэл өгөх, Хэлэлцээний үйл явцыг зохион байгуулах ажлуудыг гүйцэтгэх, хувьцаа эзэмшигч Рио Тинто талтай мэдээлэл солилцох, ажлын төлөвлөгөө, хэлэлцээний төлөвлөгөө гаргах зэргээр удаа дараа уулзалт зохион байгуулж төсөлд оролцогч талуудтай үр дүнтэй харилцан холбогдох талуудыг мэдээллээр хангах ажлуудыг гүйцэтгэн ажиллалаа. Бэлтгэл ажлыг бүрэн хангаж хэлэлцээг амжилттай эхлүүлсэн ба дараагийн үе шатанд хэлэлцээ үргэлжилж байна.

Албан хэрэг хөтлөлт

2025 оны жилийн эцсийн байдлаар Гүйцэтгэх захирлын тушаал болон бичиг хэргийн талаар нэгтгэн тайлагнавал:

I. Явсан бичгийн бүртгэлд: Бусад байгууллагад 315 албан бичиг хүргүүлж, хариутай 111 албан бичиг илгээснээс 73 албан бичигт хариу авч;

II. Ирсэн бичгийн бүртгэлд: Холбогдох байгууллагуудаас 384 албан бичиг хүлээн авсан. Үүнээс хариу өгөх шаардлагатай 166 албан бичиг ирснээс 152 албан бичигт хариуг хүргүүлж, 14 албан бичиг ажиллагаанд байна.

Явсан, ирсэн албан бичгийн ихэнх хувийг “Оюу Толгой” ХХК, толгой компани “Эрдэнэс Монгол” ХХК, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон бусад яам, төрийн байгууллагатай харилцсан албан бичгүүд бүрдүүлж байна.

III. Гүйцэтгэх захирлын тушаал: Захирамжлалын шинжтэй нийт 98 тушаал гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 онд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан худалдан авалт хийхгүй тул худалдан авах ажиллагаа төлөвлөгдөөгүй.

ГУРАВ. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн стратеги, бодлого, цаашдын үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрийн эрх зүйн үндэслэл оновчтой эсэхийг тодорхойлох, цаашид тус компанийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн, чиг үүргийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагын үүднээс “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудит орох шийдвэр гарсан бөгөөд дотоод аудитын тайланг хэлэлцсэний дараа бизнес төлөвлөгөөг батлахаар төлөвлөөд тухайн улирлын үйл ажиллагааны зардлыг 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 57 дугаар тогтоолоор баталсан. Улмаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 90 дугаартай тогтоолоор компанийн 2025 оны төсвийг буюу 3,4 дүгээр улирлын төсвийг баталсан. Тус баталсан төсвийн дагуу гүйцэтгэлийн мэдээллийг дараах байдлаар үзүүллээ.

Төсвийн гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2025 он 12-р сар 31		
		2025 оны батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хувь
Нэг. Нийт орлого/санхүүжилт		380,000,000	380,000,000	100
Хэрлэн Тооно төслийн орлого		380,000,000	380,000,000	100
Хоёр. Нийт үйл ажиллагааны зардал		7,593,636,000.0	3,520,615,419.0	46.4
2.1	Цалингийн зардал	2,272,452,000.0	2,105,074,266.0	92.6
2.2	НДШ-ийн зардал	284,056,000.0	241,717,000.0	85.1
2.3	Бичиг хэрэг	18,445,000.0	17,360,000.0	94.1
2.4	Веб сайт, интернетийн зардал	26,937,000.0	21,400,000.0	79.4
2.5	Шуудан холбооны зардал	4,602,000.0	2,240,000.0	48.7
2.6	Ном хэвлэл захиалга	6,500,000.0	-	-
2.7	Машин үйлчилгээ /сэлбэг/	-	-	-
2.8	Шатахууны зардал	11,640,000.0	11,000,000.0	94.5
2.9	Зөвлөх үйлчилгээ, судалгааны зардал	2,000,000,000	-	-
2.10	Зар сурталчилгааны зардал	181,875,000.0	144,000,000.0	79.2
2.11	Гадаад дотоод сургалт, судалгаа	27,098,000.0	10,500,000.0	38.7
2.12	Томилолтын зардал	442,661,000.0	111,122,780.0	25.1
2.13	Хурал, уулзалтын зардал	36,000,000.0	15,650,000.0	43.5
2.14	Байрны урсгал засварын зардал /түрээс/	67,000,000.0	67,000,000.0	100
2.15	Ажилтнуудын нийгмийн арга хэмжээ	11,426,000.0	-	-
2.16	Нэг удаагийн тэтгэмж /тэтгэвэр/	86,428,000.0	63,000,000.0	72.9
2.17	Ханбогд төслийн зардал	15,000,000.0	4,660,000.0	31.1
2.18	Хангамжийн материал	23,992,000.0	21,300,000.0	88.8

2.19	Татвар, даатгалын зардал	179,658,000.0	3,235,000.0	1.8
2.20	Гэрээт ажлын зардал	262,000,000.0	188,750,000.0	72.0
2.21	Санхүүгийн тайлан баталгаажуулах зардал	20,000,000.0	11,000,000.0	55.0
2.22	Элэгдлийн зардал	310,756,000.0	129,704,373.0	41.7
2.23	Зээлийн хүүгийн зардал	800,000,000.0	-	-
2.24	Менежментийн төлбөр	-	-	-
2.25	Ашиглалтын зардал	144,105,000.0	109,652,000.0	76.1
2.26	Бусад зардал	16,960,000.0	7,250,000.0	42.7
2.27	Хэрлэн Тооно төслийн зардал	344,045,000.0	235,000,000.0	68.3

ДӨРӨВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХОЛБОГДОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 4 дүгээр сарын 08-ний өдөр шинэчлэн батлагдсан зохион байгуулалтын бүтцийн хүрээнд Гүйцэтгэх захирал, 1 газар, 5 хэлтэст нийт 31 орон тоотой ажиллахаар төлөвлөгдсөн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар удирдах болон гүйцэтгэх 23 ажилтантайгаар үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санхүү, шинжилгээний хэлтсийн Мэдээллийн шинжээч мэргэжилтэн, Санхүүгийн загварчлал хариуцсан мэргэжилтний сул ажлын байранд хүний нөөцийн нээлттэй сонгон шалгаруулалтыг 2025 оны 1 дүгээр сард зохион байгуулж, шалгарсан хоёр ажилтантай туршилтаар ажиллуулах болон хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан ба үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах хүрээнд ЗГХЭГ, толгой компаниас ирүүлсэн чиглэлийг баримтлан батлагдсан төсвийг хэмнэж, бүтцэд батлагдсан орон тооноос чөлөөлөгдсөн албан хаагчдын сул ажлын байрыг орлох замаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Хүний нөөцийн чадавх, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор нийт ажилтнуудад зориулж Архивын Ерөнхий Газар, Тагнуулын Ерөнхий Газраас мэргэжилтнүүдийг урьж "Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт", "Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, анхаарах асуудал" сургалтуудаас гадна Мэргэжлийн ур чадварыг сайжруулах чиглэлээр Рио Тинто компани болон Австрали улсын Күйнслэнд мужийн их сургуулийн хамтран зохион байгуулж буй "Өмнийн говийн далд уурхайн институт"-ын мэргэжил дээшлүүлэх Хариуцлагатай орон нутгийн харилцаа сургалт, Европын Холбооны Тогтвортой Санхүүгийн Зөвлөх Төв (SFAH)-ийн хүрээнд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Тогтвортой байдлын төлөөх санхүүгийн төвөөс (UNDP FC4S) хэрэгжүүлж, Сангийн яамнаас зохион байгуулсан "Тогтвортой байдлын удирдлага", МУУҮА-ын "Хариуцлагатай уул уурхай" зэрэг сургалтуудад холбогдох ажилтнууд хамрагдлаа.

Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан Аж үйлдвэр, эрдэс баялгийн гамшгаас хамгаалах улсын албаны бэлэн байдлын үзлэгт 2025.05.22-23-ны өдрүүдэд хамрагдаж компанийн мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, бэлэн байдлын талаар танилцуулж ажиллав.

Байгууллагын соёлыг сайжруулах хүрээнд

Ажилтнуудын ахуй, нөхцөл, хэрэгцээ шаардлагыг дэмжих зорилгоор цалингийн болон шаардлагатай бусад төрлийн зээл, банкны үйлчилгээг харьцангуй

бага хүү, шимтгэл, хураамжтай байх таатай нөхцөлөөр авах боломжийг бүрдүүлж, харилцагч Голомт банктai энэ төрлийн гэрээний нөхцөлийг сайжруулан, шинэчлэн байгуулж хамтран ажиллаж байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах, оновчтой болгох зорилгоор дотоод дүрэм журам, хэм хэмжээг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан холбогдох баримт бичгүүдийг шат дараатайгаар шинэчлэн баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийт ажилтнуудын санал хураалтын үндсэн дээр “Ёс зүйн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж, байгууллагын “Ёс зүйн дүрэм”, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТАВ. БОДЛОГО ШИЙДВЭР, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

“Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн үйл ажиллагаанд хамаарах чиглэлээр дараах шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллалаа. *(дэлгэрэнгүйг Хавсралт 2. Бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийн тайлан)*

Үүнд:

1. МУЗГ-ын хуралдааны 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 38 дугаар тэмдэглэл, Хувь Нийлүүлэгчдийн Зээлийн хүүг бууруулах, УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын 1 дэх заалтын 2, 3, 4 дэх дэд заалтын хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах тухай;
2. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2024.06.06-ны өдрийн “Хэрлэн-Тооно төслийн тухай” 52 дугаар тогтоол;
3. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2024.06.06-ны өдрийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай” 53 дугаар тогтоол;
4. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2024.04.18-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тэмдэглэл, “Оюу Толгой” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой баримт, материалыг танилцах боломжит хугацаанд ирүүлж байх тухай;
5. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны тэмдэглэл;
6. МУЗГ-ын хуралдааны 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэл;
7. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 01 дүгээр тэмдэглэл;
8. “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн хурлын 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн “Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг батлах тухай” 01 дүгээр тогтоол;
9. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн “Дотоод аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 56 дугаар тогтоол;
10. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2025.04.08-ны өдрийн “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн бүтэц, орон тоо, 2025 оны 2 дугаар улирлын үйл ажиллагааны зардлыг батлах тухай” 57 дугаар тогтоол;

11. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох төлөөлөгчийг томилох, удирдамж батлах тухай” 58 дугаар тогтоол;
12. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн 2025 оны төсөв батлах тухай 90 дугаар тогтоол;
13. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 10 дугаар сарын 07-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн тогтоолд гарын үсэг зурах эрх олгох тухай” 98 дугаар тогтоол;
14. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 12 дугаар сарын 19-ний өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн тогтоолд гарын үсэг зурах эрх олгох тухай” 128 дугаар тогтоол;
15. ЗГХЭГ-ын даргын 2025.06.23-ны өдрийн ХЭГ/1760 дугаартай бичгээр өгсөн чиглэл;
16. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025.10.03-ны өдрийн 01/1260 дугаартай үүрэг даалгавар, чиглэл хүргүүлэх тухай бичиг.

ЗУРГАА. АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Үндэсний аудитын газраас хийсэн аудитын хүрээнд

Үндэсний Аудитын Газраас “Ажу Мэргэн Аудит” ХХК томилогдон 2024 оны санхүүгийн тайланд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв тайлагнасан эсэхэд санхүүгийн аудит хийж, “өөрчлөлтгүй” дүгнэлт бүхий аудитын тайланг 2025.03.28-ны өдөр ирүүлсэн.

Аудитаар нийт 14.2 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс 2.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2.1 сая төгрөгийн 2 зөрчилд 2 албан шаардлага, 10.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн. Акт, албан шаардлага, зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллалаа. (Хавсралт)

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын албанаас хийсэн аудитын хүрээнд

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн стратеги, бодлого, цаашдын үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрийн эрх зүйн үндэслэл оновчтой эсэхийг тодорхойлох, цаашид тус компанийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн, чиг үүргийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагын талаар дүгнэлт гаргахыг ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газарт даалгасан.

Энэ хүрээнд шаардлагатай бүх материал, баримт, мэдээллийг ТУЗ-ийн дэргэдэх ДАГ-т гарган өгч, нийт ажилтнууд асуулгад хамрагдан, хариу тайлбар өгч, нягт хамтран ажиллалаа. Тус аудитаас дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайланг 2025.05.13-ны өдөр ирүүлсэн бөгөөд үүний дагуу хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэн ажиллалаа. (Хавсралт 2-м)

ДОЛОО. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТАЙЛАН

Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөний зорилт бүрд холбогдох эрсдэлийн бүртгэл, үнэлгээ, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, нийт 7 зорилгын хүрээнд 49 эрсдэлийг бүртгэж, хариу арга хэмжээг төлөвлөн ажилласан. Үүнээс эрсдэлийн ангиллаар авч үзвэл санхүүгийн эрсдэл 10, үйл ажиллагааны эрсдэл 39 мөн магадлал нөлөөллөөр үнэлэн эрсдэлийн түвшинг тодорхойлсон бөгөөд бага – 4, дунд – 38, өндөр - 7 эрсдэл үнэлэгдсэн ба компанийн эрсдэлийн түвшин ДУНД түвшинд үнэлэгдсэн.

Тодорхойлсон эрсдэлийн хариу арга хэмжээний арга хэлбэрээр авч үзвэл эрсдэлээс зайлсхийх, арилгах 5 (10,4%), бууруулах 40 (81%), шилжүүлэх 1 (2,5%), хүлээн зөвшөөрөх 3 (6,1%)-аас үзэхэд нийт эрсдэлийн 91,4 хувийг хяналтад байлгаж зохих хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлсэн.

Эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр Төлөвлөгөөт ажлуудын уялдаа холбоог сайжруулж, "Эрдэнэс Монгол" нэгдлийн бодлоготой нийцүүлснээр өндөр түвшний 7 эрсдэл дунд түвшинд буурч, дунд түвшний 37 эрсдэлээс 27 эрсдэл бага түвшинд шилжиж, эрсдэлийн түвшин буурсан. Эрсдэлийн түвшин өссөн эрсдэл гараагүй болно. Мөн зарим эрсдэлүүдийн хувьд түвшин буураагүй ч эрсдэлийн түвшний тоон утга буурсан.

Мөн 2025 оны жилийн эцсийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтээр нийт 49 эрсдэлээс түвшин буурсан- 34 эрсдэл, бүрэн арилсан- 6 эрсдэл, өөрчлөлтгүй- 9 эрсдэлд хяналтын үнэлгээ хийж ажилласан.

Нэгдлийн эрсдэлийн удирдлагыг бодлогын баримт бичиг, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх жишиг аргачлалыг шинэчлэхтэй холбоотой уг баримт бичгийн төслүүдтэй танилцан санал боловсруулан хүргүүлэв.

2024 оны Эрсдэлийн удирдлагын тайланг боловсруулж, "Эрдэнэс Монгол" ХХК-д компанийн үйл ажиллагааны тайлангийн хамт хүргүүлсэн.

Нэгдлийн хэмжээнд олон улсын стандартад нийцсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангах зорилгоор хөгжүүлсэн "E-control" системийг хэрэгжүүлэх боломжийг судлах, нэгдлийн бүрэлдэхүүн компаниудын хамтран ажиллах Ажлын хэсэг-т компанийн төлөөллийг хамруулан ажилласан.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичиг, эрсдэлийн бүртгэл, үнэлгээ, тайланг дундын шэйрт фолдерт нээлттэй байрлуулж, мэргэжилтнүүдийн оролцоог ханган толгой компаниас баталсан жишиг маягтын дагуу эрсдэлийн бүртгэл, үнэлгээ, хариу арга хэмжээний төлөвлөгөө, тайланг боловсруулан цагалбарын дагуу толгой компанид тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Мөн "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ий 2026 оны бизнес төлөвлөгөөнд туссан 7 зорилгын хүрээнд 50 зорилтын учирч болзошгүй нийт 92 эрсдэлийг тодорхойлсон

бөгөөд эрсдэлийн ангиллаар авч үзвэл стратегийн эрсдэл 2, санхүүгийн эрсдэл 9, үйл ажиллагааны эрсдэл 69, БОНЗ эрсдэл 1, үйлдвэрлэлийн эрсдэл 5 тодорхойлогдсон.

(дэлгэрэнгүйг Хавсралт 3. Эрсдэлийн удирдлагын тайлан)

“ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
			/хувь/ Жилээр		
1. БИЗНЕСИЙН ӨСӨЛТИЙГ ЧУХАЛЧЛАН НЭГДЛИЙН ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ОЮУ ТОЛГОЙ ОРДЫН ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.					
1.1 Үйлдвэрлэлийн өртөг, зардлыг бууруулах	1.1.1 Үйлдвэрлэлийн өртөг, нэгжийн зардалд дүн шинжилгээ хийх Олон улсын ижил төстэй компаниудын үйлдвэрлэлийн зардлын судлан, зардал бууруулах чиглэлээр санал боловсруулан ОТ ХХК-д хүргүүлэх	Дүн шинжилгээний тайлангийн тоо	95%	Үйлдвэрлэлийн өртөг, нэгжийн зардалд сар бүр дүн шинжилгээ хийж сарын тайланд тусган ажиллаж байна.	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.
	1.1.2 Олон улсын ижил төстэй компаниудын бүтэц зохион байгуулалтыг ОТ ХХК-тай харьцуулан судалж, бүтцийг сайжруулах чиглэлээр санал боловсруулан ОТ ХХК-д хүргүүлэх	Дүн шинжилгээний тайлангийн тоо	80%	ОТ ХХК-ийн засаглал, бүтэц зохион байгуулалтын чиглэлээр хөндлөнгийн зөвлөх үйлчилгээний компани (Анкура)-г сонгон ажиллуулсан. Монголын талын байр суурийг илэрхийсэн саналыг хүргүүлж, зөвлөх компанийн хийсэн оношилгооны тайланд тусгуулж хамтран ажилласан. Мөн засаглал сайжруулах чиглэлээр Засгийн газрын ажлын хэсэгт холбогдох танилцуулга мэдээллээр ханган ажиллаж байгаа ба уг чиглэлээр Рио Тинто компанитай хэлэлцээр үргэлжилж байна.	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.
1.2 Хөрөнгийн удирдлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хянах, сайжруулах	1.2.1 Хөрөнгийн удирдлагын урт болон дунд хугацааны бодлого төлөвлөгөө боловсруулах, санал дүгнэлт гаргаж ОТ ХХК-д хүргүүлж, үр дүн хэрэгжилтэд хяналт тавих	Хөрөнгийн удирдлагын урт хугацааны бодлого, төлөвлөгөө боловсруулсан эсэх	90%	ОТ-н Хөрөнгийн удирдлагын багийн сар бүрийн тайланг авч танилцаж, уулзалтаар нэмэлт тодруулга мэдээллийг авч ажиллав. Хөрөнгийн удирдлагын чиглэлээр шинэ бүтэц бий болж, хөрөнгийн удирдлагын төвийг байгуулсан. Уг төв байгуулагдаж үндсэн чухал тоног төхөөрөмжүүдийн ажиллагаанд бодит цагийн хяналт хийснээр төлөвлөгдөөгүй засвар эвдрэл буурч, ашиглалтын бэлэн байдал нэмэгдсэн. Мөн хөрөнгийн удирдлагын урт хугацааны төлөвлөгөөг боловсруулж дууссан ба хяналтын шатанд байгаа энэ онд багтаан дуусгахаар байна.	ОТ ХХК-д хөрөнгийн удирдлага хариуцсан нэгж шинээр зохион байгуулагдсан бөгөөд урт, дунд хугацааны бодлого төлөвлөгөөг боловсруулж байна.
	1.2.2 Хөрөнгө оруулалтын зардалд сар бүр дүн шинжилгээ хийх	Дүн шинжилгээний тайлангийн тоо	90%	ОТ ХХК-аас ирүүлсэн хөрөнгө оруулалтын зардлын тайланд тухай бүрд дүн шинжилгээ хийж, хяналт тавин ажиллаж байна.	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.
	1.2.3 Хөрөнгө оруулалтын зардлыг олон улсын жишигтэй харьцуулах	Дүн шинжилгээний тайлангийн тоо	80%	ОТ-н далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт болон зардалд хөндлөнгийн аудит хийлгэх зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаварыг боловсруулан, АҮЭБС-ын А/29 тушаалаар батлагдсан ажлын хэсгээр батлан Рио Тинто компани руу хүргүүлсэн. Рио Тинто компаниас ирсэн хариуг хүлээн авч хариу албан бичгийг хүргүүлсэн.	ОТ-н далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт болон зардалд хөндлөнгийн аудит хийлгэх зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаварын саналыг Рио Тинто компанид хүргүүлсэн. Рио Тинто компаниас ирсэн хариуг хүлээн авч хариу албан бичгийг хүргүүлсэн.
1.3 ОТ ХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах	1.3.1 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулах, цаашид үр ашиггүй зардлыг бууруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх санал боловсруулах	Дүн шинжилгээ хийсэн тайлангийн тоо	100%	1. ОТ ХХК-ийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулсан. 2. Цаашид үр ашиггүй зардлыг бууруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох саналыг боловсруулж Ерөнхий сайдын 2025 оны 67, 68-р захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүд, түүнд дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсгүүдэд орж ажиллаж байна.	ОТ ХХК-ийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн төсөлд дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулсан.
1.4 Антре Гоулдын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас Монголын талын хүртэх өгөөж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр дагавар, эрсдэлийн тооцооллыг боловсруулж, хувилбаруудыг тодорхойлох	1.4.1 Холбогдох асуудлаар ажлын даалгавар боловсруулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус хөндлөнгийн зөвлөх үйлчилгээ авах, зөвлөх компанитай хамтран ажиллаж, эцсийн тайланг гаргуулах	Санал дүгнэлт гаргасан эсэх	80%	1. Антре гоулд (Онтрэ) ХХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар танилцуулга, мэдээлэл боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагуудад танилцуулсан. 2. АҮЭБЯ-ны ТНБД-ын 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/46 дугаар тушаалаар ажлын дэд хэсэг байгуулагдсан. Ажлын дэд хэсгийн хурлыг 4 удаа зохион байгуулж. "Онтрэ" ХХК-ийн эзэмшиж байгаа MV-015225, MV-015226 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайг ашиглах боломжит хувилбарууд (Үүнд: Засгийн газрын хувь эзэмшлийг тусгай АМНАТ-аар солих, ХөОГ-нд хамруулах эсэх болон өсөн нэмэгдэх АМНАТ ноогдуулах зэрэг)-ыг тодорхойлж, холбогдох санхүүгийн тооцооллыг хийж, давуу сул тал, эрсдэлийг тодорхойлж Дэд ажлын хэсгийн тайланг боловсруулж, гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулсан, холбогдох дээд шатны байгууллагуудад тайланг хүргүүлсэн. 3. Антре гоулд (Онтрэ)-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас Монголын талын хүртэх өгөөжийг Үндсэн хуулийн 6.2-д нийцүүлэн, боломжит хувилбаруудыг тодорхойлох, холбогдох санхүүгийн тооцооллыг хийж, санал боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулсан.	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.
	1.4.2 Антре Гоулд компанийн эзэмшиж байгаа MV-015225, MV-015226 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлүүд нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний хил заагийн талаарх дүгнэлтийг холбогдох байгууллагуудаас гаргуулах	Санал дүгнэлт гаргасан эсэх	100%	4. "Онтрэ" ХХК-ийн эзэмшиж байгаа MV-015225, MV-015226 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайг Оюу толгойн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулж түүний хил заагийн тогтоосон ЗГ-ын 170-р тогтоол 2025 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан. 5. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжийн 3 дахь заалтаар Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг, Дэд ажлын хэсгүүдтэй хамтран ажиллаж, Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудал, төлөвлөгөө, холбогдох танилцуулга, мэдээлэл боловсруулж, тухайн хурлын зохион байгуулалтыг хийж байна.	ЗГ-ын 170-р тогтоол 2025 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан.
	1.4.3 Антре Гоулдын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд далд уурхайн бүтээн байгуулалт, ашиглалт явуулахтай холбоотой хувилбаруудыг тодорхойлох, тэдгээрийн Монголын талын хүртэх өгөөжид хэрхэн нөлөөлөх асуудлаар санал боловсруулах, дэд ажлын хэсгийн хүрээнд хамтран ажиллах; - Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудал, төлөвлөгөө, холбогдох танилцуулга, мэдээлэл боловсруулах, тухайн хурлын зохион байгуулалтыг хийх	Санал дүгнэлт гаргасан эсэх	80%		Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.
	1.4.4 Ажлын дэд хэсгүүдийн саналуудыг нэгтгэн, Ажлын хэсгээр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулах, Засгийн газарт танилцуулан чиглэл авах	Санал дүгнэлт гаргасан эсэх	80%	1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг, түүнд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Дэд ажлын хэсгүүдтэй хамтран ажиллаж байна. "Онтрэ" ХХК-ийн эзэмшиж буй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас Монголын талын хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Дэд ажлын хэсгүүд батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
			/хувь/ Жилээр		
1.5 Хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах	1.5.1 ХНЗ-ийн үлдэгдлийг бууруулах үндэслэлийг гаргаж, ХНЗ-ийн хэмжээг бууруулах боломжит хувилбаруудыг боловсруулах; - ХНЗ-ийн зээлийн хүүг бууруулахад хэлтсийн чиг үүргийн дагуу мэргэжлийн дэмжлэг үзүүлэх	Боломжит хувилбаруудыг боловсруулсан эсэх	90%	1. ХНЗ-ийн үлдэгдэл, суурийг бууруулахтай холбоотойгоор ДУББСТ болон далд уурхайн зардлын хэтрэлт нь ХНЗ-ийн үлдэгдэлийг өсөхөд хэдий хэмжээгээр нөлөөлсөн талаарх санхүүгийн тооцооллыг хийж, ХНЗ-ийн үлдэгдэлийг бууруулах боломжит дүнг тооцож гаргасан, түүний хувьцаа эзэмшигчдийн өгөөж болон ОТ ХХК-ийн ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаарх санхүүгийн нөлөөллийг ОТ ХХК-ийн ТЭЗҮ2023 төслийн санхүүгийн загварчлалд үндэслэн тооцоолсон. 2. ХНЗ-ийн хүүгийн зохистой хувь хэмжээг тогтоох талаар нэмэлт судалгаа хийж, "ОТ" ХХК-ийн ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ЗОХИСТОЙ БАЙДЛЫГ ХЯНАН ҮЗЭХ, БУУРУУЛАХ, ШИНЭЧЛЭХ" товч мэдээлэлд ХНЗ-ийн хүүг бууруулснаар үзүүлэх эерэг нөлөөний талаар холбогдох тооцоолол, судалгааг хийж, санхүүгийн нөлөөг нэмж тусгав.	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.
	1.5.2 Ажлын хэсэг байгуулах - Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудал, төлөвлөгөө, холбогдох танилцуулга, мэдээлэл боловсруулах, тухайн хурлын зохион байгуулалтыг хийх	Ажлын хэсэг байгуулсан эсэх	90%	1). УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын хэрэгжилтийг хангуулахтай холбоотойгоор нэмэлт судалгаа хийж, Монгол Улсын ЕС-ын 67,68,73-р захирамжаар байгуулагдсан АХ-ийн нэгдсэн хуралд танилцуулах танилцуулга мэдээллийг бэлтгэж, хуралд оролцов. 2).МУ-ын ЕС-ын 2025.08.19-ны 67-р захирамжаар байгуулагдсан ОТ төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Сангийн сайдын тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгийн хүрээнд холбогдох суурь судалгаануудыг хийж, боломжит хувилбаруудыг тодорхойлж хувьцаа эзэмшигчдийн өгөөжид нөлөөлөх нөлөөлөл, дагалдах судалгааг хийж дэд ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	Хугацаа хоцорсон
	1.5.3 ХНЗ-ийн хүүг бууруулах ажлын даалгаврыг боловсруулж, Ажлын хэсгээр батлуулах	Ажлын даалгавар боловсруулсан эсэх	100%	1. "Оюу Толгой" ХХК-ийн Хувь Нийлүүлэгчдийн зээлийн /ХНЗ/-ийн хүүг бууруулах, шинэчлэх асуудлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хараат бус, хөндлөнгийн санхүүгийн зөвлөхүүдээр гүйцэтгүүлэх ажлын даалгаврын төслийг боловсруулсан. 2. "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын 1 дэх заалтын 2, 3, 4 дэх дэд заалтын хэрэгжилтийг хангах, "Оюу Толгой" ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах, шинэчлэх асуудлаар яриа хэлэлцээ хийх Ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.02.01-ний өдрийн А/29 тушаалаар байгуулж, тус "Ажлын хэсэг" нь хэрэгжүүлэх "Ажлын төлөвлөгөө"-г баталж, хэрэгжилтийг ханган ажилласан ба нийт 3 удаа хуралдаж, ХНЗ-ийн зохистой хувь хэмжээг тогтоох санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн ажлын даалгаврыг боловсруулан, баталж, эцсийн тайланг бэлтгэн холбогдох ажлын хэсгүүдэд хүргүүлээд байна.	Ажлын даалгавар боловсруулж, батлуулсан.
	1.5.4 ХНЗ-ийн хүүг бууруулах асуудлаар мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх ОУ-д хүлээн зөвшөөрөгдсөн зөвлөх компанийг сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээ авах	Гэрээ байгуулсан эсэх	100%	ХНЗ-ийн хүүгийн зохистой хувь хэмжээг тогтоохтой холбоотойгоор дотоодын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдийг судалж, холбогдох ажлын даалгаварыг боловсруулан гэрээг байгуулсан. Зөвлөхүүд гэрээний хүрээнд хийгдэх ажлуудаа эцэслэн хүргүүлж, гэрээ бүрэн хэрэгжиж дууссан.	Дотоодын зөвлөхүүдтэй гэрээ байгуулах ажил төлөвлөгөөний дагуу хэвийн явагдаж байна.
	1.5.5 ХНЗ-ийн хүүг бууруулах талаар зөвлөх компанийн тайланг Ажлын хэсэг, Засгийн газарт танилцуулж, хэлэлцээрийн бэлтгэл ажлыг хангах	Засгийн газрын шийдвэр гарсан эсэх	100%	1/ ОТ ХХК-ийн ХНЗ-ийн хүүгийн зохистой хувь хэмжээг тогтоох, хэлэлцээрт орох бэлтгэл ажлыг хангах хүрээнд суурь судалгаануудыг хийсэн; 2/ Боломжит хувилбаруудыг боловсруулж, холбогдох тооцоолол судалгааг хийгээд байна. Дотоодын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчтэй гэрээ хийж, гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан.	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.
	1.5.6 ХНЗ-ийн хүүг бууруулах асуудлаар хэлэлцээрт орж, НӨӨДТХНГ-нд холбогдох өөрчлөлтийг оруулах	Хэлэлцээрт орж, НӨӨДТХНГ-нд нэмэлт өөрчлөлт оруулсан эсэх	70%	Хэлэлцээрийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 1/ ОТ ХХК-ийн санхүүжилтийн хүүг бууруулах асуудлаар холбогдох суурь судалгаануудыг хийж гүйцэтгэсэн; 2/ Хэлэлцээрийн "Мэдэгдэл"-ийг 2025.04.10-нд Монголын талаас хүргүүлсэн, Хөрөнгө оруулагч талаас хариу "Мэдэгдэл"-ийг 2025.05.30-нд "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-д ирүүлсэн; 3/ Хэлэлцээ хийх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Рио Тинто компанитай 2025 оны 8 дугаар сарын 11, 13-ны өдрүүдэд "техникийн уулзалт"-ыг 2 удаа зохион байгуулж, хэлэлцээрийг ямар үе шаттай, хэдий хугацаанд, хэрхэн зохион байгуулах талаар харилцан санал солилцож нэгдсэн ойлголтод хүрснээ албажуулсан; 4/ Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67-р захирамжаар хэлэлцээ хийх эрх бүхий ажлын хэсэг байгуулагдсан. 5/ Хэлэлцээрт мэргэжлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын санхүүгийн зөвлөхүүдийг судалж, холбогдох ажлын даалгавар, төлөвлөгөөг боловсруулж, ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. 6/ 2025.10.30, 31-ний өдрүүдэд хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр эхэлсэн. Дотоодын зөвлөхүүдийн гэрээ дуусч, эцсийн тайланг ирүүлсэн ба тайланг холбогдох ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн. 8/ Суурь ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба хэлэлцээр үргэлжилж байна.	Хэлэлцээний бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
1.6 ОТ ХХК-ийн санхүүгийн загвар боловсруулж, харьцуулалт хийх замаар хяналтыг сайжруулах	1.6.1 ОТ ХХК-ийн богино хугацааны санхүүгийн загвар боловсруулж, харьцуулалт хийх замаар хяналтыг сайжруулах	Санхүүгийн загвар боловсруулсан эсэх	80%	ОТ төслийн ТЭЗҮ-ийн санхүүгийн загварчлалыг сайжруулах талаар ОТ төслийн санхүүгийн загвар хийдэг мэргэжилтэнтэй уулзалт хийж, богино хугацааны санхүүгийн загварчлалыг эхний байдлаар боловсруулаад байна.	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.
	1.6.2 ОТ ХХК-ийн урт хугацааны санхүүгийн загварт дүн шинжилгээ хийж хөрөнгө оруулагчдын хүртэх мөнгөн урсгалд хяналт тавих, сайжруулах хувилбаруудыг боловсруулах	Санхүүгийн хувилбарууд боловсруулсан эсэх	90%	Оюу толгой төслийн урт хугацааны санхүүгийн загвар боловсруулагдаж байгаа.	Загвар боловсруулагдаж ирснээр сайжруулах боломжит хувилбарууд хийгдэнэ.
1.7 ОТ ХХК-ийн 2025 төсвийн гүйцэтгэлийг хянах, 2026 оны төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх	1.7.1 ОТ ХХК-ийн 2025 төсвийн гүйцэтгэлийг хянах, 2026 оны төсвийн төсөлд санал өгөх	Санал дүгнэлт боловсруулсан эсэх	100%	1) 2025 оны 9 дүгээр сарын 16-17 өдрүүдэд ЭОТ ХХК-ийн төлөөллүүд уурхайн талбайд ажиллаж, 2025 оны уулын ажлын гүйцэтгэл, тулгамдаж буй асуудлуудтай газар дээр нь танилцав. Мөн ОТ ХХК-ийн ил уурхай, далд уурхай, баяжуулах үйлдвэрийн төлөвлөлтийн багуудтай уулзалт хийж болон 2026 оны уулын ажлын төлөвлөгөөний үзүүлэлтүүдтэй танилцаж, санал солилцов. 2) 2025 оны 10 дугаар сарын 15-17 өдрүүдэд ОТ ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал, 5 ерөнхий менежер, 29 менежер, болон ахлах инженерүүд оролцсон 3 өдрийн хурал хийсэн. Уг хурлаар 2026 оны зах зээлийн төлөв, орлого, алба хэлтсүүдийн ирэх оны төсвийн тооцооллын нийт 330 гаруй хуудас танилцуулга материалтай танилцсан. 3) Манай компанийн зүгээс ОТ ХХК руу нэмж тодруулах шаардлагатай 103 асуултыг хүргүүлэн хариу тайлбаруудыг авч удирдамжийн төсөл боловсруулав	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
			Жилээр		
1.8 ОТ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Хувьцаа эзэмшигчийн хуралд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх;	1.8.1 ОТ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн ээлжит, ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлуудын талаар Монголын талын төлөөллийн баримтлах "Удирдамжийн төсөл, Танилцуулга"-ын төсөл, хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлаар "Илтгэх хуудас" боловсруулж хүргэх	Холбогдох баримт бичгүүдийг боловсруулсан эсэх	100%	1) ОТ ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит хурал 4 удаа буюу 60, 61, 62, 63-р хурал болон ээлжит хурлын үргэлжлэл хурал, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 1 удаа хуралдаж, хэлэлцэх асуудлаар Танилцуулга, Удирдамжийн төслийг боловсруулж, толгой компани "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад хүргэж, "Удирдамж"-ийг батлуулан төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүдэд хүргэсэн. 2) Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүд батлагдсан "Удирдамж"-ийн дагуу хуралд оролцсон. 3) Хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар "Илтгэх хуудас"-ыг боловсруулж, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад хүргэсэн.	ОТ ХХК-ийн ТУЗ-ийн болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал төлөвлөсөн хугацааны дагуу хуралдсан.
ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ			90%		
2. БИЗНЕСИЙН ӨСӨЛТИЙГ ЧУХАЛЧЛАН НЭГДЛИЙН ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД УИХ-ЫН 2021 ОНЫ 103 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛНА.					
2.1 ДУББСТ, ДУББСНТ-н цуцалж хүчингүй болгосон шийдвэрийг хэрэгжүүлэх	2.1.1 Хөрөнгө оруулагч талууд нэгдсэн ойлголтод хүрэх	Нэгдсэн ойлголтод хүрсэн эсэх	100%	"Менежментийн үйлчилгээний гэрээ"-г шинэчлэх талаар гадаадын хөрөнгө оруулагч талтай уулзалт-ярилцлагын хүрээнд тохиролцоонд хүрсэн.	Оролцогч тал тус бүрд хүлээн зөвшөөрөгдөхүйц шийдлийг олохоор ажиллаж, олон талуудаас саналыг нэгтгэх, тал тус бүрийн саналыг тусгах нь ажлын явцыг удаашруулах хандлагатай байна.
	2.1.2 ДУББСТ, ДУББСНТ-г хуульд нийцүүлж цуцалж хүчингүй болсонтой холбоотой, үр дагаварын талаар хөндлөнгийн зөвлөхөөс санал дүгнэлт гаргуулах	Зөвлөх үйлчилгээний санал дүгнэлтийг хүлээн авсан эсэх	100%	ОТ ХХК ийн ТУЗ-ийн 2025 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 356 дугаар тогтоолын дагуу Менежментийн үйлчилгээний гэрээг шинэчлэх боломжийг эрэлхийлэх асуудлаар 1) ЭОТ, Рио Тинто, ОТ компанийн хамтарсан Ажлын хэсэг байгуулж, 2) МҮГ-ний өнөөгийн нөхцөл байдлын талаар оношилгооны тайланг хөдлөнгийн компаниар гаргуулахаар тогтсон. Энэ дагуу Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд нээлттэй сонгон шалгаруулалтаар МҮГ-ний талаар оношилгооны тайлан боловсруулах хөндлөнгийн компаниар Анкура шалгарсан. Анкура компани тайланг эцэслэн боловсруулж төслийг оролцогч талуудад буюу ОТ, ЭОТ, ЭМГЛ болон Рио Тинтогийн төлөөлөлд 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдөр танилцуулсан.	
	2.1.3 "Менежментийн үйлчилгээний гэрээ"-ний төслийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хөрөнгө оруулагч талтай хэлэлцэхтэй холбоотой жишиг гэрээнүүдийг судлан, санал дүгнэлт боловсруулах	Шинэчилсэн менежментийн үйлчилгээний гэрээний төслийг боловсруулсан эсэх	80%	ЭОТ ХХК-ийн зүгээс МҮГ-г шинэчлэх, сайжруулах, өөрчлөх чиглэлийн төслийг боловсруулсан бөгөөд "Эрдэнэс Монгол" ХХК болон бусад холбогдох яам болон газруудаас санал авахаар албан бичгүүдийг тус тус хүргүүлсэн. Ерөнхий сайдын 68 дугаар захирамжаар байгуулагдсан, АҮЭБ-ийн сайдаар ахлуулсан Ажлын хэсэг нь МҮГ-г шинэчлэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч тал буюу Рио Тинто компанийн төлөөлөлтэй албан ёсны эхний хэлэлцээг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр эхлүүлж, хэлэлцээ үргэлжилж байгаа ба талууд тохиролцоонд хүрээгүй байна. Хэлэлцээний бэлтгэл ажлын хүрээнд Анкура компанийн боловсруулсан тайлангаас олон улсын бэнчмарк мэдээллүүдийг боловсруулж, нэгтгэн Ажлын хэсгийн гишүүдэд эх сурвалж мэдээлэл болгон тараасан.	
	2.1.4 Рио Тинто баталгааны шимтгэлийг бууруулах, зогсоох боломжийг судлах	Бууруулсан эсэх	80%	1/ Рио Тинто баталгааны шимтгэлийг бууруулах, зогсоох талаар олон улсын туршлага судалж, холбогдох шийдэл, хувилбарыг боловсруулсан.	
2.2 ОТ-н далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт болон зардалд хөндлөнгийн аудит хийлгэх	2.2.1 Ажлын даалгаврыг эцэслэн боловсруулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус хөндлөнгийн зөвлөх үйлчилгээ авах асуудлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Санал хүргүүлсэн эсэх	90%	АҮЭБ-ын сайдын А/29 дүгээр тушаалаар батлагдсан Ажлын хэсэгт Ажлын даалгаврыг боловсуулан Рио Тинто компани руу хүргүүлсэн. Рио Тинто компаниас ирсэн хариуг хүлээн авч хариу албан бичгийн хүргүүлсэн.	Бусад оролцогч талын саналыг хүлээх нь ажлын явцыг удаашруулахад хүргэж байна.
2.3 ЭОТ ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх, ОТ ХХК-д хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдээс нэмэлт эзэлийн санхүүжилт авахгүй байх гэсэн заалтын агуулга дээр хөндлөнгийн зөвлөхийн дүгнэлт гаргуулах	2.3.1 Холбогдох асуудлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус хөндлөнгийн зөвлөх үйлчилгээ авч дүгнэлт гаргуулах	Дүгнэлт гаргуулсан эсэх	50%	1/ УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын 1.4 дэх заалтын хэрэгжилтийн хүрээнд "Хуулийн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төсөл"-ийг эхний байдлаар боловсруулсан.	
2.4 Татварын маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, цаашид сайжруулах боломжийг судлах	2.4.1 Лондоны олон улсын арбитрын шүүхэд үүссэн татварын маргаантай холбоотой Ажлын хэсгийг мэдээллээр хангах	Боломжит хувилбар, шийдлүүдийг боловсруулсан эсэх	100%	1/ Лондоны олон улсын арбитрын шүүхэд үүссэн татварын маргаантай холбоотой Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж буй ХЗДХЯ болон Хуулийн зөвлөх компанийг шаардлагатай мэдээллүүдээр цаг тухайд нь хангаж ажилласан. 2/ Татварын маргааны хүрээнд ХНЗ, ХНЗ-ийн хүүтэй холбоотой асуудлаар танилцуулга, санал дүгнэлт бэлтгэж, HSF зөвлөх компанитай тухайн асуудлаар хэлэлцсэн ба шаардлагатай бүхий л мэдээллээр хангаж ажилласан. 3/ Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 74 дүгээр захирамжаар шинэчлэн байгуулагдсан Ажлын хэсэгт шаардлагатай баримт бичиг, мэдээллийг хүргэж, холбогдох орчуулгын ажлыг гүйцэтгүүлж хүргэсэн. 4/ Лондоны олон улсын арбитрын шүүхэд үүссэн татварын маргаантай холбоотой 2025 оны 9 дүгээр сард болсон Лондоны арбитрын хуралд ЭОТ ХХК-ийн Гүйцэтгэх захирал болон Хууль эрх зүйн хэлтсийн менежер холбогдох төрийн төлөөллийн хамт оролцсон.	Төлөвлөгөөний дагуу үргэлжилж байна.
ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ			86%		
3. САНХҮҮ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАЖ ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛНЭ.					
3.1 ОТ ХХК-ийн сар бүрийн санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх	3.1.1 ОТ ХХК-ийн үйл ажиллагаа болон бүтээн байгуулалт, санхүү, татварын сар бүрийн тайланд дүн шинжилгээ хийж, хяналт тавьж хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх	Холбогдох мэдээлэл тооцооллыг гаргаж, санал дүгнэлт хүргүүлсэн эсэх	90%	1/ ОТ ХХК-ийн 2025 оны санхүү, үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, татвар, хураамж, төлбөрийн мэдээг судлан, байгууллагын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулсан дүн шинжилгээ сар бүр хийж хувьцаа эзэмшигчийн эрх үүргийн хүрээнд хяналт тавьсан. 2/ Борлуулалт, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардал, татвар төлөлт, санхүүжилтийн бүтэц зэрэг үндсэн чиглэлүүдэд үнэлгээ хийж хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлж, цаашдын шийдвэрт дэмжлэг болох санал, зөвлөмж боловсруулсан. 3/ ОТ ХХК-ийн сар бүрийн санхүү, татвар хөрөнгө оруулалтын тайланд /2025 оны 1-11 сарууд/ дүн шинжилгээ хийсэн.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.1.2 ОТ ХХК-ийн урт хугацааны санхүүгийн загвар шинэчлэгдэн ирэх бүрд төслийн ашигт ажиллагаа, төслөөс хөрөнгө оруулагчдын хүртэх мөнгөн урсгалд нөлөөлөх нөлөөллийн талаар шинжилгээ хийж, санал дүгнэлт боловсруулах	Санал дүгнэлт, тайлан боловсруулсан эсэх	95%	ОТ төслийн 5q1 (дотроо 4 дэд хувилбартай) уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн урт хугацааны санхүүгийн загвар шинэчлэгдэж ирсэн. Эдгээрийг өмнөх ТЭЗҮ2023 болон 3q3 хувилбаруудтай харьцуулан гол өөрчлөлт орсон хэсгийн нөлөөг харьцуулсан дүгнэлт гаргаж, хүргүүлсэн.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ /хувь/	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
			Жилээр		
	3.1.3 ОТ төслийн татварын мэдээллийг толгой компани болон бусад төрийн байгууллагууд руу явуулах	Холбогдох мэдээлэл тооцооллыг гаргаж, санал дүгнэлт хүргүүлсэн эсэх	100%	ОТ ХХК-ийн татвар төлөлтийн мэдээлэлд сар бүр дүн шинжилгээ хийж, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлсэн. ОТ ХХК-ийн татварын маргаантай холбоотой асуудлаар танилцуулга бэлтгэж Толгой компанид хүргүүлэв. Мөн ТЕГ-ын актууд, холбогдох тооцоолол, материалуудыг хүргүүлсэн.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.1.4 ТУЗ-ын хурал, төсвийн хурал, АСХ зэрэг хурлууд дээр татвартай холбоотойгоор Хувьцаа эзэмшигчийн зүгээс байр суурийг илэрхийлэх	Холбогдох дүн шинжилгээг хийсэн эсэх	100%	ТУЗ-ын хурал, АСХ зэрэг хурлууд дээр татвартай холбоотойгоор Хувьцаа эзэмшигчийн зүгээс байр суурийг илэрхийлж ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
3.2 Ил уурхайн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийг хянах	3.2.1 Ил уурхайн олборлолтын ажлыг ТЭЗҮ болон 2025 оны батлагдсан уулын төлөвлөгөөний гүйцэтгэлтэй уялдуулан хяналтыг хэрэгжүүлэх	Хяналтын тайлан боловсруулсан эсэх	100%	Ил уурхайн 2025 оны уулын ажлын төлөвлөгөөг тухайн сарын уулын ажлын төлөвлөгөөтэй харьцуулсан тайланг сар бүр боловсруулан ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.2.2 Уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зардал хэтэрсэн тохиолдолд хөрөнгийн удирдлагын төлөвлөгөөтэй уялдуулан хяналтыг хэрэгжүүлэх		100%	ОТ-н Хөрөнгийн удирдлагын уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэлийн сар бүрийн мэдээлэлтэй танилцан, санал дүгнэлт боловсруулан ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.2.3 Уурхайн талбайд ажиллаж, уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах		100%	ОТ уурхайн талбайд улирал бүр ажлын явцтай газар дээр нь танилцаж, хариуцсан ИТА-уудаас нэмэлт тодруулга мэдээллүүдыг авч ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
3.3 Хаягдал хадгалах байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг ТЭЗҮ болон 2025 оны батлагдсан уулын төлөвлөгөөний гүйцэтгэлтэй уялдуулан хяналтыг хэрэгжүүлэх	3.3.1 Хаягдал хадгалах байгууламжийн 2-р үүрийн бүтээн байгуулалтын ажлыг ТЭЗҮ болон 2025 оны батлагдсан уулын төлөвлөгөөний гүйцэтгэлтэй уялдуулан хяналтыг хэрэгжүүлэх	Хяналтын тайлан боловсруулсан эсэх	100%	Хаягдал хадгалах байгууламжийн 1-р үүрийн нөхөн сэргээлт, 2-р үүрийн ашиглалт, далангийн өндөрлөгөө, тайлан, мэдээллүүдийг сар бүр тогтмол авч танилцан, уурхайн талбайд газар дээр нь баталгаажуулан ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.3.2 Хаягдал хадгалах байгууламжийн 1-р үүрийн нөхөн сэргээлт, шүүрэлт болон бусад асуудлын талаарх төлөвлөгөө, тайлантай уялдуулан хяналтыг хэрэгжүүлэх		100%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.3.3 Хугацаа болон зардал хэтэрсэн тохиолдолд санал дүгнэлт боловсруулах		100%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
3.4 Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, хяналт тавих	3.4.1 Баяжуулах үйлдвэрийн боловсруулах хүдэр болон баяжмалын үзүүлэлтүүдийг ТЭЗҮ болон 2025 оны уулын ажлын төлөвлөгөөтэй харьцуулж хянах	Санал дүгнэлт, тайлан боловсруулах эсэх	100%	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны (хүдэр боловсруулалт, баяжмал үйлдвэрлэлт, металлын авалт) гүйцэтгэлийн тайланг сар бүр авч танилцан санал дүгнэлт боловсруулан ажиллаа. Мөн ИТА-уудтай сар бүр цахимаар болон уурхайн талбайд биечлэн уулзалт хийж тулгамдаж буй асуудлаар нэмэлт тодруулга, мэдээлэл авч ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.4.2 Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа болон өргөтгөлийн ажлын уялдааг хянах		100%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.4.3 Хугацаа болон зардал хэтэрсэн тохиолдолд санал дүгнэлт боловсруулах		50%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
3.5 Зэсийн баяжмалын лабораторийн хяналтыг сайжруулах	3.5.1 МУЗГ-ын 2013 оны 44-р тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих	Санал дүгнэлт, тайлан боловсруулах эсэх	80%	Манай компанийн зүгээс ОТ ХХК-иас баяжмалыг хүлээн авсан худалдан авагч буюу хайлуулах үйлдвэрүүд дахин дээж авч шинжилгээг хийдэг бөгөөд тус хариуг ГТЛ, RC inspection лабораториудын шинжилгээний хариунуудтай тогтмол харьцуулан дүн шинжилгээ хийж ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.5.2 Геологийн Судалгаа Шинжилгээний Төв нь бусад лабораториудын үр дүнг хүлээн авч, харьцуулан судалж, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх		80%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
3.6 ОТ Далд уурхайн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийг хянах	3.6.1 Далд уурхайн үйл ажиллагааг ТЭЗҮ болон 2025 оны уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хянах	Санал дүгнэлт, тайлан боловсруулах эсэх	100%	Далд уурхайн олборлолтын сар бүрийн уулын ажлын тайлан, малталт нэвтрэлтийн маркшейдерийн хэмжилтүүд, геотехникийн тайлан, нураан олборлолтын мониторингийн тайлангуудтай танилцаж, холбогдох асуудлаар сар бүр ОТ ХХК-ийн төлөвлөлтийн багийн инженер техникийн ажилтнуудтай цахим уулзалт хийж нэмэлт тодруулга, мэдээллүүд авч ажиллаж байна. Мөн Оюу толгойн уурхайн талбайд ажиллаж ажлын явцыг газар дээр нь хянан баталгаажуулж байна. Мэргэжлийн ур чадварыг сайжруулах чиглэлээр Рио Тинто компани болон Австрали улсын Күйнслэнд мужийн их сургуулийн хамтран зохион байгуулсан "Өмнийн говийн далд уурхайн институт"-д суралцаж төгсөв.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.6.2 Нураан олборлолтын тайлан, геотехникийн тайлантай танилцах, дүн шинжилгээ хийх		100%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.6.3 Уурхайн талбайд ажиллаж холбогдох чиглэлээр нэмэлт мэдээлэл тодруулга авах, холбогдох багуудтай хамтран ажиллах		100%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.6.4 Хугацаа болон зардал хэтэрсэн тохиолдолд санал дүгнэлт боловсруулж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх		100%	ОТ ДУ-н бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд сар бүр дүн шинжилгээ хийж, холбогдох мэдээллийг бэлтгэн ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
3.7 Оюу толгой төслийн уурхайн дэд бүтэц, үйлчилгээний багийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийг хянах	3.7.1 Механик засвар үйлчилгээ, өргөтгөлийн төсөл, цахилгааны болон кемп, сайтын үйлчилгээний багуудын тайлан мэдээтэй танилцаж, дүн шинжилгээ хийх	Санал дүгнэлт, тайлан боловсруулсан эсэх	90%	Холбогдох багуудын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлтэй танилцаж, дүн шинжилгээ хийж байна. Мөн сар бүрийн хуралд оролцон холбогдох мэдээллийг авч уурхайн талбайд томилолтоор ажиллахдаа хэрэгжүүлж буй төслүүдийн гүйцэтгэлийг хянан ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
3.8 Зэс, металлын зах зээл, маркетингийн судалгаа хийх	3.8.1 Зах зээлийн мэдээ, мэдээлэл, тоон мэдээлэлтэй танилцах, цуглуулах	Санал дүгнэлт, тайлан боловсруулсан эсэх	100%	Зэс, металлын зах зээлийн мэдээ мэдээлэлтэй танилцах, цуглуулах ажлыг тогтмол гүйцэтгэж ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.8.2 Мэргэжлийн судалгааны байгууллагуудын дата баазад хандах боломжит хувилбаруудыг судлах, тооцоолол гаргах		98%	Мэргэжлийн судалгааны байгууллагуудын дата баазад хандах боломжит хувилбаруудыг судалж тооцоолол гаргасан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.8.3 Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулах, тайлан төлөвлөгөөнд тусгах		90%	ОТ ХХК-иас ирүүлдэг тоон мэдээллүүдэд тогтмол дүн шинжилгээ хийж байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.8.4 Маркетинг болон борлуулалтын стратеги асуудлаар судалгаа хийж, санал дүгнэлт боловсруулах		100%	Зэсийн баяжмалын борлуулалтын талаар танилцуулга хийж гүйцэтгэх захиралд танилцуулсан. Борлуулалтын хүрээг ОТ ХХК-ийн ТУЗ-өөр батлахад санал дүгнэлт гарган ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.8.5 Зэсийн баяжмалыг биржээр арилжаалах асуудлыг судлах		100%	Зэсийн баяжмалыг Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр борлуулахтай холбоотой судалгаа хийж, танилцуулга боловсруулсан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
3.9 Далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын хуваарь, зардлыг хянах, холбогдох байгууллагуудтай хамтран	3.9.1 Далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын сар бүрийн тайлан, 7 хоног тутмын явцын мэдээлэл, гүйцэтгэлийн мэдээллүүдэд дүн шинжилгээ хийх, хариуцсан багтай уулзалт хийж холбогдох асуудлаар нэмэлт тодруулга, мэдээлэл авах, санал дүгнэлт боловсруулах	Санал дүгнэлт, тайлан боловсруулсан эсэх	100%	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын төслийн сар бүрийн тайлан, гүйцэтгэлийн мэдээлэл, 7 хоног тутмын тайлан, эрсдлийн бүртгэл болон зардлын мэдээллүүдтэй танилцаж санал дүгнэлт боловсруулан ажиллаж байна. Мөн улирал тутам төслийн талбайд ажиллаж далд уурхайн бүтээн байгуулалт, барилга угсралтын ажлуудтай газар дээр нь	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.9.2 Уурхайн талбайд ажиллаж бүтээн байгуулалтын ажлуудтай газар дээр нь танилцах	Томилолтын тайлан	100%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ /хувь/	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
			Жилээр		
ажиллах	3.9.3 Хугацаа болон зардал хэтэрсэн тохиолдолд санал дүгнэлт боловсруулж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Санал дүгнэлт, тайлан боловсруулсан эсэх	100%	танилцаж, холоогдох мэргэжилтнүүдээс ажлын явц, тулгамдаж байгаа асуудлаар тодруулга, мэдээлэл авч ажиллав.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.9.4 ОТ Далд уурхайг улсын комисст хүлээлгэн өгөхөд дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах		100%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
3.10 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд хяналт тавих	3.10.1 ХАБЭА-ын сар бүрийн тайлан, 7 хоног тутмын явцын мэдээллүүдэд дүн шинжилгээ хийх, хариуцсан багтай уулзалт хийж холбогдох асуудлаар нэмэлт тодруулга, мэдээлэл авах, уурхайн талбайд ажиллаж хяналт тавих	Санал Дүгнэлт, Тайлан боловсруулсан эсэх	100%	ХАБЭА-ын сар бүрийн тайлан, явцын мэдээллүүдэд дүн шинжилгээ хийх, хариуцсан багтай уулзалт хийж холбогдох асуудлаар нэмэлт тодруулга, мэдээлэл авах, уурхайн талбайд ажилллаж байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.10.2 ХАБЭА үйл ажиллагаанд хяналтын хэрэгжүүлж, сайжруулалт хийхэд санал дүгнэлт боловсруулах, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах		100%	ХАБЭА-ын сар бүрийн тайлан, явцын мэдээллүүдэдтэй танилцаж, төслийн талбайд очиж ажилласан ба үйл ажиллагаанд нөлөөлөх ноцтой осол бүргэгдээгүй хэвийн ажиллаж байгаа учир санал дүгнэлт боловсруулагдаагүй.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
3.11 Оюу толгой төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих	3.11.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон хэрэгжилтийн тайланд хяналт тавих	Тайлан боловсруулсан эсэх	100%	ОТ ХХК нь 2022 оны "Оюу толгойн ордоос зэс-алт олборлох, боловсруулах" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланд үндэслэн 2025 оны БОМТ-г боловсруулан БОАЖЯ-аар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгаль орчны асуудлаар тухай бүр уулзалтыг зохион байгуулан мэдээ мэдээлэл авч, санал дүгнэлт гарган ажиллаж байна. 2025 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардалд жил бүр 1,955,000,000₮ төсөвлөсөн байна. ОТ-н байгаль орчны барьцаа хөрөнгө, ус бохирдуулсны төлбөр, улсын нэгдсэн сүлжээнд усны нэмэлт цооног холбох, тодорхой давтамжтай хийгддэг аудитын тайлангууд зэрэгтэй холбогдох асуудлаар ЗГ-ын хэрэг эрхлэх газар, ажлын хэсгүүд, БОУАӨЯ зэрэг төрийн байгууллагуудад мэдээлэл хүргүүлэн ажиллав. ОТ ХХК нь 2025 оны БОМТ-ний биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Өмнөговь аймгийн Байгаль орчны газарт танилцуулан биелэлтийг хүлээлгэн өгсөн.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.11.2 Оюу Толгой төслийн зээлдүүлэгч олон улсын байгууллагад өгч буй байгаль орчны тайлантай танилцах, харьцуулалт хийх	Тайлан боловсруулсан эсэх	100%	Оюу Толгой ХХК нь жилд 1-2 удаа Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөх (БОНХЗ)-ийн байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны аудит, 2 жил тутам дотоодын байгаль орчны нийцлийн аудитыг гүйцэтгүүлж байна. БОНХЗ нь ОТ-н Зээлдүүлэгчдийн бүх шаардлагыг хангах зорилгод чиглэл өгөх үүднээс илэрсэн зөрчлийг арилгах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж өгдөг бол Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу 2 жил тутам хийгддэг дотоодын аудит нь Монгол улсын хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгааг үндэслэн байгаль орчны нийцлийн аудитыг гүйцэтгэдэг. Манай компанийн зүгээс БОНХЗ-ийн тайланг ирүүлэх тухай хүсэлтийг хүргүүлж 2024, 2025 онд гүйцэтгэсэн тайлангуудыг хүлээн авч танилцан дүн шинжилгээг хийж ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.11.3 "Гүний хоолойн газрын доорх усны орд"-ын нөөцийг дахин үнэлэх ажлын гүйцэтгэлийн явцын талаарх мэдээллийг тухай бүр авч, тайлан боловсруулах	Тайлан боловсруулсан эсэх	100%	УИХ-ын "Оюу Толгой ордын ашиглалтад Монгол улсын эрх ашгийг хангуулах тухай" 92-р тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн зүгээс ОТ ХХК-д Гүний хоолойн газрын доорх ус ашиглалтын үеийн нөөцийг дахин үнэлэх ажлыг гүйцэтгэх талаар санал хүргүүлж тухайн жилийн төсөвт тусгуулсан. Үүний дагуу тус ажлыг гүйцэтгэх ажлын даалгаварт олон улсын хөндлөнгийн зөвлөхтэй хамтрах, олон улмад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар усны нөөцийг үнэлэх тухай саналыг хүргүүлсэн. ОТ ХХК нь 2023 онд холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийг шалгаруулж тус ажлыг эхлүүлсэн. 2023 оны 8 дугаар сараас хээрийн судалгаа, геофизик, шинээр цооног өрөмдөх зэрэг ажлууд хийгдэж эхэлсэн бөгөөд тус ажлын товч танилцуулгыг 09 дүгээр сарын 20-ны өдөр ОТ-н байгаль орчны хэлтсээс танилцуулсан. Одоогоор эцсийн шатны тайланг боловсруулан 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Усны газарт хүлээлгэн өгөөд байна. Усны газраас шинжээчдийг томилон тайланг авч хэлэлцэх, батлуулах ажил хүлээгдэж байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.11.4 Оюу Толгой төслийн ус ашиглалтын сар бүрийн тайланг боловсруулж ажиллах	Тайлан боловсруулсан эсэх	100%	ОТ уурхайн ус ашиглалтын тайлан мэдээг сар тутам хүлээн авч танилцаж байна. Уурхайн ус ашиглалтын байдал өмнөх онуудтай ойролцоо байгаа ба энэ оны 11 дүгээр сарын байдлаар ОТ ХХК нь ус ашигласны төлбөрт нийт 24.8 тэрбум төгрөгийг Монгол Улсын төсөвт төвлөрүүлээд байна. Мөн Гүний хоолойн газрын доорх усны ордоос нийт 15.3 сая.м3 буюу 518 л/с ус ашигласан байна. Оюу Толгой уурхайн цогцолборын хэмжээнд ерөнхий дүнгээр авч үзвэл нийт ашигласан усны 86% -ийг дахин ашиглаж, 1 тн хүдэр боловсруулахад дунджаар 402 литр усыг нөхөн сэлбэлтээр авч ашигласан байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.11.5 Хүрээлэн буй орчинд нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах 3.11.5.1 Агаарын чанарын үзүүлэлт, хог хаягдлын тайлантай танилцаж, хянах	Тайлан боловсруулсан эсэх	100%	Оюу Толгой уурхайн 2022 оны Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлээнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. ОТ төслийн 2025 оны БОМТ-нд хүрээлэн буй орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр нийт 47 арга хэмжээн авч хэрэгжүүлсэн. Үүнээс агаарын чанарт 19, Газар хөрсөн бүрхэвч 7, Усны нөөц 14, Ургамалан нөмрөг 3, Амьтны аймаг 8 арга хэмээг авч хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах зорилгоор цахилгаан тээврийн туршилтууд, уур амьсгалын өөрчлөлтийн судалгааны ажлууд хийгдэж байна. Агаарын чанарт нөлөөлж буй сөрөг нөлөөллийг багасгах үүднээс замын усалгаа, хүнд машин механизмын засвар, Дулааны цахилгаан станцын шүүдлтүүрийг солих зэрэг ажлуудыг хуваарийг дагуу тогтмол хийж байна. Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны хүрээнд 5 зорилтыг дэвшүүлж 100% хэрэгжүүлсэн. 2025 онд нийт 20.9 мян.тн хог хаягдал үүссэнээс 68%-ийг дахин боловсруулж, 20.7%-ийг ландфиллд булшилсан байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.11.6 Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Тайлан боловсруулсан эсэх	100%	ОТ нь 2010-2024 оны хугацаанд нийт 1,865.88 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж, үүнээс 662.11 га талбайд нь биологийн шатны ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. 2025 оны хувьд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг ОТ-ТТ чиглэлийн хатуу хучилттай замын барилгын үед ашиглагдсан шороон ордууд, үйлдвэр, оффисын талбай, барилгын үед ашигласан түр зам болон 200м тутмын гарцууд зэрэг нийт 50 га талбайд хийхээр төлөвлөсөн бөгөөд 118.18 га талбайд, Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг Оюу толгой - Гашуун сухайт чиглэлийн хатуу хучилттай замын барилгын ажилд ашигласан шороон орд буюу нийт 30 га талбайд хийхээр төлөвлөсөн бөгөөд 65.06 га талбайд хийж гүйцэтгэсэн давуу гүйцэтгэлтэй байна. Дүйцүүлэн хамгаалах зорилтын хүрээнд Хулан, хар сүүлтийн тоо толгойд үзүүлэх үлдэгдэл сөрөг нөлөөллийг бууруулах "Хууль бус антай тэмцэх" төсөл, Оюу толгой - Манлайн замын дагууд хөндөгдсөн талбайг дүйцүүлэн хамгаалах Байгалийн ургамлын тарьц суулгац ашиглан бэлчээр сайжруулах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
			/хувь/ Жилээр		
	3.11.7 Биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, газар дээр нь очиж бодит байдалтай танилцаж, хяналт тавьж ажиллах	Тайлан боловсруулсан эсэх	100%	Оюу толгой уурхай нь өмнийн говийн биологийн олон янз байдалд эерэг ахиу нөлөө үзүүлэх, үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалтайгаар багасгахыг зорин ажилладаг. Энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа нэн түрүүнд тэрхүү нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгдэнэ. Үйл ажиллагааны улмаас үүссэн үлдэгдэл нөлөөлөлд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авч ажиллаж байна. Ургамлын аймаг, ургамалжилт, амьтны аймгийн хяналт шинжилгээний хөтөлбрийг тогтмол хэрэгжүүлэн ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.11.8 Газарзүйн мэдээллийн систем ArcGIS программ ашиглан Оюу Толгой төслийн Байгаль орчны тайлан мэдээлэлд харьцуулалт хийж, бодит хяналт тавьж, санал дүгнэлт боловсруулах	Тайлан боловсруулсан эсэх	100%	Газарзүйн мэдээллийн систем ArcGIS сургалтад хамрагдлаа. Мөн ОТ төслийн талбайд 2025 оны 06 дугаар сард очиж ажиллах үеэр ОТ-н байгаль орчны багийн газарзүйн мэдээллийн систем хариуцсан мэргэжилтэнтэй уулзалт зохион байгуулан ерөнхий мэдээллийг авч ажиллав. ОТ ХХК нь тус ажилтай холбоотой программд төлбөр төлж лицензийг эзэмшин ажиллаж байна. Цаашид газарзүйн мэдээллийн сангаас тухай бүр мэдээллийг хуваалцан ажиллахаар төлөвлөж байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.11.9 Төрийн болон орон нутгийн байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Тайлан боловсруулсан эсэх	100%	БОУАӨЯ, Эдийн Засгийн Байнгын Хороо, Эрдэнэс Монгол, Усны газар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, ОТ-н байгаль орчны асуудал, Хэрлэн Тооно төслийн явцын тайлан, танилцуулга мэдээг тухай бүр өгч уулзалтуудыг зохион байгуулан ажиллав. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ОТ уурхайтай танилцахтай холбогдуулан "Оюу Толгой" ХХК-ийн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэж буй "Нэг зуун сая мод" хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг бэлтгэн Ерөнхийлөгчийн Тамгын Газарт хүргүүлэв. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар "Цэнхэр алт" үндэсний хоёрдугаар чуулган 03 сарын 21-ний өдөр "Мөстөл, мөсөн голоо хамгаалъя" уриан дор Төрийн ордонд зохион байгуулагдсан бөгөөд тус чуулганд амжилттай оролцсон. МУУҮА-ийн газраас хариуцлагатай уул уурхайн хүрээнд хийгдсэн сургалтад хамрагдлаа. Түүнчлэн Шинжлэх ухааны академийн Газарзүй, геозкологийн хүрээлэнтэй Говийн бүсийн усны чанарын судалгааны ажлын даалгавар эхний байдлаар боловсруулахад хамтран ажиллаа.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	3.11.10 Оюу толгой уурхайн талбарт тогтмол давтамжтай очиж ажиллах байгаль орчны ажлын явцтай танилцаж, газар дээр нь хяналт тавьж ажиллах	Тайлан боловсруулсан эсэх	100%	2025 онд ОТ төслийн талбайд улирал тутам очиж ажиллахаар төлөвлөөгөө гарган биелэлтийг ханган ажилласан бөгөөд ОТ төслийн талбайд очиж ажиллахдаа уурхайн хаягдлын удирдлагын төв, ойролцоох малчдын худгийн түвшинг хэмжих, агаарын чанарын станц болон салхины хурд хэмжигч станцын үйл ажиллаатай газар дээр нь очиж танилцах, байгаль орчны холбогдох асуудлуудаар байгаль орчны багтай уулзалтыг зохион байгуулан ажиллав.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ			97%		
4. БИЗНЕСИЙН ӨСӨЛТИЙГ ЧУХАЛЧЛАН НЭГДЛИЙН ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ӨСӨЛТ ХӨГЖЛИЙГ ЦОГЦЛООНО.					
4.1 Оюу толгойн нуруулдан уусгах аргаар ашиглах нөөцийн тооцооны тайлан, УТЭЗҮ-г ЭБМЗ-д хүлээлгэн өгөх	4.1.1 Нуруулдан уусгах аргаар ашиглах нөөцийн тооцооны тайлан, УТЭЗҮ-г ЭБМЗ-д хүлээлгэн өгөх асуудлаар төрийн байгууллагууд болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллах	УТЭЗҮ хүлээлгэн өгсөн эсэх	100%	Рио Тинто компани Оюу толгойн Оюутын ордыг ил аргаар ашиглахад олборлон хураасан исэлдсэн хүдэр болон Төв оюутын ордоос гарах хоёрдогч баяжилтын бүсийн сульфидын хүдрийг бактериар үйлчилж, нуруулдан уусгах замаар катодын зэс үйлдвэрлэх Урьдчилсан техник-эдийн засгийн үнэлгээ (УТЭЗҮ)-г боловсруулсан. Уг УТЭЗҮ-г хүлээн авч Эрдэнэс Монгол нэгдлийн Техник технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан.	ОТ ордыг түшиглэн барих төсөл УТЭЗҮ-ийн одоогийн хувилбараар ашиггүй гарсан бөгөөд зардал бууруулах боломжуудыг судалж байна.
4.2 Оюу толгой ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн судалгааг боловсруулах	4.2.1 Рио Тинто компанийн боловсруулж буй катодын зэс үйлдвэрлэх хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн судалгаануудтай танилцаж, дүн шинжилгээ хийх	Тайлан боловсруулсан эсэх	80%	"Рио Тинто Монгол" ХХК дээр манай компани болон "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөллийг оролцуулан хамтарсан уулзалт зохион байгуулсан. Рио Тинто компанийн зүгээс уг судалгааг боловсруулж байгаа бөгөөд уг төслийг хэрэгжүүлэхэд дагалдах үйлдвэр, дэд бүтцүүдийг барьж байгуулах, хайлуулах цэвэршүүлэх олон улсын жишиг зардал маш бага байгаа зэргээс шалтгаалж эдийн засгийн үр ашиггүй байгаа талаар мэдээлсэн.	
	4.2.2 Холбогдох асуудлаар МУЗГ, Яамдууд, Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс УТП, Эрдэнэт ТӨҮГ болон бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллах		80%		
4.3 Баяжмалын экспортын логистиктой холбоотой цар хүрээг нэмэгдүүлэх	4.3.1 Оюу Толгой ХХК-иас ирүүлж буй баяжмал тээврийн тайлан мэдээллийг судалж, боловсруулалт хийх	Сар бүрийн тайлан	100%	Баяжмалын тээвэр логистиктой холбоотой сарын тайланг боловсруулсан бөгөөд тус тайланг боловсруулахад шаардлагатай баяжмалын тээвэр логистиктой холбоотой мэдээллүүдийг хүлээн авч танилцаж, нэгтгэн боловсруулах ажлыг гүйцэтгэв. ОТ ХХК нь 2025 оны 11 дүгээр сард 132.7 мянган тонн баяжмалыг Гашуунсухайт-Ганцмод боомтоор тээвэрлэсэн бол тус хугацаанд 145.5 мянган тонн баяжмалыг худалдаалсан байна.	Төлөвлөгөөний дагуу хийгдэж сар бүрийн тайлан бэлтгэгдсэн
	4.3.2 Ганцмод боомтоор нэвтрүүлэх баяжмал тээврийг тусгайлсан гарцтай болгох	Санал дүгнэлт боловсруулсан эсэх	100%	2025 оны 9-р сарын 11-ний өдөр Гашуунсухайт хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж буй талаар Хилийн боомтын захиргаа болон Эрдэнэс Монгол ХХК-ийн Дэд бүтэц, Логистикийн групп хамтарсан уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтын хүрээнд Ганцмод боомтоор нэвтрүүлэх баяжмал тээврийг тусгайлсан гарцтай болгох асуудлаар холбогдох саналыг Дэд бүтэц, логистикийн групп-д хүргүүлсэн.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
4.4 Оюу Толгойг дотоодын эрчим хүчээр хангах	4.4.1 Оюу Толгой ХХК-иас ирүүлж буй эрчим хүчний тайлан мэдээллийг судалж, боловсруулалт хийх	Сар бүрийн тайлан	100%	Эрчим хүчтэй холбоотой сарын холбоотой сарын тайланг боловсруулсан бөгөөд тус тайланг боловсруулахад шаардлагатай эрчим хүчний хэрэглээ, төлбөр зэрэг мэдээллүүдийг хүлээн авч танилцаж, нэгтгэн боловсруулах ажлыг гүйцэтгэв. ОТ ХХК нь 2025 оны 11-р сард ӨМЭХК-иас импортоор 149.611 МВт.ц эрчим хүч, холбогдох төлбөрт 12.44 сая ам.долларыг төлөөд байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	4.4.2 Монгол Улсын нэгдсэн сүлжээнээс Оюу Толгойг эрчим хүчээр хангах (ТТДЦС ТӨХХК) чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах	Санал дүгнэлт боловсруулсан эсэх	90%	2025 оны 1-р сарын 30-ний өдөр Эрчим хүчний яам болон манай компанийн төлөөллүүд оролцсон уулзалт зохион байгуулж, Оюу Толгой ХХК-ийн эрчим хүчний гэрээ хэлэлцээр, нөхцөл байдал, тариф бууруулах боломжтой эсэх, Тавантолгой дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалт болон сэргээгдэх эрчим хүчний чадлын тохируулгын тариф зэрэг асуудлаар санал солилцлоо.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	4.4.3 Оюу Толгойг дотоодын сэргээгдэх эрчим хүчээр хангах (СЭХ Билгэх төсөл) чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Санал дүгнэлт боловсруулсан эсэх	100%	2025 оны 11-р сарын Оюу Толгой ХХК-ийн ТУЗ-ийн хурлаар Сэргээгдэх эрчим хүч худалдан авах гэрээний үндсэн нөхцөлийг танилцуулсан бөгөөд худалдан авах гэрээг 2026 оны 1-р улиралд танилцуулахаар холбогдох бэлтгэл ажлын ханган ажиллаж байна. 2025 оны 11-р сарын ОТ ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит 63-р хуралд хуралд танилцуулга мэдээлэл боловсруулан ажилласан.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
			/хувь/ Жилээр		
4.5 БОНЗ-ын гэрээний дагуу хийгдэх ажлуудыг тодорхой болгох, гэрээг байгуулж хэрэгжүүлэх	4.5.1 ОТ төслийн мэдээллүүдийг харьцуулан гаргаж, цахимжуулах ажлуудын цар хүрээг тодорхойлж, зохион байгуулж ажиллах (бенчмаркинг арга, мэдээлэл солилцох)	Ажлын даалгавар боловсруулах Цахим мэдээллийн санг үүсгэсэн эсэх	60%	"Мэдээлэл солилцох цахим мэдээллийн платформ үүсгэх" төслийн ажлын тодорхойлолт болон мэдээлэл технологийн зөвлөхийн гүйцэтгэх ажлын цар хүрээг тодорхойлж боловсруулсан ба ОТ ХХК-тай гэрээ байгуулагдахыг хүлээж байна. Гэрээ байгуулагдсаны дараа дараагийн тендер зарлах болон судалгаа харьцуулалтын ажлууд хийгдэж эхлэх болно.	ОТ ХХК-тай гэрээ хийж санамж бичиг байгуулахад удаашралтай байгаа учир төлөвлөгөөнөөс хоцрогдолтой явж байна.
	4.5.2 Оюу Толгойн баяжмалын тээвэрлэлт, логикийн цар хүрээг нэмэгдүүлэх	Ажлын даалгавар боловсруулах	90%	Оюу Толгойн баяжмалын тээвэрлэлт, логикийн цар хүрээг нэмэгдүүлэх судалгааны ажлын тодорхойлолтыг боловсруулан ОТ ХХК-д хүргүүлсэн бөгөөд гэрээ байгуулах ажил хүлээгдэж байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	4.5.3 Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогыг уялдуулах, өмнийн говийн бүсийн газрын гадаргын болон газар доорх усны нөөцийн судалгааны цогц арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөгжлийн стратеги төлөвлөгөө, зөвлөл шинэчлэгдсэн эсэх	75%	БОНЗ-ын Түншлэлийн гэрээний дагуу Өмнийн говийн бүсийн усны чанарын судалгаа болон газрын доорх усны нөөцийн судалгааг хийх ажлын тодорхойлолт, даалгавруудыг боловсруулан ажилласан. Өмнийн говийн бүсийн усны чанарын судалгааны ажлын даалгавар боловсруулахдаа шинжлэх ухаан технологийн хүрээлэнгийн газарзүй, геоэкологийн хүрээлэнгээс санал авч тусгаад байна. Ажлын тодорхойлолтыг ОТ ХХК-д хүргүүлэн санал авч англи, монгол хувилбарыг эцэслэн баталгаажуулах шатандаа явагдаж байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
4.6 Хэрлэн-Тооно төслийн хэрэгжилтийг хангах	4.6.1 Хэрлэн-Тооно төслийн ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах ажлын гэрээт гүйцэтгэгчийн ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, хээрийн судалгааны ажилтай газар дээр нь очиж танилцах, хяналт тавих	Хяналтын тайлан боловсруулсан эсэх	100%	Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийг тэлэх 14 мега төслийн нэг болох "Хэрлэн Тоонот" усан цогцолборын ТЭЗҮ-ийн нэмэлт тодотгол боловсруулах ажлыг "Оюу Толгой" ХХК санхүүжүүлэн, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК нь гүйцэтгэгчийг холбогдох хууль журмын дагуу сонгон шалгаруулж, "Монхидроконстракшн" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Хэрлэн Тоонот төслийн ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд олон зориулалттай усан цогцолборын боомт, усан сан үүсэх талбайд хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэн, суурин боловсруулалтын ажлыг эхлүүлсэн. Үүнтэй холбоотой Хэрлэн гол дээр байгуулах олон зориулалттай усан цогцолборын усан сан үүсгэх талбай, ус дамжуулах шугам хоолойн урьдчилсан трассын схем зурагт санал авах тухай албан бичгийг холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлсний дагуу ирүүлсэн саналыг тусгаж, боловсруулан трассыг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан Усны газар, БОУАБЯ-ны төлөөлөл болон төслийн нэгжид 09 дүгээр сарын 22-ны өдөр танилцуулсан. Тус хурлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах чиглэлийг гүйцэтгэгч компанид хүргүүлэн, хариу товч тайлан, албан бичгүүдийг Усны газарт хүргүүлсэн. Төслийн талбайд 2025 оны байдлаар нийт 6 удаа очиж танилцсан бөгөөд 05 дугаар сарын 15-нд ЭМГЛ ХХК-ийн төлөөллүүдтэй хамт очиж ажилласан. Түүнчлэн тус төслийг таниулах, орон нутгийн иргэдэд үнэн зөв, бодит мэдээ мэдээллийг хүргэх үүднээс Хэрлэн Тооно төслийн биет макет болон богино хэмжээний видео шторкуудыг гүйцэтгүүлэн Дэлгэрхаан сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн. Мөн төслийн явцыг тухай бүр том ажлын хэсэг, толгой компанид танилцуулан уулзалтыг зохион байгуулж санал авч, тусган дараагийн ажлуудыг төлөвлөн хамтран ажиллаж байна. Хэрлэн Тооно төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэх, тодотгол боловсруулах ажлын явц хуваарийн дагуу явагдаж байгаа бөгөөд тус төслийн тайланг эцсийн байдлаар 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр боловсруулж дуусна. Үүний дараагаар тус тайланг БОУАӨЯ-ний Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, ТЭЗҮ-н шатны зураг төсөлд улсын магадлал хийлгэх, ЭХЯ болон БХББОСЯ-ны дэргэдэх шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хянан баталгаажуулах ажлуудыг төлөвлөөд байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	4.6.2 Хэрлэн-Тооно төслийн БОНУ боловсруулах ажлыг судалж, зохион байгуулалтыг хангах, Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, БОНУ-ийн ажлын даалгавар боловсруулах, батлуулах	Ажлын даалгаварт санал дүгнэлт боловсруулах	100%	Хэрлэн-Тооно төслийн ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах ажлын дараа БОНУ-ийн ажлын даалгавар боловсруулах судалгааны ажлыг эхлүүлнэ. Энэхүү ажлыг 2026 онд төлөвлөн гүйцэтгэхээр байна.	
ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ			90%		
5. САЙН ЗАСАГЛАЛ, ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЗАРЧМУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ОТ КОМПАНИЙН ӨНӨӨГИЙН ЗАСАГЛАЛД ҮНЭЛГЭЭ ХИЙН, ГҮЙЦЭТГЭЛ, ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭ АВЧ ХЭРЭГЖҮҮЛНЭ					
5.1 "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн засаглалыг сайжруулах	5.1.1 ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын бүтцийн шинэчлэл хийхэд санал дүгнэлт боловсруулах, хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах	ОТ удирдлагад хүргүүлсэн санал, дүгнэлт	80%	ОТ ХХК-ийн ТУЗ-ийн засаглалыг сайжруулах, үнэлэлт дүгнэлт өгөх хүрээнд хөндлөнгийн зөвлөх үйлчилгээний Анкура консалтинг компанитай ОТ ХХК гэрээ байгуулан ажиллаж байгаа. Анкура консалтинг компани (Ankura Consulting Group, LLC) нь 2024 оны 11 дүгээр сард "Оюу Толгой" ХХК-ийн засаглалыг сайжруулах ажлын эхний үе шатыг дуусгаж, дүн шинжилгээ, санал дүгнэлтээ ирүүлж, 2-р шатны ажлын саналыг танилцуулж, төлөвлөгөөний дагуу засаглал сайжруулах ажил нэг шатаар ахисан. Энэ хүрээнд хувьцаа эзэмшигч талууд буюу "Эрдэнэс Оюу Толгой" ХХК, "Эрдэнэс Монгол" ХХК, "Рио Тинто" ХХК-ийн зүгээс ОТ ХХК-ийн засаглалыг сайжруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Ankura Consulting компанитай хамтран ажиллаж Засаглалын хүрээний баримт бичигт тус тусын төлөөллийг оролцуулан байр сууриа илэрхийлэн, саналаа өгсөн.	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.
5.2 "Оюу Толгой" ХХК-ийн засаглалын болон мэдээллийн ил тод байдлыг сайжруулах	5.2.1 ОТ ХХК-ийн засаглалын болон мэдээллийн ил тод байдлыг сайжруулах асуудлаар санал, мэдээлэл, танилцуулга боловсруулах ОТ ХХК-ийн засаглалын талаарх зөвлөхийн тайлан, дүгнэлттэй холбоотой санал боловсруулах	Засаглалын үзүүлэлтүүд	90%	ОТ ХХК-ийн засаглал, үр дүнг Монгол Улсын Засгийн газарт танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох мэдээ, мэдээллээр хангах үүрэг хүлээн ажиллаж байна. Мөн цаашид хамаарах талуудтай засаглалыг сайжруулах уулзалт, хэлэлцээр хийх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.
ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ			85%		
6. САЙН ЗАСАГЛАЛ, ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЗАРЧМУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ӨМНИЙН БҮСИЙН ХӨГЖЛИЙГ ХУРДАСГАХАД ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ИДЭВХТЭЙ АЖИЛЛАНА					

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ /хувь/ Жилээр	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
6.1 МУ-ын 3Г-ын бодлогын баримт бичиг "Бүсчилсэн Хөгжил"; "Шинэ Сэргэлтийн Бодлого" Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд дэмжиж ажиллана.	6.1.1 Өмнийн говийн бүсийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээний 4-р бүлгийн хэрэгжилтийг хамтран хэрэгжүүлэх	Санал дүгнэлт, тайлан боловсруулсан эсэх	100%	Оюу толгойн ХөОГ-ний 4 дүгээр бүлэг, УИХ-ын 103 дугаар тогтоолын 1,5 дахь заалт, ЭОТ- ОТ хамтран ажиллах Байгаль орчин нийгэм, засаглалын түншлэлийн гэрээний хэрэгжилтийг хангуулах хүрээнд болон төрөөс баримтлаж буй Бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор Эрдэнэс Оюу Толгой ХХК, Оюу Толгой ХХК, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ хамтран ажиллах гурван талт санамж бичгийг байгуулах санаачилга гарган энэ хүрээнд санамж бичиг байгуулж, Монгол Улсын Шадар сайд санамж бичгийг 2025 оны 08 дугаар сарын 27нд батламжлав. Санамж бичгийн хүрээнд Говийн бүсэд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн ажлын тодорхойлолтыг боловсруулан 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр баталгаажуулав. Өмнийн бүсэд хэрэгжүүлэх ажлуудыг бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялуудлан нарийвчилсан ажлын даалгавар боловсруулж ажиллаж байна.	Төлөвлөгөөний дагуу холбогдох ажлууд хийгдсэн, үргэлжилж байна.
	6.1.2 Ханбогд сум нь 2025.06.01-нээс орон нутгийн зэрэглэлтэй хот болж байгаатай холбогдуулан Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллах	Санал дүгнэлт, тайлан боловсруулсан эсэх	100%	ХХХОТС-ийн 2024 оны тайлатай танилцаж тус сангийн 2025 онд Ханбогд суманд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний хүрээнд газар дээр нь очиж танилцаж санал дүгнэлтээ танилцуулав. Түүнчлэн сангаас гүйцэтгэж буй дэд бүтэц, нийгмийн болон боловсрол, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг чанаржуулах зөвлөмжийг өгч ажиллав. Мөн суманд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудын зардал өндөр, бүтээмж удаашралтай байгааг удаа дараа сануулж ажиллав. Ханбогд сумын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажилд түншлэлийн хороотой хамтран ажиллах саналаа хүргүүлээд байна.	Төлөвлөгөөний дагуу холбогдох ажлууд хийгдсэн . Ирэх онд үргэлжилнэ.
	6.1.3 Ханбогд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Оюу толгой уурхайн ажилтан, албан хаагчдыг Ханбогдод тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрахад зориулан орчин үеийн нийгмийн үйлчилгээний хүртээмжтэй, иргэндээ ээлтэй, амьдрах таатай нөхцөл бүрдсэн орон сууц бүхий хорооллыг бий болгоход төрийн бодлогоор дэмжиж ажиллах	Санал дүгнэлт, тайлан боловсруулсан эсэх	80%	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн тэмдэглэлээр Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн, Оюу Толгой төслийн ажилтнуудыг Ханбогд суманд тогтвор суурьшилтай амьдрахад зориулсан хүртээмжтэй, таатай нөхцөл бүхий орон сууцны хорооллыг байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Өмнөговь аймгийн Засаг даргад даалгасны дагуу "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Ганхүү болон Ханбогд төсөл, хамтын ажиллагааны хэлтсийн менежер Б.Чулуунбаатар нар Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбаттай уулзаж ажлын хэсэг байгуулах, хамтран ажиллахаар тохиролцсон. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн тэмдэглэлийг уламжлан Өмнөговь аймгийн засаг даргад албан бичгээр хүргүүлсэн. Энэ хүрээнд 2025.05.12-нд Өмнөговь аймгийн засаг дарга Н.Энхбат болон Ханбогд сумын засаг дарга нартай Говийн бүсийн анхдугаар хуралдааны үеэр уулзалт зохион байгуулж ажлын хэсгийг яаралтай байгуулж газрын асуудлыг шийдвэрлэх хүрээнд санал солилцож ажиллав.Оюу толгой уурхайн ажилтан, албан хаагчдыг Ханбогдод тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрахад зориулан орчин үеийн нийгмийн үйлчилгээний хүртээмжтэй, иргэндээ ээлтэй, амьдрах таатай нөхцөл бүрдсэн орон сууц бүхий хорооллыг бий болгох хүрээнд ОТ ХХК-ийн ажилчдын орон нутагт суурьшин амьдрах талаарх судалгааг авч ажилласан бөгөөд ажиллах, амьдрах орчин нөхцөл, нийгмийн гол үйлчилгээ эрүүл мэнд,боловсролын салбарын хүртээмж нэмэгдсэн тохиолдолд Ханбогд суманд ажиллаж амьдрахад бэлэн байгааг судалгааны дүн харуулсан. Үүнтэй холбоотойгоор цаашид сум орон нутагт, аймгийн удирдлага идэвхи санаачилга гарган ажиллах газрын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага тулгараад байна.	Төлөвлөгөөний дагуу холбогдох ажлууд шат дараатай хийгдэж байна. Энэ ажил ирэх онд үргэлжилнэ.
	6.1.4. Өмнийн говийн бүсийн Шинэ хоршоо хөдөлгөөний салбар уялдааг дэмжиж ажиллах	Санал дүгнэлт, тайлан боловсруулсан эсэх	90%	Эрдэнэс Оюу Толгой ХХК, Оюу Толгой ХХК, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ хамтран ажиллах гурван талт санамж бичгийг байгуулж энэ хүрээнд Говийн бүсийн малчдын амжиргааг дэмжих, малын гаралтай нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний боловсруулалтыг нэмэгдүүлэх, малчдын хамтран ажиллах нөхцөлийг сайжруулах хүрээнд малчдын дундын хоршооны жишиг загвар боловсруулах, малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг өргөтгөх замаар дэмжин ажиллах санал, санаачилга гарган энэ дагуу ЭОТ ХХК- ОТ ХХК хамтран ажилах ажлын тодорхойлолтыг 2025.09.18нд баталсан. Ажлын тодорхойлолтын дагуу нарийвчилсан төлөвлөгөө боловсруулагдаж байна. Төлөвлөгөөнд малчдын хоршоо, бүлгэмийн уялдааг хангаж ажиллах, жишиг хоршоо байгуулах ажил хийхээр ирэх оны төлөвлөгөөнд тусгав.	Төлөвлөгөөний дагуу холбогдох ажлууд хийгдсэн.Ирэх онд үргэлжилнэ.
6.2 "Говийн Оюу Хөгжлийн Дэмжих" сан "Ханбогдын Хөгжлийн Хурдасгуур Оюу Толгойн" сангийн үйл ажиллагаа, засаглал, хяналтыг сайжруулах.	6.2.1 "Говийн Оюу Хөгжлийн Дэмжих" сангийн түншлэлийн хороо, удирдах зөвлөлд "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн төлөөллийг оруулж бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдсан төсөл хэрэгжүүлэхэд санал оруулах	Түншлэлийн хороо, удирдах зөвлөлд компанийн төлөөлөл орж саналаа оруулсан эсэх	80%	Оюу Толгой ХХК-ийн орон нутгийн харилцааны хэлтсийн гүйцэтгэсэн Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдлын судалгааг авч, Гурван талт зөвлөлийн хурал болон харилцааны хорооны хуралд оролцохоор тохиролцов. Сар бүрийн хуралд оролцож тухайн сард хийсэн ажилтай танилцав. Гүйцэтгэж буй ажлын үр дүн, төлөвлөлтийн талаар саналаа хэлж хамтран ажиллаж байна. Гурван талт зөвлөлийн хурал нь товчлосон хугацаанд хуралдахгүй байх зэрэг тохиолдол гарсан бөгөөд цаашид энэ асуудалд анхаарал хандуулж хуралд хяналтын байдлаар оролцохоо удаа дараа илэрхийлэв. Түүнчлэн бүс нутгийн хөгжилд Оюу толгой төслийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх энэ хүрээнд ОТ ХХК-иас санхүүжилтэй үйл ажиллагаа явуулж байгаа сангуудын үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн үр дүн, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд илүү анхаарч хөрөнгө оруулалтыг үр ашигтай захиран зарцуулах талаарх саналаа илэрхийлэн хяналт тавьж ажиллаж байна.	Төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.Ирэх онд үргэлжилнэ.
	6.2.2 "Ханбогдын Хөгжлийн Хурдасгуур Оюу Толгойн" сангийн үйл ажиллагаа, засаглал, хяналтыг сайжруулах	Санал дүгнэлт, тайлан боловсруулсан эсэх	95%	ХХХОТ сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2025.09.10-наар дуусгавар болож байгаатай холбоотойгоор Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-д тус сангийн үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн үзүүлэлт, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, түүний үр дүнгийн талаарх танилцуулга хийж ХХХОТ сангийн ТУЗ-д ЭОТ ХХК-ийг цаашид төлөөлөх гишүүнээр ЭОТ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүг томилох тогтоолыг Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-аас гаргав. Тус сангийн үйл ажиллагаатай холбоотойгоор 14 хоног тутмын хуралд оролцож Ханбогд суманд хийгдэж байгаа ажлын явц, гүйцэтгэлийн мэдээлэлийг авч ажиллаж байна. Энэ хүрээнд Тус санд төрийн аудит оруулахаар Үндэсний аудитын газарт албан бичиг илгээсэн. Гэвч 2025 оны төлөвлөгөө батлагдсан тул боломжгүйг мэдэгдсэн. Иймд төлөвлөгөөт бус аудит оруулах хүсэлтээ дахин илгээсэн боловч мөн энэ онд аудит оруулах боломжгүй байсан тул ирэх оны төлөвлөгөөнд тусгуулахаар ажиллаж байна.Хурдасгуур сангийн засаглалыг сайжруулах хүрээнд ТУЗ-д ЭОТ ХХК-ийн захирал гишүүнээр орсон нь цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаанд болон төсвийн зарцуулалтад бодит хяналт тавих нөхцөл бүрдсэн.	Төлөвлөгөөний дагуу холбогдох ажлууд хийгдсэн
ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ			91%		
7. САНХҮҮ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАЖ ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ЭОТ ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛНА					
	7.1.1 Бизнес төлөвлөгөө хэрэгжүүлэхэд тулгарч болох эрсдэлийн бүртгэл хийх		100%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
			/хувь/ Жилээр		
7.1 Эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэх	7.1.2 Бүртгэгдсэн эрсдэлүүдийн үнэлгээ хийх	Эрсдэлийн удирдлагын тайланг хүргүүлсэн эсэх	100%	2024 оны Эрсдэлийн удирдлагын тайланг боловсруулж, "Эрдэнэс Монгол" ХХК-д компанийн үйл ажиллагааны тайлангийн хамт хүргүүлсэн. 2025 оны компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй 49 эрсдэлийн бүртгэж, үнэлэн, хариу арга хэмжээг төлөвлөсөн ба хариу арга хэмжээний хэрэгжилтийг улирал бүр гарган "Эрдэнэс Монгол" ХХК-д хүргүүлж ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар компанийн хэмжээнд нийт бүртгэж үнэлсэн 49 эрсдэлээс бага – 4, дунд – 38, өндөр - 7 эрсдэл үнэлэгдсэн.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	7.1.3 Бүртгэж үнэлэгдсэн эрсдэлүүдийн хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах		100%	Эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр 11 дүгээр сарын байдлаар дунд түвшний 15 эрсдэл бага түвшинд буурч, тоон дүнгээр эрсдэлийн үнэлгээ буурсан ба өндөр түвшний 5 эрсдэл дунд түвшин рүү буурсан байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	7.1.4 Эрсдэлийн тайланг боловсруулж толгой компанид хүргүүлэх		100%	Мөн "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ий 2026 оны бизнес төлөвлөгөөнд туссан 7 зорилгын хүрээнд 52 зорилтын учирч болзошгүй нийт 101 эрсдэлийг тодорхойлсон бөгөөд эрсдэлийн ангиллаар авч үзвэл стратегийн эрсдэл 2, санхүүгийн эрсдэл 9, үйл ажиллагааны эрсдэл 78, БОНЗ эрсдэл 7, үйлдвэрлэлийн эрсдэл 5 тодорхойлогдсон.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
7.2 Нэгдлийн хэмжээнд ERP системийг нэвтрүүлэхэд хамтран ажиллах	7.2.1 Компанийн дотоод системийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох	Хэрэгцээ шаардлагыг гаргасан байдал, тоо	20%	Нэгдлийн хэмжээний ERP систем нэвтрүүлэх баг болох ЭМГЛ ХХК-ийн Нэгдлийн удирдлагын нэгдсэн систем, цахим хөгжлийн зөвлөлийн мэргэжилтэн н.Ундрам нарт системийн хэрэгцээ шаардлага, одоогийн нөхцөл байдлыг тодорхойлох ярилцлага, мэдээллийг өгсөн.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.
	7.2.2 ERP системийг нэвтрүүлэхэд нэгдэх	ERP системд нэвтэрсэн хувь	0%	Компанийн системийн хэрэгцээ шаардлага, одоогийн нөхцөл байдлын талаар асуулгад холбогдох ажилтнууд оролцон мэдээлэл өгч, хамтран ажиллаж байна. Нэгдлийн хэмжээнд ERP нийлүүлэх сонгон шалгаруулалтын хүрээнд тус системийг туршилтын байдлаар нэвтрүүлж, зарим модулийг хэрэгжүүлж эхлүүлээд байгаа бөгөөд ирэх онд бүрэн нэвтрүүлж ашиглах тухай мэдээлэл өгсөн. Тус системийн "худалдан авах ажиллагаа" зэрэг зарим модулийг ашиглах талаарх уулзалт, сургалтад холбогдох ажилтнууд оролцсон.	Нэгдлийн хэмжээнд нэвтрүүлэлт хойшлогдсон
7.3 Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах	7.3.1 Гүйцэтгэх захирлын өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангах, Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, нэгдсэн хяналт тавих	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдал хангагдсан эсэх, үүрэг даалгаврын хэрэгжилтийн мэдээллээр хангасан байдал	100%	Гүйцэтгэх удирдлагын албан уулзалт, ажлын хэсгийн хуралд зочин, төлөөлөгчид хүлээн авч гадаад дотоод томилолт, уулзалттай холбоотой товыг нэгтгэн жагсаалт гаргаж, холбогдох мэдээ мэдээллийг удирдлагад хүргүүлэн, хөтлөх нэрийн жагсаалтын дагуу тайлан, удирдамж, хурлын тэмдэглэл, томилолтын тайланг нэгтгэн архивд хүлээлгэн өгөхөд бэлтгэн, шаардлагатай бараа, материалыг худалдан авч сар бүрийн кассын тайланг гаргаж Гүйцэтгэх удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.	Төлөвлөгөөний дагуу үргэлжилж байна.
	7.3.2 Компанийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ, тушаал, шийдвэр, дүрэм, журмын төсөл боловсруулах, зөвлөгөө, мэдээллээр хангах, хууль зүйн эрсдлээс урьдчилан сэргийлэх	Компанийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг боловсруулсан эсэх	100%	Компанийн үйл ажиллагаатай холбоотой 2025 оны 4-р улирлын байдлаар гэрээ 43, тушаал, шийдвэр 55, холбогдох зөвлөгөө, мэдээлэл, хууль зүйн эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	Төлөвлөгөөний дагуу үргэлжилж байна.
	7.3.3 Өргөдөл гомдол, ирсэн бичигт хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж хариу хүргүүлэх	Шийдвэрлэж хариу хүргүүлсэн тоо	85%	Хариутай бичгийн шийдвэрлэлтэд нийт 52 албан бичиг ирсэнээс 46 албан бичигт хариуг хүргүүлж, 6 албан бичиг ажиллагаанд явж байна. Ажилтнаас 40, иргэнээс 5 хүсэлт ирүүлсэн бөгөөд тухай бүрд хууль журамд нийцүүлэн хэрэгжилтийг хангаж ажилласан.	Төлөвлөгөөний дагуу үргэлжилж байна.
	7.3.4 Төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах	Худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичиг боловсруулж, хэрэгжилтийг хангасан эсэх	100%	2025 онд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөөгүй.	Худалдан авалт төлөвлөөгүй.
7.4 УИХ, Засгийн газар, толгой компаниас гаргасан шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах	7.4.1 Шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн тайлан мэдээ, сар, улирал бүрийн төлөвлөгөө, тайлан мэдээллийг хүргүүлэх, шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүрд хангаж ажиллах	Тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлсэн эсэх	90%	-2025 оны компанийн 1, 2, 3 дугаар улирлын үйл ажиллагааны тайлан; -УИХ-ын ЭЗБХ-д зориулсан сар бүрийн үйл ажиллагааны тайлан; -Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан зэрэг мэдээллийг тухай бүрд Толгой компани, холбогдох бусад байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.	Төлөвлөгөөний дагуу үргэлжилж байна.
7.5 Компанийн дотоод хэм хэмжээ, эрх зүйн орчинг сайжруулах	7.5.1 Компанийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа хууль тогтоомжийн нэгдсэн сан үүсгэх	Мэдээллийн сан үүсгэсэн эсэх	90%	Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгцээ шаардлага бүхий хууль тогтоомж, дүрэм журмын нэгдсэн санг үүсгэж, цаашид тодорхой дүрэм, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	Сан үүсгэсэн
	7.5.2 Компанийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд компанийн дотоод хэм хэмжээ, зохицуулалтын байдалд шинжилгээ хийх, шаардлагатай дүрэм, журмыг шинээр гаргаж мөрдүүлэх	Шинжилгээ хийсэн байдал, шаардлагатай дүрэм, журмыг баталж мөрдүүлсэн эсэх	50%	Гүйцэтгэх захирлын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/31 дугаартай "Ажлын хэсэг байгуулах тухай" Компанийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд компанийн дотоод хэм хэмжээ, зохицуулалтын байдалд шинжилгээ хийх, шаардлагатай дүрэм, журмыг шинээр гаргаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг компанийн үйл ажиллагаанд холбогдох дотоод хэм хэмжээ, зохицуулалтын байдалд шинжилгээ хийж шаардлагатай дүрэм, журмыг шинээр гаргаж мөрдүүлэх ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.	Хэрэгжүүлсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ /хувь/	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
			Жилээр		
7.6 Авилгын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	7.6.1 ХАСХОМ, ХАСУМ-ийн бүртгэл, хяналт, мэдээлэл, зөвлөгөө, мэдээлэл, тайланг эрхлэн хөтлөх	ХАСХОМ, ХАСУМ-ийн холбогдох тайлан, мэдээлэл гаргасан эсэх	100%	1/ Авилгын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд компанийн ХАСХОМ болон ХАСУМ гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудын бүртгэл, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим бүртгэлд тайлагнан ажиллаж, хуулийн хугацаанд тайлан (8 хуудас), мэдээллийг толгой компани "Эрдэнэс Монгол" ХХК-д 2025.02.26-ны өдрийн 01/47 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2/ Эрдэнэс Монгол нэгдлийн хуулийн этгээдүүдийн 2023-2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс хяналт тавьж, холбогдох "Зөвлөмж"-ийг ирүүлсний дагуу "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"-г Гүйцэтгэх захирлын 2025 оны А/22 дугаартай тушаалаар шинэчлэн баталсан. 3/ ЭОТ ХХК-ийн "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар толгой компанид 2025 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 01/150 дугаартай "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн. 4/ ЭОТ ХХК-ийн "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны шинэчилсэн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн тайлан (9 хуудас)-г 2025 оны байдлаар толгой компанид 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/306 дугаартай "Тайлан хүргүүлэх тухай" албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.
7.7 Ажлын байрны цогц шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах	7.7.1 Ажлын байрны зураг авалт, чиг үүргийн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах	Ажлын байрны чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны зураг авалт хийгдсэн эсэх	75%	Ажлын байр, орон тоог нэмэгдүүлэхгүй байх бодлоготой уялдуулан чиг үүргийг шинжлэн, ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн баталж, хэрэгжүүлж байна.	
	7.7.2 Процессын дахин инженерчлэл хийх ажлыг зохион байгуулах	Компанийн нийт үйл ажиллагаанд процессын хувьд дахин инженерчлэл хийсэн эсэх	0%	Тус ажлыг менежмент, хүний нөөцийн мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөсөн бөгөөд ЗГ-аас хэрэгжүүлж буй хэмнэлтийн бодлого, компанийн төсвийн хэмнэлттэй холбоотойгоор хийгдээгүй.	Хийгдээгүй
7.8 Байгууллагын хүний нөөцийн менежментийн үйл ажиллагааг сайжруулах	7.8.1 Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэх, Гүйцэтгэлийн үнэлгээний журам боловсруулах, Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, байгаль орчны журмын судалгаа хийх	Журмын өөрчлөлт, боловсруулалт, судалгааг хийсэн эсэх	80%	Хөдөлмөрийн дотоод журам, Гүйцэтгэлийн үнэлгээний журмын төслүүдийг шинэчлэн боловсруулж баталсан. Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулагдсан компанийн дотоод үйл ажиллагаанд холбогдох нийт дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж сайжруулах ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох бусад журмуудын судалгаа, шинжилгээний ажил хийгдэж байна.	Хөдөлмөрийн дотоод журам, Гүйцэтгэлийн үнэлгээний журам болон холбогдох бусад журмууд шинэчлэгдсэн.
	7.8.2 Компанийн хүний нөөцийн мэдээллийн сан үүсгэх, шаардлагатай тохиолдолд тайлан гаргаж толгой компанид хүргүүлэх	Компанийн хүний нөөцийн мэдээлэл, сан үүсгэх явц Хүний нөөцийн тайлан гаргасан байдал	100%	Хүний нөөцийн мэдээллийн сан буюу ажиллаж байгаа ажилтнуудын болон шаардлагатай зарим ажлын байранд сонирхогчдын материалыг цахим хавтас үүсгэн хадгалсан. Хүний нөөцийн холбогдох тайланг улирал бүр ҮА тайлангийн хамт, мөн шаардлагатай тохиолдол тухай бүрд хүний нөөцийн тодорхой асуудлаар тайлан, мэдээлэл боловсруулан толгой компани, бусад холбогдох байгууллагад хүргүүлж байна.	Хэрэгжүүлсэн.
	7.8.3 Хүний нөөц, бүтэц, орон тооны төлөвлөлтийн төсөл боловсруулах /шаардлагатай тохиолдолд тухай бүрд/	Боловсруулсан төслийн тоо	100%	Компанийн зохион байгуулалтыг сайжруулах үүднээс бүтэц, орон тооны хязгаарын төслийг шинэчлэн боловсруулж толгой компанийн ТУЗ-ийн 2025.04.08-ны 57 дугаар тогтоолоор батлагдсан ба энэ хүрээнд холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэсэн.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.
	7.8.4 Сул орон тоо, шаардлагатай ажлын байранд сонгон шалгаруулалт зарлаж, ажилтан шалгаруулж авсах	Сонгон шалгаруулалт зарлаж, ажилтан шалгаруулж авсан тоо	70%	2025 оны 1 дүгээр сард СТШХ-ийн Мэдээллийн шинжээч мэргэжилтэн, Санхүүгийн загварчлал хариуцсан мэргэжилтний сул ажлын байранд сонгон шалгаруулалт зохион байгуулж, шалгарсан 2 ажилтантай туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулсан. Тайлант хугацаанд тодорхой ажилтнууд хувийн шалтгааны улмаас хүсэлтээ өгч ажлаас чөлөөлөгдсөн ба ЗГ-аас ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу сул орон тоог нөхөн ажилтан сонгон шалгаруулах боломжгүй, үйл ажиллагааны зарим чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл үүсээд байна.	Хэрэгжүүлсэн.
7.9 Хөдөлмөрийн бүтээмж, ажиллах нөхцлийг сайжруулах	7.9.1 Хүний нөөцийн чадавхыг олон улсын түвшинд хүргэж, бэхжүүлэх хүрээнд сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулж ажилтнуудыг хамруулах	Сургалт зохион байгуулсан тоо	70%	Архив, албан бичиг хэргийн хөтлөлтийн сургалт, Нууцын тухай хууль, тогтоомжийн хэрэглээ, нууц мэдээлэл ашиглах хамгаалахтай холбогдох зохицуулалтын талаарх сургалт, татварын хууль тогтоомжийн уул уурхайн салбарын зохицуулалтын талаарх сургалтуудыг зохион байгуулж нийт ажилтнууд хамрагдав. Мөн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулах чиглэлээр Рио Тинто компани болон Австрали улсын Күйнслэнд мужийн их сургуулийн хамтран зохион байгуулж буй "Өмнийн говийн далд уурхайн институт"-ын мэргэжил дээшлүүлэх "Хариуцлагатай орон нутгийн харилцаа" зэрэг сургалтууд, Европын Холбооны Тогтвортой Санхүүгийн Зөвлөх Төв (SFAH)-ийн хүрээнд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Тогтвортой байдлын төлөөх санхүүгийн төвөөс (UNDP FC4S) хэрэгжүүлж, Сангийн яамнаас зохион байгуулсан "Тогтвортой байдлын удирдлага", МУУҮА-ын "Хариуцлагатай уул уурхай" зэрэг сургалтуудад холбогдох ажилтнууд хамрагдлаа.	Сургалтын төлөвлөгөө, төсөв батлагдаагүйтэй холбогдон зарим төрийн байгууллагуудаас шаардлагатай боломжит сургалтуудыг авсан. Төлөвлөгөөний дагуу сургалтуудыг бүрэн зохион байгуулах боломж хомс байна.
	7.9.2 Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	ЭМУСҮ-т хамруулсан эсэх	0%	-	Санхүү, төсвийн байдлаас шалтгаалан хойшлогдсон.
7.10 Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг хангаж ажиллах	7.10.1 Аж ахуй, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тогтмол хяналт тавих	Хөрөнгийн тооллого хийсэн тоо, бүрэн бүтэн байдал	95%	Аж ахуй, засвар үйлчилгээ, хадгалалт хамгаалалт, хяналт тавихтай холбогдох ажиллагааг тогтмол гүйцэтгэж байна. Хагас жилийн байдлаарх эд хөрөнгийн дотоод /ХНААХМ/ тооллого хийсэн ба Гүйцэтгэх захирлын тушаалаар Эд хөрөнгийн тооллогны комиссыг шинэчлэн байгуулж, жилийн эцсийн тооллого хийгдэж байна.	Төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн.
	7.10.2 Компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл, төлбөр тооцоо, гүйлгээ, үндсэн ба мөнгөн хөрөнгө, бараа материалын бүртгэл, тайлагналттай холбогдох ажиллагааг гүйцэтгэх	НББ, санхүү тайлан мэдээг гаргаж хүргүүлсэн байдал	100%	Компанийн 2025 оны 1-р улирал, 2-р улирал, 3, 4 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг ЭМ-ийн ТУЗ-ийн хурлаар батлуулсан. Компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл, цалин хөлс, бараа материал хөрөнгийн бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв хөтөлж, нийгмийн даатгалын тайланг сар бүр, санхүүгийн тайлан балансыг улирал бүр гаргаж Сангийн яам, АҮЭБЯ, ТӨБЗГ, Татварын ерөнхий газар, "Эрдэнэс Монгол" ХХК-д тус тус хүргэж баталгаажуулан ажилласан.	Төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн.
	7.10.3 Хангамж нийлүүлэлт, мөнгөн хөрөнгийн гүйлгээ, төлбөр тооцоотой холбогдох ажиллагааг гүйцэтгэх	Хангамж нийлүүлэлтийг цаг тухайд хийсэн эсэх, гүйлгээ, төлбөр тооцоо хийгдсэн эсэх	100%	Хангамж нийлүүлэлт, мөнгөн хөрөнгийн гүйлгээ, төлбөр тооцоотой холбогдох тогтмол үйл ажиллагааг цаг тухай бүрд хийж гүйцэтгэв.	Цаг тухай бүрд гүйцэтгэсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
			/хувь/ Жилээр		
7.11 Байгууллагын архивыг цахимжуулах	7.11.1 ЭОТ ХХК-ийн 2011-2024 оны ажлын тайлангууд, 2024 оны ирсэн явсан бичгүүд, гүйцэтгэх захирлын тушаалууд, ОТ ТУЗ-ийн 2009-2024 оны хурлын материалууд, түүнд холбогдох баримт бичгүүд архивын хадгаламжийн нэгж болгох болон цахимжуулах ажил гүйцэтгэх	Цахимжуулсан хувь, хэмжээ	80%	ЭОТ ХХК-ийн 2011-2024 оны ажлын тайлангууд, 2024 оны ирсэн явсан бичгүүд, гүйцэтгэх захирлын тушаалууд, ОТ ТУЗ-ийн 2009-2024 оны хурлын материалууд, түүнд холбогдох баримт бичгүүд архивын хадгаламжийн нэгж болгох болон цахимжуулах ажилын хүрээнд : 2012 он 15 файл, 1.42 gb, 2013 он 12 файл, 1.25 gb, 2014 он 9 файл, 810 mb, 2015 он 12 файл, 1.32 gb, 2016 он 6 файл, 635 mb, 2017 он 8 файл, 680 mb, 2018 он 16 файл, 1.73 gb, 2019 он 16 файл, 0.98 mb, 2020 он 27 файл, 1.78 gb, 2021 он 27 файл, 2.82 gb, 2022 он 88 файл, 8.82 gb, 2023 он 79 файл, 5.20 gb, 2024 он 94 файл, 8.23 gb хадгаламжийн нэгжүүдийг цахимжуулж ажилласан байна.	Төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн.
7.12 Нууцад хамаарах мэдээллийг нууцлах, хамгаалах үйл ажиллагааг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх	7.12.1 Нууц хамгаалахтай холбогдох ажиллагааг гүйцэтгэх, ТБАНууцын талаар сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан эсэх	100%	Нууцад хамаарах мэдээллийг нууцлах, хадгалах, хамгаалах үйл ажиллагааг тогтмол гүйцэтгэж байна. 2025.03.14-ны өдөр Тагнуулын ерөнхий газраас 2 албан хаагч урин ирүүлж "Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, анхаарах зарим асуудал" сэдэвт сургалтыг нийт ажилчдад зориулан зохион байгуулав.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.
7.13 Байгууллагын гадаад харилцаа, олон нийт хамтын ажиллагааг хөгжүүлэх	7.13.1 Веб сайт шинэчлэн хөгжүүлэх	Вебсайт шинэчлэн хөгжүүлсэн эсэх	100%	Компанийн албан ёсны веб www.eot.mn сайтын өнгө төрхийг шинэчлэн, холбогдох мэдээ, мэдээллүүдийг бэлтгэн боловсруулж төрийн мэдээллийн цахим системд бүртгэлжүүлэн бэлэн болсон. Сайтын хөгжүүлэлтийн ажил хийгдэж мэдээ, мэдээллүүдийг тогтмол шинэчлэн оруулж, нээлттэй ил тод байдлын ханган ажиллаж байна.	төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж дууссан.
	7.13.2 "Эрдэнэс Монгол" нэгдлийн бодлоготой уялдуулан компанийг олон нийтэд сурталчилан таниулах үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	Төлөвлөгөө боловсруулсан эсэх	90%	Компанийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан Эрдэнэс Монгол ХХК болон Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-д хүргүүлэв. Түүнчлэн компанийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, Оюу толгой төсөл, Хэрлэн тооно төсөл болон толгой компаниас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг олон нийтэд таниулан сурталчлахад компанийн албан ёсны вэб сайт, цахим хуудсуудаар болон хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан түгээн ажиллаж байна. Команийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө эцэслэн батлагдаагүй байгаатай холбоотойгоор компанийг олон нийтэд сурталчлан таниулах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулаагүй бөгөөд нэгдлийн нэгдсэн зохион байгуулалтай үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдийг олон нийтэд таниулах, төсөлтэй холбоотойг цаг үеийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг цаг алдалгүй тухай бүрд үнэн зөвөөр мэдээллэж ажиллаж байна.	төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа, хэрэгжилт бүрэн бус ирэх онд үргэлжилнэ
	7.13.3 Уул, уурхайн чиглэлээр зохиогдож байгаа олон улсын хуралд оролцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг эрэлхийлэх	Оролцсон эсэх	90%	1. Уул уурхайн салбарын сүүлийн үеийн шинэ технологи, дэвшлийн талаар мэдээлэл авах, бусад ижил төстэй компанитай хамтын ажиллагаа өргөжүүлэх зорилгоор компанийн төлөөлөл Канад Улсын Торонто хотноо 2025 оны 3 дугаар сарын 2-5-ны өдрүүдэд болсон уул уурхайн салбарын олон улсын хурал PDAC-д оролцсон бөгөөд холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. 2. 2025 оны 4 дүгээр сарын 12-17-ны өдрүүдэд Оманы Султант Улсын Мускат хотноо болох ОТ ХХК-ийн ээлжит стратегийн хуралд компанийн төлөөлөгчид оролцохтой холбоотой бэлтгэл ажлыг зохион байгуулж, арга хэмжээг авч, мэдээ, мэдээллээр хангаж ажиллав.Мөн энэ онд зохион байгуулагдах дотоод болон гадаадын томоохон уул уурхайн чуулган, хурал, арга хэмжээнд оролцох төлөвлөгөөг гарган судалж байна. 3. Уул уурхайн 7 хоног арга хэмжээнд Эрдэнэс Монгол нэгдлийн зохион байгуулалтаар хамтран оролцож компанийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр,үйл ажиллагаагаа танилцуулав. Зарим төлөвлөгөөт олон улсын хурал арга хэмжээнд оролцоогүй бөгөөд 3Г-аас өгсөн чиглэлийн гадаад томилолт, хуралд оролцохыг хязгаарласан шийдвэртэй холбоотой.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжилт хангагдсан.
	7.13.4 Гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компанитай хамтран ажиллах	Хамтын ажиллагааны Санамж бичиг төсөлд компанийн хэрэгцээ шаардлага тусгагдсан байх	90%	Компанийн гадаад харилцааг өргөжүүлэх, гадны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компанитай хамтын ажиллагаа эхлүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Чили Улсын төрийн өмчит Коделко ХХК-тай хамтын ажиллагаа эхлүүлэх Санамж бичгийн төслийг боловсруулсан. Санамж бичгийн төслийг Бүгд Найрамдах Чили Улсын Коделко компанид хүргүүлэх зорилгоор Гадаад харилцааны яаманд уламжилж өгөх хүсэлтийг 01/30 тоот албан бичгээр 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн. Гадаад харилцааны яамнаас манай төслийг БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо суугаа Бүгд Найрамдах Чили Улсын Элчин сайдын яаманд уламжилж, айлын тал дэмжсэн тул Санамж бичиг байгуулах асуудлыг Монгол Улсын Гадаад харилцааны яам болон Бүгд Найрамдах Чили Улсын Гадаад харилцааны яамд хоорондын Улс төрийн зөвлөлдөх уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан. Санамж бичгийн төслийг байгуулах асуудал төлөвлөгөөнд тусах хүртэл бүх зохицуулалтыг хийж, шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, ГХЯ-тай холбогдон ажилласан бөгөөд санамж бичгийн асуудлаар 01/262 дугаартай албан бичгийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Энэ дагуу ГХЯ-наас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хариу албан бичиг ирүүлсэн бөгөөд Чили Улсын төрийн өмчит Коделко ХХК санамж бичиг байгуулахыг дэмжиж буйгаа илэрхийлсэн мэдээллийг ирүүлээд байна. Ирэх онд санамж бичгийг албан ёсоор байгуулж хамтын ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна.	Төлөвлөгөөний дагуу хамтын ажиллагаа сайжирж, санамж бичиг байгуулсан. Цаашид үргэлжилж байна.
7.14 Уул уурхайн чиглэлээр төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, чиглэлтэй уялдуулан Оюу толгой төслөөс хүртэх үр өгөөжийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах	7.14.1.Үндэсний баялгийн сангийн өгөөжийг олон нийтэд сурталчилан таниулах	Сурталчлан таниулсан мэдээллийн тоо	100%	Уул уурхайн салбарт өрнөж буй гол арга хэмжээнүүд болон Төрөөс баримталж буй салбарын бодлого чиглэлээр тэр дундаа Үндэсний баялгийн сангийн бүрдүүлэлт, баялгийн сангаас олон нийтийн хүртэх өгөөж, ач холбогдолын талаарх видео контетн, постерт мэдээллийг компанийн албан ёсны цахим хуудас /фэйсбүүк, твиттер, сайт/-д байршуулан түгээж ажиллав.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжилт хангагдсан.
	7.14.2 ОТ төсөлтэй холбоотой гол үйл явдлын талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх төлөвлөгөө боловсруулах	төлөвлөгөө боловсруулсан эсэх	90%	ОТ төслийн хэрэгжилт, шууд болон шууд бус өгөөж, орон нутагт хэрэгжиж буй гол арга хэмжээ, хөрөнгө оруулалт, төслөөс монголын талын хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх тухай УИХ, ЗГ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд хийгдэж буй ажил, явц, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлийн талаарх уулзалтыг ОТ ХХК-ийн хамтын ажиллагаа, харилцааны багуутай 2 удаагийн уулзалт хийж цаашид хамран хэрэгжүүлэх ажлуудын талаарх байр сууриа илэрхийлж, мэдээлэл солилцов. Хамтарсан төлөвлөгөө боловсруулах ажил цаг үеийн нөхцөл байдал, УИХ-ын хянан шалгах хороо, хэлэлцээ зэрэгтэй холбоотойгоор удаашралтай байна. Цаашид хамтын ажиллагаа үргэлжилнэ.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжилт бүрэн бус, цаашид үргэлжилнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БИЕЛЭЛТ /хувь/	ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	ТАЙЛБАР
			Жилээр		
	7.14.3 ОТ төслийн талаарх мэдээлэлд хандалтын судалгаа хийх	Судалгаа хийсэн эсэх	90%	ОТ ХХК-иас явуулж буй улирал тутамын олон нийтийн тандалтын судалгааг авч ажиллаж байна. Компанийн зүгээс хөндлөнгийн судалгаа хийлгэхэд санхүүгийн хувьд бүрэн шийдэх боломжгүй нөхцөл байдал болон хэмнэлтийн хууль, чиглэлтэй холбоотойгоор судалгаа хийгдээгүй.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжилт хангалттай бус
7.15 ОТ ХХК-аас мэдээлэл, тодруулга авахаар илгээсэн хүсэлтүүдэд хяналт тавих	7.15.1 Сар бүрийн тайлан, 7 хоног тутмын гүйцэтгэлийн мэдээллүүдэд дүн шинжилгээ хийж хариуцсан багтай уулзалт хийх, холбогдох асуудлаар нэмэлт тодруулга, мэдээлэл авах	Санал дүгнэлт, тайлан боловсруулсан эсэх	100%	Холбогдох шаардлагатай болон дутуу ирүүлсэн мэдээллүүдийг авсан. Хэлтсээс илгээсэн хүсэлт бүрийн жагсаалтуудыг хөтөлж байна.	Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.
	7.15.2 ОТ ХХК-тай холбоотой хүсэлтүүд, уулзалтуудын бүртгэлийг хөтлөх ЭОТ ХХК-ийн хүсэлтүүдэд холбогдох цаг хугацаанд бүрэн мэдээлэл ирүүлсэн эсэхийг хянах		100%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.
	7.15.3 ОТ ХХК-ийн хөтөлдөг мэдээллийн хүсэлтүүдийн жагсаалтуудтай харьцуулалт хийх		100%		Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.
7.16 Бизнес төлөвлөгөөг нэгтгэж боловсруулах, хэрэгжилтийг тайлагнах	7.16.1 Үйл ажиллагаа, Бизнес төлөвлөгөөнд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэлэлт, дүгнэлт өгч, хэрэгжилтийг хангуулан, үр дүнг тооцож ажиллах	Бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, тайланг хугацаанд нь гаргасан эсэх	95%	Бизнес төлөвлөгөө, үүрэг даалгаврын биелэлтийн мэдээллийг төлөвлөгөөт болон шаардлагатай цаг тухай бүрд гаргаж ажиллав.	2025 оны жилийн эцсийн тайланг урьдчилсан байдлаар боловсруулаад байна.
	7.16.2 2025 оны гүйцэтгэл, 2026 оны бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулах	Бизнес төлөвлөгөөг хугацаанд нь боловсруулж батлуулсан эсэх	90%	2025 оны бизнес төлөвлөгөө батлагдаагүй боловч үйл ажиллагаа, санхүүгийн холбогдох тайлан, мэдээлэл, хэрэгжилтийг гарган ажиллаж байна. 2026 оны компанийн бизнес төлөвлөгөөний төслийг журмын дагуу хугацаанд нь боловсруулан толгой компанид хүргүүлсэн ба Толгой компаниас ирүүлсэн санал, тодруулгад нийцүүлэн өөрчлөлт, сайжруулалтыг тусган хүргүүлээд байна.	Компанийн зүгээс төслийг боловсруулан батлуулахаар толгой компани, түүний ТУЗ-д хүргүүлсэн ба хуваарийн дагуу хурлаар хэлэлцэгдэж батлагдана.
ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ			87%		
НИЙТ ДҮНГЭЭР ГҮЙЦЭТГЭЛ			91.18%		

“ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ” ХХК, ТОГТООЛ ШИЙДВЭР, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

/2025.IV улирал/

№	Тогтоол, шийдвэрийн нэр агуулга, тэргүү	Хэрэгжилт
1	ЗГ-ын хуралдааны 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 38 дугаар тэмдэглэл, Хувь Нийлүүлэгчдийн Зээлийн хүүг бууруулах, УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын 1 дэх заалтын 2, 3, 4 дэх дэд заалтын хэрэгжилтийн ажлыг зохион байгуулах тухай	38.17.3.1. “Оюу Толгой” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах, шинэчлэх асуудлаар яриа хэлэлцээ хийх Ажлын хэсгийг байгуулж, бэлтгэл хангаж яриа хэлэлцээг эхлүүлэн, үр дүнг тухай бүр танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт), “Эрдэнэс Оюу Толгой” ХХК (Э.Ганхүү)-д; Хэрэгжилт: 1/ “Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын 1 дэх заалтын 2, 3, 4 дэх дэд заалтын хэрэгжилтийг хангах, “Оюу Толгой” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах, шинэчлэх асуудлаар яриа хэлэлцээ хийх Ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.02.1-ний өдрийн А/29 тушаалаар байгуулж, тус “Ажлын хэсэг” нь хэрэгжүүлэх “Ажлын төлөвлөгөө”-г гарган батлуулж төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг 100% ханган ажилласан. 2/ “Оюу Толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигч талуудын хооронд 2011 онд байгуулсан НӨОДТХНГ-ний 11.3(е) заалтад: “Хөрвүүлэх өдрөөс хойш 7 (долоон) жил тутамд Санхүүжилтийн хүүгийн хувь болон энэхүү Гэрээний 13.1(г)(ii)-д заасан, түүнчлэн энэхүү Гэрээний 25-д заасан Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийн тодорхойлолтод буй хүүгийн хувийн зохистой байдлыг хянан үзэх бөгөөд эдгээр хувийг бүх Тал зөвшөөрснөөр өөрчилж болно” гэсний дагуу хэлэлцээрийг эхлүүлэх тухай “Мэдэгдэл”-ийг “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-иас 2025.04.10-ны өдрийн 01/87 дугаартай албан бичгээр хамаарал бүхий Талуудад хүргүүлж, тус мэдэгдлийн хариуд “яриа хэлэлцээ өрнүүлэхийг дэмжиж байгаа тухай” 2025.05.30-ны өдөр Рио Тинто талаас хариу албан бичгийг ирүүлсэн. 3/ “Оюу Толгой” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах санхүүгийн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг А/29 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2025.05.26-ны өдрийн хурлаар баталсан. Үүний дагуу зөвлөх үйлчилгээнд шаардлагатай зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2025.08.05-ны “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн хурлаар баталсан. 4/ 2025 оны 8 дугаар сард “Эрдэнэс Монгол” ХХК, ЭОТ ХХК, Рио Тинто болон ОТ ХХК-ийн төлөөллүүд оролцсон хэлэлцээний бэлтгэл ажлыг хангах “техникийн уулзалт”-ыг 2 удаа зохион байгуулж, хэлэлцээний урьдчилсан хуваарь, төлөвлөгөөг гаргаж ЗГ-т танилцуулсан.

5/ Оюу толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх, өөрчлөх асуудлаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, санал боловсруулан 3Г-ын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2025.08.19-ний өдрийн 67-р захирамжаар шинэчлэн байгуулсан. Тус Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх Дэд ажлын хэсгийг Сангийн сайдын 2025.09.22-ны өдрийн 169-р тушаалаар байгуулсан. Сангийн сайдын тушаалаар байгуулагдсан Дэд ажлын хэсгийн хүрээнд ХНЗ-ийн хүүг бууруулахтай холбоотой суурь судалгаануудыг хийж, хэлэлцээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоод зөвлөх үйлчилгээний багуудтай хамтран ажиллаж, зөвлөх үйлчилгээний багуудын эцсийн тайланг хүлээн авсан.

6/ Хэлэлцээний бэлтгэлийг бүрэн хангаж 2025 оны 10-р сарын 30, 31-ний өдрүүдэд хөрөнгө оруулагч талтай хийх хэлэлцээг албан ёсоор эхлүүлсэн. Рио Тинто талаас 2025 оны 11-р сарын 20, 12-р сарын 17-ны өдрүүдэд хэлэлцээний саналаа Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхланд албан ёсоор ирүүлсэн 2 талын хэлэлцээг 2026 оны 1-р сарын 19-өөс хэвийн үргэлжлүүлэх боломжтой талаар саналаа ирүүлсэн.

38.17.3.2. “Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолын 1 дэх заалтын 2. 3. 4 дэх дэд заалтын хэрэгжилт, хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах, төслөөс ногдол ашиг авах хугацааг урагшлуулах асуудлаар техник, хууль зүй, санхүүгийн зөвлөх үйлчилгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хараат бус, хөндлөнгийн зөвлөхөөс авах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт), “Эрдэнэс Оюу Толгой” ХХК (Э.Ганхүү)-д;

Хэрэгжилт:

1. УИХ-ын 2021 оны 103 дугаар тогтоолын 1.2 заалтын хэрэгжилттэй холбогдуулан: Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө (ДУББСТ) болон Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө (ДУББСНТ)-г хүчингүй болгох, цуцлах, дуусгавар болгох хувилбар тус бүр нь санхүүгийн нөлөөлөл, үр дагавартай тул эдгээр баримт бичгийг УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын дагуу “хуульд нийцүүлэн цуцалж, хүчингүй болгох” эрх зүйн баримт бичиг байгуулж, баталгаажуулах шаардлагатай бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч талын зүгээс “цуцалж, дуусгавар болгох” байр суурийг илэрхийлж, талуудын байр суурь зөрүүтэй байгаа болно. Харин ДУББСНТ-ний хавсралтаар баталсан “Менежментийн үйлчилгээний гэрээ”-г шинэчлэх талаар талууд ойлголцолд хүрч, 2025.01.20-ны өдөр ОТ ХХК-ийн ТУЗ-өөс “Менежментийн гэрээг шинэчлэх боломжийг эрэлхийлэх удирдамж өгөх тухай” 356-р тогтоол батлагдсан. Менежментийн үйлчилгээний гэрээ (МҮГ)-г шинэчлэх ажлын хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК болон ОТ ХХК-ийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгээр ажлыг даалгаврыг баталж, Анкура гадаад зөвлөх компанийг шалгаруулж, гэрээ хийж, ажлыг эхлүүлж, Анкура зөвлөх компаниас тайлан ирүүлсэн.

	2. УИХ-ын 2021 оны 103 дугаар тогтоолын 1.3 заалтын хэрэгжилттэй холбогдуулан: Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэх асуудлаар Рио Тинто компани "Ernst & Yong" компаниар далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтэд хөндлөнгийн аудит хийлгэж, холбогдох мэдээллийг Ажлын хэсэгт хүргэсэн бөгөөд үүнтэй "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн хувьд байр суурь нэгдээгүй. Иймд УИХ-ын 2021 оны 103-р тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд талуудын хооронд хийсэн уулзалтуудын үр дүнд Далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт болон зардлын гүйцэтгэлд аудит хийх асуудлыг тохиролцсон. Энэхүү Далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт болон зардлын гүйцэтгэлд аудитын "Ажлын даалгавар"-ыг боловсруулж, "Эрдэнэс Монгол" ХХК болон ОТ ХХК-ийн Монголын талын ТУЗ-ийн гишүүдээс ирүүлсэн саналыг тусгасан төслийг эцэслэн батлуулахаар "Эрдэнэс Монгол" ХХК руу 2025.01.24-ний өдрийн 01/20 дугаартай албан бичгээр хүргүүлж, мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/29 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хурлаар "Аудитын ажлын даалгавар"-ыг хэлэлцэж баталсан. Энэхүү Ажлын даалгаврыг Рио Тинто компанид хүргүүлсэн. 3. УИХ-ын 2021 оны 103 дугаар тогтоолын 1.4 заалтын хэрэгжилттэй холбогдуулан: Оюу толгой төслийн гүний уурхай ашиглалтад орж олборлолт эхлэх хугацаа буюу 2023 оны эхний хагас жил хүртэлх нэмэлт зардлыг гадаадын хөрөнгө оруулагч тал 100 хувь хариуцаж, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-д нэмэлт өр үүсгэхгүй байх, "Оюу Толгой" ХХК-д хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдээс нэмэлт зээлийн санхүүжилт авахгүй байх тухай санхүүжилтийн асуудлаар талууд нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай бөгөөд талууд байр суурийн зөрүүтэй байна. Уг асуудлаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.02.11-ний өдрийн А/29 тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ээс хэрэгжүүлэх "Ажлын төлөвлөгөө"-г баталж, түүнд тогтоолын энэ заалтын агуулга, зохицуулалт, хууль зүйн үр дагаврын талаар 2025 онд "дотоод"-ын зөвлөх үйлчилгээ авч, дүгнэлт гаргуулах, улмаар гадаадын хөрөнгө оруулагч талтай нэгдсэн ойлголтод хүрэхээр төлөвлөн ажилласан бөгөөд "Ажлын даалгавар"-ын төслийг эхний байдлаар боловсруулсан. "Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2021 оны 103-р тогтоолын хэрэгжилтийг хангуулах, хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирон, эцэслэсэн хувилбарыг ЗГ-ын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2025.08.19-ний өдрийн 68-р захирамжаар шинэчлэн байгуулсан. Тус Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх Дэд ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.09.19-ний өдрийн А/204-р тушаалаар байгуулсан. Хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ явагдаж байна. 38.17.3.3.MV-015225, MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас Монголын талын хүртэх өгөөж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр дагавар, эрсдэлийн тооцооллыг боловсруулж, 2024 оны 12 дугаар сард багтаан
--	---

Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт), “Эрдэнэс Оюу Толгой” ХХК (Э.Ганхүү)-д даалгасугай.

Хэрэгжилт:

1. Ерөнхий сайдын 2024 оны 120 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт MV-015225, MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас Монголын талын хүртэх өгөөжийн талаар санхүүгийн тооцоолол, хувилбаруудыг судалж, санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий “Ажлын дэд хэсгийг” АҮЭБЯ-ны ТНБД-ын 2025.03.27-ны өдрийн А/46 тушаалаар байгуулсан. Уг ажлын дэд хэсэг 3 удаа хуралдаж, гишүүдээс гадны санхүүгийн зөвлөх үйлчилгээний баг авч санхүүгийн загварчлал, тооцооллыг баталгаажуулах нэгдсэн санал гаргасан. Онтрэ ХХК-ийн эзэмшиж буй ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг ашиглах боломжит хувилбар (Үүнд: ОТ төслийн ХөОГ-нд хамруулах, өсөн нэмэгдэх АМНАТ ноогдуулах, ЗГ-ын хувь эзэмшлийг тусгай АМНАТ-аар орлуулах)-уудыг судалж холбогдох санхүүгийн тооцооллыг хийж, оролцогч талуудын төслөөс хүртэх өгөөжийг тодорхойлж Ажлын дэд хэсгийн тайланг эцэслэн боловсруулсан.

2. Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгойн бүлэг ордын талбайн хил зааг дотор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг “Онтрэ” ХХК-ийн хувьцааны төрийн эзэмших хувь хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, холбогдох бусад асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 73 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. Тус Ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах (1)Гэрээ, эрх зүйн асуудал хариуцсан Дэд ажлын хэсэг, (2) Эдийн засаг, санхүү, татварын асуудал хариуцсан Дэд ажлын хэсэг, (3)Уул уурхай, байгаль орчны асуудал хариуцсан Дэд ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Дэд ажлын хэсэг байгуулах тухай” А/212 дугаар тушаалаар байгуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын 73 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар судалж танилцуулах асуудлаар холбогдох байгууллагад өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу, түүнчлэн ЗГ-ын тогтоолын ОТ төслийн гэрээ хэлэлцээний багийн баримтлах удирдамжийн дагуу ажлын хэсэг ажиллаж байна.

Мөн Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор байгуулагдсан Оюутолгойн бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороонд шаардлагатай материал, танилцуулга, тайлангуудыг боловсруулан хүргүүлж хамтран ажилласан.

38.17.3.8. Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Оюу толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагч талтай хийх яриа хэлэлцээг эрчимжүүлэх болон энэ тэмдэглэлийн хүрээнд зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж,

	хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа сар бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд Ажлын хэсгийн дарга Н.Учралд; Хэрэгжилт: Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67, 68, 73 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг болон Рио Тинто групп хоорондын анхны хэлэлцээрийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан. Тус хэлэлцээрээр Оюу Толгойн зээлийн хүү болон Менежментийн үйлчилгээний төлбөрийг бодитойгоор бууруулах асуудлыг хөндөн эхний байдлаар талууд хэлэлцээний протоколыг байгуулаад байна. Хэлэлцээ үргэлжилж байна. Дараагийн шатны шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 38.17.3.2-д дэлгэрэнгүй тусгасан. 38.6. Оюу толгой төслийн гүний ус ашиглалтыг зохистой хэмжээгээр бууруулах, орон нутаг гадаргын ус хуримтлуулах зорилгоор "Хэрлэн Тооно" төслийн ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулах төлөвлөгөө гаргаж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяад; Хэрэгжилт: Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийг тэлэх 14 мега төслийн нэг болох "Хэрлэн Тооно" төслийн ТЭЗҮ шинэчлэн боловсруулах төслийг "Оюу Толгой" ХХК санхүүжилэн, Монхидроконстракшн ХХК гүйцэтгэж, Эрдэнэс Оюу Толгой ХХК нь ажлын гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Говийн бүсийг экологийн усаар хангах энэхүү төслийн ТЭЗҮ-ийн тодотгол хийх ажлыг гүйцэтгэхэд Засгийн газар болон холбогдох мэргэжлийн байгууллага, орон нутгийн санал, дүгнэлт, шийдвэрийг уялдуулан тооцоо судалгаа, шинжилгээний ажлыг хийхэд анхаарч, гүйцэтгэгч компанийн хэрэгжилтэд зөвлөх багтай хамтран хяналт тавин ажиллаж байна. Гүйцэтгэгчээс 2025.11.30-ны өдөр ТЭЗҮ-ийн судалгааны ажлын Техникийн зураглал ба Санхүү эдийн засгийн урьдчилсан 3 дахь үе шатны ажлын явцын тайланг хүлээн авч захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн. Түүнчлэн санхүүжүүлэгч тал болох Оюу Толгой ХХК-д 2025 оны 12 дугаар сарын 09, 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрүүдэд төслийн явц, тайланг танилцуулах уулзалтыг зохион байгуулан ажиллалаа. Монхидроконстракшн ХХК нь Хэрлэн Тооно төслийн ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулах ажлыг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу гүйцэтгэж холбогдох тайланг боловсруулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны дэргэдэх Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Усны нөөцийн зөвлөлөөс шинжээчдийг томилон тайланд санал зөвлөмж өгч ажиллаж байна. Үүний дараагаар бусад холбогдох байгууллагуудаар хянан баталгаажуулж, шийдвэрлүүлсний үндсэн дээр 2026 оны 1 дүгээр улиралд тайланг эцэслэн боловсруулж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.
--	---

2	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2024.06.06-ны өдрийн “Хэрлэн-Тооно төслийн тухай” 52 дугаар тогтоол	Хэрлэн Тооно төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэх, тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хүрээнд: “Хэрлэн-Тооно” төслийн ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг зарлаж, 2024 оны 08 дугаар сарын 20 өдөр тендерийг нээж, хянан үзэж, үнэлэн 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр захиалагч “Эрдэнэс Оюу Толгой” ХХК болон гүйцэтгэгч “Монхидроконстракшн” ХХК-ийн хооронд “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г, мөн захиалагч “Эрдэнэс Оюу Толгой” ХХК, санхүүжүүлэгч “Оюу Толгой” ХХК болон гүйцэтгэгч “Монхидроконстракшн” ХХК-ийн хооронд “Санхүүжилтийн гэрээ”-г тус тус байгуулан “Хэрлэн-Тооно” төслийн ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах ажлыг эхлүүлсэн. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор: Говийн бүсийг экологийн усаар хангах энэхүү төслийн ТЭЗҮ-ийн тодотгол хийх ажлыг гүйцэтгэхэд Засгийн газар болон холбогдох мэргэжлийн байгууллага, орон нутгийн санал, дүгнэлт, шийдвэрийг уялдуулан тооцоо судалгаа, шинжилгээний ажлыг хийхэд анхаарч, гүйцэтгэгч компанийн хэрэгжилтэд зөвлөх багтай хамтран хяналт тавин ажиллаж байна. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төслийн эхлэлийн тайланг 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр, Хайгуул судалгааны ажлын явцын эхний үе шатны тайланг 2025 оны 03 дугаар сарын 30-ны өдөр, Хайгуул судалгааны ажлын төгсгөлийн ба зураг төслийн ажлын явцын 2 дох шатны тайланг 2025 оны 08 дүгээр сарын 30-ны өдөр, ТЭЗҮ-ийн тооцоо зураглалын ажлын явц ба санхүү эдийн засгийн урьдчилсан судалгааны 3 дах үе шаны тайланг 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр тус тус хүлээн авч хяналтыг гүйцэтгээд байна. Түүнчлэн төслийн явцын тайлан мэдээг тухай бүр яам, агентлаг, төслийн нэгж, ажлын хэсэг, толгой компани болон Оюу Толгой ХХК-д танилцуулан санал авч ажиллаж байна. Төслийн тайланг хянан баталгаажуулах асуудлаар: Монхидроконстракшн ХХК нь Хэрлэн Тооно төслийн ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулах ажлыг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу гүйцэтгэж холбогдох тайланг боловсруулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны дэргэдэх Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Усны нөөцийн зөвлөлөөс шинжээчдийг томилон тайланд санал зөвлөмж өгч ажиллаж байна. Үүний дараагаар бусад холбогдох байгууллагуудаар хянан баталгаажуулж, шийдвэрлүүлсний үндсэн дээр 2026 оны 1 дүгээр улиралд тайланг эцэслэн боловсруулж хүлээлгэн өгөхөөр төлөвлөн ажиллаж байна. “Оюу Толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төлөөлөгч томилох, удирдамж батлах асуудлыг “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүү танилцуулсан. Үүнтэй холбогдуулан:
3	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2024.06.06-ны өдрийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай” 53 дугаар тогтоол	
4	“Эрдэнэс ХХК-ийн 2024.04.18-ны өдрийн Монгол” ТУЗ-ийн	

хуралдааны 01 дүгээр тэмдэглэл, "Оюу Толгой" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хурал, Төлөөлөн удирдах хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой баримт, материалыг танилцах боломжит хугацаанд ирүүлж байх тухай	1. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 82 дугаар тогтоолоор баталсан "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.1, 4.5 дахь хэсэгт заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлыг гишүүдэд судалж танилцах хангалттай хугацаа олгож, холбогдох материалуудын бүрдлийг хангаж ирүүлж байхыг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд даалгасан. Компанийн тухай хуулийн, - 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэгт "Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, гүйцэтгэх удирдлагыг томилох, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна." гэж; - 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсэгт "Төр болон бусад хуулийн этгээд аливаа компанид хөрөнгө оруулсныхаа төлөө эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээ хэрэгжүүлэхдээ дүрэмдээ заасан эрх бүхий этгээдээс томилсон төлөөлөгчөөр дамжуулан төлөөллөө хэрэгжүүлэх бөгөөд энэхүү төлөөлөгч нь уг төлөөллийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль болон тухайн компанийн дүрэмд заасан эрх бүхий этгээдээс өгсөн удирдамжийг үндэслэх ба энэхүү удирдамжаас өөрөөр санал гаргасан нь түүнийг энэхүү төлөөллийг хэрэгжүүлэх эрхээс чөлөөлөх үндэслэл болно." гэж; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн, - 21 дүгээр зүйлийн 21.6-д "Төрийн өмчийн төлөөлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана. Удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно." гэж; - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралтаар шинэчлэн батлагдсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 1.2-т "Энэ журмын зохицуулалтад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой дараах хуулийн этгээд (цаашид "төрийн өмчит компани" гэх) хамаарна." гэж мөн журмын 1.2.2-т "нийт гаргасан энгийн хувьцааны 34-өөс 100 хүртэл хувийг нь төр эзэмшдэг төрийн өмчийн оролцоотой компани." гэж; - 2.8-д "Оюутолгой" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл болгосны дагуу "Эрдэнэс Монгол" ХХК нэр дэвшүүлж, "Оюутолгой" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал томилж, чөлөөлнө." гэж; - 6.3-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь ажлын гүйцэтгэл, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг жил бүр хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид хүргүүлнэ." гэж; - 7.4-т "... төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсийг тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал тус тус батална." гэж;
--	---

	- 8.2-т "Хууль, энэ журамд нийцсэн удирдамж, чиглэлийг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй, энэ журмын 8.1-д заасан үйлдлийг гаргасан нь тогтоогдсон тохиолдолд төрийн өмчийн төлөөлөгчийн бүрэн эрхийг дуусгавар болгоно." гэж; - 8.3-т "Эрх бүхий этгээдээс баталсан удирдамжийн дагуу гарсан хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээс үүсэх үр дагаврыг энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан этгээд хариуцахгүй." гэж тус тус журамд заасны дагуу ОТ ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хуралд төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч-Монголын талын ТУЗ-ийн гишүүд толгой компани ЭМГЛ ХХК-ийн ТУЗ-өөс баталсан удирдамжийн дагуу ОТ ХХК-ийн ТУЗ-ийн хуралд оролцож байна. НӨӨДТХНГ-ний 5.6-ын (а)-д "ТУЗ-ийн хурлыг улиралд 1 (нэг) удаа хуралдуулна. Аливаа 3 (гурван) ТУЗ-ийн гишүүний хүсэлтээр түүнээс олон удаа хуралдуулж болно. Онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд хамгийн сүүлийн хурлаас хойш 30 (гуч) хоногийн дотор дараагийн хурлыг хуралдуулахыг 3 (гурван) ТУЗ-ийн гишүүн шаардах эрхгүй." гэж, мөн гэрээний 5.6-ын (а) (ii)-д "ТУЗ-ийн хурлын зарыг гишүүдэд 21 (хорин нэг)-ээс доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ." гэсний дагуу ОТ ХХК-ийн ТУЗ-ийн хурлыг зарласан тохиолдолд I. ЭОТ ХХК-иас энэ талаарх мэдээлэл болон ОТ ХХК-ийн ТУЗ-ийн хуралд оролцох төрийн төлөөлөгчийн баримтлах удирдамж, танилцуулгын төслийг ирүүлсэн баримт-мэдээллийн хэмжээнд судлан боловсруулж, ЭОТ ХХК-ийн дүрмийн 1.2.2, 2.1.3-д заасны дагуу мэдээлэл-удирдамж, танилцуулгын төслийг хамтад нь хувьцаа эзэмшигч ЭМГЛ ХХК-д хүргүүлж; II. ЭОТ ХХК-ийн хувьцаа эзэмшигч буюу толгой компани ЭМГЛ ХХК-иас ОТ ХХК-ийн ТУЗ-ийн хуралд төрийн төлөөллийг хэрэгжүүлэгчийг болон түүний (тэдгээрийн) баримтлах удирдамжийн хамт Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.6, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралтаар шинэчлэн батлагдсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 2.1.1, 2.1.2, ЭМГЛ ХХК болон ЭОТ ХХК-ийн дүрэмд заасны дагуу баталж; III. ОТ ХХК-ийн ТУЗ-ийн хуралд ЭМГЛ ХХК (ТУЗ)-иас батлагдсан удирдамжийг баримтлан товлосон хугацаанд нь хуралд оролцож, ОТ төслийн талаарх төрийн байр суурийг илэрхийлэн саналаа өгч оролцож байна. Дээрх ажиллагаанд тодорхой хугацаа шаардлагатай нь дамжиггүй юм. Гэвч ОТ ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит хурлын үргэлжлэл хурлыг анх товлөгдож, хуралдаж, завсарласан өдрөөс хойш 1-2 өдрийн дараа дахин зарлах, ээлжит бус хурлыг 5 хоногийн дараа зарлах зэргээр бодит бус хугацаагаар ОТ ХХК-ийн ТУЗ-ийн хурлууд товлөгдож, хуралдаж, өндөр ач холбогдолтой, нухацтайгаар анхаарал хандуулбал зохих асуудлууд шийдвэрлэгдсээр ирсэн. Энэ байдлыг залруулах зорилгоор ЭОТ ХХК-ийн зүгээс ОТ ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлыг товлон, түүнтэй холбогдуулан хурлаар хэлэлцэх асуудлуудын талаар мэдээлэл ирүүлэх ажиллагаатай холбогдуулан Оюу Толгой" ХХК-ийн гадаадын хөрөнгө оруулагч - хувьцаа эзэмшигч талуудын төлөөлөлтэй, - 2024 оны 6 дугаар сарын 07-ны өдөр; - 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдөр; - 2024 оны 6 дугаар сарын 19-ний өдөр;
--	--

	- 2024 оны 7 дугаар сарын 17-ны өдөр; - 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдөр; - 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн уулзалтуудыг хийж урьдчилсан байдлаар ОТ ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит хурлын үргэлжлэл хурлыг хурал завсарласан өдрөөс хойш багадаа 7 хоногийн дараа, ээлжит бус хурлыг багадаа 15 хоногийн дараа товлон зарлаж, хуралдуулах талаар нэгдсэн ойлголтод хүрээд байна. Ингэснээр ЭМГЛ ХХК-ийн ТУЗ-ийн хуралд хугацааг нь тулгаж, яарч Удирдамж, танилцуулгыг боловсруулах, танилцуулах явдлыг зогсоож ач холбогдол өндөртэй, нухацтай хандаж, авч үзэх асуудлаар илүү дэлгэрэнгүй судлах, санал, дүгнэлт боловсруулах, хэлэлцүүлэх цаг хугацааны боломж бүрдэнэ гэж тооцож байна.
5	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын албанаас гаргасан дүгнэлттэй уялдуулан “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн 2025 оны төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд үүрэг болгов. Хэрэгжилт: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ДАГ-аас тус асуудлаар аудит хийгдсэн бөгөөд энэ хүрээнд шаардлагатай материал, баримт, мэдээллийг ТУЗ-ийн дэргэдэх ДАГ-т гарган өгч, нийт ажилтнууд асуулгад хамрагдан, хариу тайлбар өгч хамтран ажилласан бөгөөд Дотоод аудитын газраас 2025.05.13-ний өдөр дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайланг ирүүлсэн. Дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд төсөв, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж ажиллааа.
6	20.2.1 “Эрдэнэс Монгол” ХХК, түүний нэгдлийн хэмжээнд борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлыг бууруулах, хөрөнгө оруулалтыг хойшлуулах замаар 4 их наяд төгрөгийг төвлөрүүлэх болон улс, орон нутгийн төсөвт оруулж, татварын орлого, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт), түүнийн нэгдлийн хуулийн этгээдүүдэд. 20.2.2 “Эрдэнэс Монгол” ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдүүдийн засаглал, үр ашгийг сайжруулах хүрээнд бүтцийг оновчтой тогтоох, шинэчлэл хийх зорилгоор үр ашиггүй, чиг үүргийн давхардалтай хуулийн этгээдүүдийг нэгтгэх, татан буулгах, шилжүүлэх, захиргааны болон удирдах ажилтны тоог бууруулах, нэгдлийн хэмжээнд ажлын үр дүн, бүтээмжид суурилсан цалин, урамшууллын систем нэвтрүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт), түүнийн нэгдлийн хуулийн этгээдүүдэд. Хэрэгжилт: Оюу Толгой ордыг ашиглахтай холбоотой УИХ/ЗГ-ын тогтоол, захирамжийн биелэлтийг хангуулах замаар Монгол улсын хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах хүрээнд ЗГХЭГ, толгой компаниас ирүүлсэн чиглэлийг баримтлан батлагдсан төсвийг хэмнэж, бүтцэд батлагдсан орон тооноос чөлөөлөгдсөн албан хаагчдын сул ажлын байрыг орлох замаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. (31 орон тоо батлагдсанаас 23 ажилан ажиллаж байна.) Татварын өр, авлагагүй, үргүй зардлыг бууруулах тал дээр онцгой анхаарч ажилласан. Компанийн дотоод үйл ажиллагаанд холбогдох нийт дүрэм журмыг шинэчлэн сайжруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан дүрэм журмын төслүүдийг шат дараатайгаар шинэчлэн сайжруулах ажиллагааг хэрэгжүүлж байгаагийн дотор "Гүйцэтгэлийн үнэлгээний журам" -ыг боловсруулан баталж, журмын дагуу үр дүнг тооцож үнэлдэг шударга зарчмыг нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.
7	"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 01 дүгээр тэмдэглэл. 1. "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит 60 дугаар хурлаар хэлэлцэгдэх асуудлаар Монголын талын төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүдэд өгөх удирдамжид гарын үсэг зурж баталгаажуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ш.Мөнхцэрэнд зөвшөөрөв. Хэрэгжилт: 1/ ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцэж шийдвэрлэх асуудалтай холбогдуулан Удирдамжийн төсөл, Танилцуулгыг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-иас боловсруулж, 2025.03.06-ны өдрийн 01/51 дугаартай албан бичгээр толгой компанид хүргэж, 2025.03.11-ний өдөр толгой компани "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн хуралд танилцуулсан. 2/ Тус хурлаар хэлэлцсэний дагуу ОТ ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит 60 дугаар хурлаар хэлэлцэх асуудлаар төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч Монголын талын гишүүдийн баримтлах "Удирдамж"-ийг толгой компани "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн дарга Ш.Мөнхцэрэн 2025.03.11-ний өдөр баталсан. 2. "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд Монголын талын төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүдэд удирдамжийг хүргүүлж, хэрэгжилтийг эргэн тайлагнах арга хэмжээ авахыг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогтод тус тус даалгав. Хэрэгжилт: 1/ ОТ ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит 60 дугаар хурлын 2025.03.11-ний өдөр баталсан "Удирдамж"-ийг Монголын талын төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүдэд хүргэж, тус удирдамжийн дагуу гишүүд Оюу Толгой төсөл болон компанийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах, төслийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг зөв, зохистой байдлаар шийдвэрлэх зарчмын асуудалд Монголын талын эрх ашгийг хамгаалах байр суурийг илэрхийлж, ТУЗ-ийн ээлжит 60 дугаар хуралд оролцсон. 2/ ОТ ХХК-ийн ТУЗ-ийн ээлжит 60 дугаар хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлаар "Илтгэх хуудас"-ыг 2025.06.16-ны өдрийн №01/154 дугаартай албан бичгээр толгой компани болон ТУЗ-ийн дарга Ш.Мөнхцэрэнд хүргэсэн.

8	“Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн хурлын 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн “Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэх явцад өгсөн санал, зөвлөмж болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын газрын дүгнэлт, түүнд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах; 2.2.Эрдэнэс Монгол нэгдлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах; 2.3.Батлагдсан стратеги төлөвлөгөөтэй уялдуулан Компанийн засаглал, шийдвэр гаргах ажиллагаа, санхүүгийн болон хүний нөөцийн бүхий л үйл ажиллагааны талаарх дотоод зохицуулалтыг хууль, журамд нийцүүлэн сайжруулж, мөрдөн ажиллах; 2.4.“Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын мэдээллийг Хувь нийлүүлэгчдийн гэрээнд заасан хугацаанд Толгой компанид хүргүүлж, урьдчилан судлах, санал дүгнэлт боловсруулах боломжит нөхцөлөөр хангаж байх; 2.5.“Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Монголын талын гишүүд хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг төлөөлөх, үр дүнг хувьцаа эзэмшигчид тайлагнах чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, уг үйл ажиллагаанд баримтлах зохицуулалт, хэм хэмжээг сайжруулах, шаардлагатай бол шинээр батлуулан хэрэгжүүлэх. 3.“Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлт ирүүлснийг дурдаж, тус аудитын дүгнэлтэд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг 2025 оны 3 дугаар улиралд багтаан “Эрдэнэс Монгол” ХХК-д танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Ганхүү)-д үүрэг болгосугай.	2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллах, үр дүнг 2025 оны 3 дугаар улиралд “Эрдэнэс Монгол” ХХК-д танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Ганхүү)-д даалгасугай. 2.1.Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэх явцад өгсөн санал, зөвлөмж болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын газрын дүгнэлт, түүнд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах; 2.2.Эрдэнэс Монгол нэгдлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах; 2.3.Батлагдсан стратеги төлөвлөгөөтэй уялдуулан Компанийн засаглал, шийдвэр гаргах ажиллагаа, санхүүгийн болон хүний нөөцийн бүхий л үйл ажиллагааны талаарх дотоод зохицуулалтыг хууль, журамд нийцүүлэн сайжруулж, мөрдөн ажиллах; 2.4.“Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын мэдээллийг Хувь нийлүүлэгчдийн гэрээнд заасан хугацаанд Толгой компанид хүргүүлж, урьдчилан судлах, санал дүгнэлт боловсруулах боломжит нөхцөлөөр хангаж байх; 2.5.“Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Монголын талын гишүүд хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг төлөөлөх, үр дүнг хувьцаа эзэмшигчид тайлагнах чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, уг үйл ажиллагаанд баримтлах зохицуулалт, хэм хэмжээг сайжруулах, шаардлагатай бол шинээр батлуулан хэрэгжүүлэх. 3.“Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлт ирүүлснийг дурдаж, тус аудитын дүгнэлтэд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг 2025 оны 3 дугаар улиралд багтаан “Эрдэнэс Монгол” ХХК-д танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Ганхүү)-д үүрэг болгосугай.
---	--	---

Хэрэгжилт:

2.“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын газрын дүгнэлт, зөвлөмжүүд бүхий аудитын тайланг 2025.05.13-ны өдөр ирүүлсэн бөгөөд хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллалаа. (хэрэгжилт №7-г харах)

“Эрдэнэс Монгол” нэгдлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн стратеги төлөвлөгөөг боловсруулан 2025.05.07-ны өдрийн 01/12 дугаартай бичгээр хүргүүлээд байна.

Компанийн дотоод үйл ажиллагааны нийт дүрэм журмын шинэчлэн сайжруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан дүрэм журмын төслүүдийг шат дараатайгаар шинэчлэн баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн Дотоод хяналт хэрэгжүүлэх аргачлалыг шинээр батлан мөрдөж байна.

“Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Монголын талын гишүүд хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг төлөөлөх, үр дүнг хувьцаа эзэмшигчид тайлагнах чиг үүргийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж буй бөгөөд уг үйл ажиллагаанд баримтлах журмыг боловсруулсан, ОТ ХХК-ийн засаглалыг сайжруулах үйл ажиллагааны үр дүнтэй холбоотойгоор хүлээгдэж байна.

9	"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн "Дотоод аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 56 дугаар тогтоол.	3.Компанийн үйл ажиллагаанд ҮАГ-аас хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчлийг арилгах үйл ажиллагааны төлөвлөгөө гарган баталж, бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. 1. "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн засаглал, чиг үүрэг, үйл ажиллагааны үр ашиг, өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, компанийн засаглалыг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дотоод аудитын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан дотоод аудитын тайланд туссан зөвлөмжүүдийг хэрэгжүүлж, биелэлтийг эргэн тайлагнахыг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд даалгасугай. 2. "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн дүрмийг үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, дүрэмд санхүүжилтийн тогтолцоог тодорхой тусгаж, 2025 оны 2 дугаар улиралд Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогтод даалгасугай. Хэрэгжилт: "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дотоод аудитын газраас 2025.05.13-ны өдөр ирүүлсэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайланг ирүүлсэн. Үүний дагуу "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн засаглал, чиг үүрэг, үйл ажиллагааны үр ашиг, өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, компанийн засаглалыг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган 2025.05.19-ний өдрийн 01/123 дугаартай "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгээр "Эрдэнэс Монгол" ХХК-д хүргүүлсэн. -Зөвлөмжийн дагуу компанийн дүрэмд шаардлагатай өөрчлөлтүүдийг тусган толгой компанийн ТУЗ-д хүргүүлсэн ба толгой компанийн дүрмийн өөрчлөлттэй холбогдон хүлээгдэж байна. -Компанийн цахим хуудсыг 100% ашиглалтад оруулж, хэвийн үйл ажиллагааг ханган, шаардлагатай мэдээллийг тухай бүрд нийтлэн ажиллаж байна. Шилэн дансны мэдээллийг компанийн болон шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд нь тухай бүрд бүрэн байрлуулж хэрэгжилтийг 100% хангаж ажиллалаа. -Компанийн дунд хугацааны Стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулан хүргүүлсэн бөгөөд ТУЗ-аар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна. -ОТ ХХК-ийн ТУЗ-ийн Монгол талын гишүүдийн гүйцэтгэх үүрэг, ажлын үр дүнг тайлагнах, үнэлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах "Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүний ажиллах журам"-ын төслийг боловсруулаад байгаа бөгөөд ОТ ХХК-ийн засаглалыг сайжруулах ажлын тайлан, үр дүнтэй холбогдуулан түр хүлээгдэж байна. -Компанийн дотоод хяналт хэрэгжүүлэх журмыг батлан мөрдөж, шинэ бүтэц орон тоонд дотоод хяналтын чиг үүргийг тусгайлан хэрэгжүүлж ажиллаж байна. -Ажлын байранд тавигдах шаардлагуудыг шинэчлэн, чиг үүрэг, зохион байгуулалтын холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, АБТ-уудыг боловсруулж батлан хэрэгжүүлж байна. -Ажлын байрны тодорхойлолтод няравын ажлын чиг үүргийг тусган хэрэгжүүлж байна. -2024 оны худалдан авах ажиллагааны хүрээнд авсан зохих стандарт шаардлага хангасан архивын өрөө тасалгаа, ажиллах орчин бүхий оффисын талбайг бүрэн ашиглалтад авч үйл ажиллагаагаа явуулж байна. Архивын материалыг зориулалтын өрөө тасалгаанд хадгалж байна.
---	---	--

		-Компанийн дотоод үйл ажиллагааны нийт дүрэм журмыг шинэчлэн сайжруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан дүрэм журмуудыг шат дараатайгаар шинэчлэн сайжруулах ажиллагааг хэрэгжүүлээ. Зөвлөмжийн хэрэгжилтийг компанийн үйл ажиллагааны тайланд тусгасан байдлаар улирал бүр хувьцаа эзэмшигчид хүргүүлсэн.
10	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2025.04.08-ны өдрийн “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн бүтэц, орон тоо, 2025 оны 2 дугаар улирлын үйл ажиллагааны зардлыг батлах тухай” 57 дугаар тогтоол	1.Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн зохион байгуулалтын бүтцийг нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталж, орон тооны хязгаарыг нийт 31 байхаар тогтоосугай. 2.“Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн 2025 оны 2 дугаар улирлын үйл ажиллагааны зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай. Тус шийдвэрийн дагуу бүтэц, орон тоо, ажлын байрны чиг үүргийг шинэчлэн зохион байгуулж, энэ хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.
11	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох төлөөлөгчийг томилох, удирдамж батлах тухай” 58 дугаар тогтоол.	1. “Оюу Толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийг төлөөлж “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт (саналын эрхтэй), “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүү нарыг томилон оролцуулсугай. Хэрэгжилт: ОТ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит 23 дугаар хуралд төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийг төлөөлж оролцох саналын эрхтэй төлөөлөгчөөр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүү нарыг оролцуулахаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2025.04.23-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох төлөөлөгчийг томилох, удирдамж батлах тухай” 58 дугаар тогтоолоор томилсны дагуу тус хуралд оролцсон. 2. “Оюу Толгой” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төлөөлөгчийн баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай. Хэрэгжилт: ОТ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэж шийдвэрлэх асуудалтай холбогдуулан Удирдамжийн төсөл, Танилцуулгыг “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-иас боловсруулж, 2025.04.17-ны өдрийн 01/91 дугаартай албан бичгээр толгой компанид хүргэж, 2025.04.23-ны өдөр толгой компани “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн хуралд танилцуулж, батлуулсан.

	3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон талаарх тайланг 2025 оны 05 дугаар сард багтаан Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд тайлагнахыг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд үүрэг болгосугай. Хэрэгжилт: ОТ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч Монголын талын гишүүдийн баримтлах "Удирдамж"-ийг толгой компани "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн 2025.04.23-ны өдрийн "Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох төлөөлөгчийг томилох, удирдамж батлах тухай" 58 дугаар тогтоолоор баталж, хэрэгжилтийг хангасан.
12	"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025.08.05-ны өдрийн "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн 2025 оны төсөв батлах тухай 90 дугаар тогтоол 1. "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн 2025 оны төсвийг хавсралтаар баталсугай. 2. Компанийн 2025 оны баталсан төсвийг мөрдөх, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд захиран зарцуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд үүрэг болгосугай. 3. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын газрын "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн дүрмийн шинэчлэлт, санхүүжилтийн загвар, гүйцэтгэх чиг, үүргийн талаар 2025 оны 3 дугаар улиралд багтаан танилцуулахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүү нарт үүрэг болгосугай. Хэрэгжилт: 2. 2025 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу 7.5 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардлын төсөвтэйгөөр үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн. Үндсэн үйл ажиллагааны зардалд 3.5 тэрбум төгрөг зарцуулсан. 2024 онд оффисын барилга худалдан авахад урьдчилгаа төлбөрт 70%-ийг төлсөн байсан. 2025 онд барилга ашиглалтанд орж үлдэгдэл 30% болох 2.4 тэрбум төгрөгийг төлсөн. 2025 оны төсөвт тусгагдсанаар Засгийн газрын 38 дугаар тэмдэглэлийн дагуу Оюу Толгой төслийн Хувь нийлүүлэгчдийн зээл болон зээлийн хүүг бууруулах ажлын зөвлөх үйлчилгээнд зориулж "Эрдэнэс Монгол" ХХК-аас авах байсан 2 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг авалгүйгээр өөрийн нөөц бололцоог ашиглан дотоодын зөвлөх авч ажиллуулсан. 2025 онд төсвийн үзүүлэлт тус бүрээр хэмнэлт гарган, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн үндсэн үйл ажиллагааны зардал болох 5.5 тэрбум төгрөгөөс 3.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 64%-ийн гүйцэтгэлтэй, 36%-ийн бодит хэмнэлттэй ажиллалаа.

13	3. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газраас дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайланг 2025.05.13-ний өдөр ирүүлсэн. Үүний дагуу "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн засаглал, чиг үүрэг, үйл ажиллагааны үр ашиг, өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, компанийн засаглалыг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлын төлөвлөгөөг боловсруулж, 2025.05.19-ний өдрийн 01/123 дугаартай "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгээр "Эрдэнэс Монгол" ХХК-д хүргүүлсэн. -Зөвлөмжийн дагуу компанийн дүрэмд шаардлагатай өөрчлөлтүүдийг тусган толгой компанийн ТУЗ-д хүргүүлсэн ба толгой компанийн дүрмийн өөрчлөлттэй холбогдон хүлээгдэж байна. -Компанийн цахим хуудсыг 100% ашиглалтад оруулж, хэвийн үйл ажиллагааг ханган, шаардлагатай мэдээллийг тухай бүрд нийтлэн ажиллаж байна. Шилэн дансны мэдээллийг компанийн болон шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд хугацаанд нь тухай бүрд бүрэн байрлуулж хэрэгжилтийг 100% хангаж ажиллалаа. -Компанийн дунд хугацааны Стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулан хүргүүлсэн бөгөөд ТУЗ-аар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна. -ОТ ХХК-ийн ТУЗ-ийн Монгол талын гишүүдийн гүйцэтгэх үүрэг, ажлын үр дүнг тайлагнах, үнэлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах "Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүний ажиллах журам"-ын төслийг боловсруулаад байгаа бөгөөд ОТ ХХК-ийн засаглалыг сайжруулах ажлын тайлан, үр дүнтэй холбогдуулан түр хүлээгдэж байна. -Компанийн дотоод хяналт хэрэгжүүлэх журмыг батлан мөрдөж, шинэ бүтэц орон тоонд дотоод хяналтын чиг үүргийг тусгайлан хэрэгжүүлж ажиллаж байна. -Ажлын байранд тавигдах шаардлагуудыг шинэчлэн, чиг үүрэг, зохион байгуулалтын холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, АБТ-уудыг боловсруулж батлан хэрэгжүүлж байна. -Ажлын байрны тодорхойлолтод няравын ажлын чиг үүргийг тусган хэрэгжүүлж байна. -2024 оны худалдан авах ажиллагааны хүрээнд, зохих стандарт шаардлага хангасан архивын өрөө тасалгаа, ажиллах орчин бүхий оффисын талбай шинээр худалдан авч үйл ажиллагаагаа явуулж байна. Архивын материалыг зориулалтын өрөө тасалгаанд хадгалж байна. -Компанийн дотоод үйл ажиллагааны нийт дүрэм журмыг шинэчлэн сайжруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан дүрэм журмын төслүүдийг шат дараатайгаар шинэчлэн сайжруулах ажиллагааг хэрэгжүүлээ. Хэрэгжилтийг компанийн үйл ажиллагааны тайланд тусгаснаар улирал бүр хувьцаа эзэмшигчид хүргүүлсэн. 1. "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Хувьцаа эзэмшигчдийн тогтоолд хавсралтад заасан удирдамжийг баримтлан гарын үсэг зурах эрхийг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд олгосугай. 2. "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Хувьцаа эзэмшигчдийн тогтоолд хавсралтад заасан удирдамжийг баримтлан гарын үсэг зурах эрхийг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд олгосугай. 3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийн өмчийн төлөөллийн гишүүний ажлыг хүлээлцэж, гишүүнээр ажиллах хугацааны нууцтай холбоотой бүх мэдээллийг хүлээлгэн
"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн "Хувьцаа эзэмшигчдийн тогтоолд гарын үсэг зурах эрх	

	олгох тухай" 98 дугаар тогтоол	өгч, цаашид мэдээллийн нууцлалыг хангахыг Э.Баясгаланд, холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд тус тус үүрэг болгосугай.
		Хэрэгжилт: 1. "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүнийг чөлөөлж, томилох асуудлаар Хувьцаа эзэмшигчдийн тогтоолд гарын үсэг зурах эрхийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн 2025.10.07-ны өдрийн 98-р тогтоолоор "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд олгосон. 2. Тус тогтоолын хавсралтаар баримтлах Удирдамж батлагдаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025.10.03-ны өдрийн ХЭГ/2760 дугаартай албан бичгээр "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүнийг чөлөөлж, томилуулах чиглэлийн дагуу "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн Э.Баясгаланг чөлөөлж, Д.Цолмонг томилох тухай Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 61-р тогтоолд "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүү гарын зурж, хэрэгжилтийг хангасан. 1. "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Хувьцаа эзэмшигчдийн тогтоолд хавсралтад заасан удирдамжийг баримтлан гарын үсэг зурах эрхийг "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд олгосугай. Хэрэгжилт: 1. "Оюу Толгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд гадаадын хөрөнгө оруулагчийн төлөөлөл гишүүнийг чөлөөлж, томилох асуудлаар Хувьцаа эзэмшигчдийн тогтоолд гарын үсэг зурах эрхийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн 2025.12.19-ний өдрийн 128-р тогтоолоор "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүүд олгосон. 2. Тус тогтоолын хавсралтаар баримтлах Удирдамж батлагдаж, гадаадын хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн саналын дагуу Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээний 5.3(а)(б)(г) заалтыг үндэслэн ТУЗ-ийн гишүүн Дэйдрэ Лингенфэлдерийг 2025.12.09-ний өдрөөс чөлөөлж, Эндрью Лая-г 2025.12.09-ний өдрөөс 2026.02.01-ний өдрийг хүртэл "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилох тухай Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 62-р тогтоолд "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Ганхүү гарын зурж, хэрэгжилтийг хангасан. Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой болгох, удирдах, гүйцэтгэх албан тушаалын зохистой харьцааг хангах, давхардлыг арилгах, төсөв, зардлыг хэмнэх бодлого тодорхой болох хүртэлх хугацаанд яам, Засгийн газрын агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг зогсоож, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгож, орон тоог нэмэгдүүлэхгүй байхын зэрэгцээ өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байх.
14	"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "Хувьцаа эзэмшигчдийн тогтоолд гарын үсэг зурах эрх олгох тухай" 128 дугаар тогтоол	
15	ЗГХЭГ-ын даргын 2025.06.23-ны өдрийн ХЭГ/1760-д хамаарах "Эрдэнэс Монгол" ХХК-ийн 2025.06.27-ны өдрийн 07/1870	

	Хэрэгжилт: Компанийн зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой болгох, сайжруулах хүрээнд компанийн бүтэц, орон тоог шинэчлэн төлөвлөж, үүнийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2025.04.08-ны өдрийн 57 дугаартай тогтоолоор баталсан. Компанийн бүтэц, орон тоог шинэчлэн төлөвлөж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2025.04.08-ны өдрийн 57 дугаартай тогтоолоор шинэчлэн баталсан. Үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах хүрээнд ЗГХЭГ, толгой компаниас ирүүлсэн чиглэлийг баримтлан батлагдсан төсвийг хэмнэж, бүтцэд батлагдсан орон тооноос чөлөөлөгдсөн албан хаагчдын сул ажлын байрыг орлох замаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. (31 орон тоо батлагдсанаас 23 ажилан ажиллаж байна.)
16 “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2025.10.03-ны өдрийн 01/1260 дугаартай бичгээр өгсөн чиглэл	1. Үйл ажиллагааны зардлыг бууруулах, хөрөнгө оруулалтыг хойшлуулах замаар төсвийн хэмнэлт хийх, гадаад валютын гарах урсгалыг сааруулах, 2. Засаглал, үр ашгийг сайжруулах хүрээнд бүтцийг оновчтой тогтоох, шинэчлэл хийх зорилгоор захиргааны болон удирдах ажилтны тоог бууруулах арга хэмжээ авч ажиллах, 3. Хууль, шүүхийн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, санхүүгийн сахилга батыг сахиулах, өр, авлагыг барагдуулах чиглэлээр шуурхай арга хэмжээ авч ажиллах, Хэрэгжилт: -Оюу Толгой ордыг ашиглахтай холбоотой УИХ/ЗГ-ын тогтоол, захирамжийн биелэлтийг хангуулах замаар Монгол улсын хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. -Компанийн зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой болгох, сайжруулах хүрээнд компанийн бүтэц, орон тоог шинэчлэн төлөвлөж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2025.04.08-ны өдрийн 57 дугаартай тогтоолоор шинэчлэн баталсан. Үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах хүрээнд ЗГХЭГ, толгой компаниас ирүүлсэн чиглэлийг баримтлан батлагдсан төсвийг хэмнэж, бүтцэд батлагдсан орон тооноос чөлөөлөгдсөн албан хаагчдын сул ажлын байрыг орлох замаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. (31 орон тоо батлагдсанаас 23 ажилан ажиллаж байна.) Татварын өр, авлагагүй, үргүй зардлыг бууруулах тал дээр онцгой анхаарч ажилласан. -Гадаад томилолтын үйл ажиллагааг хязгаарлаж, төсвийг танасан.

---oOo---

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТАЙЛАН

Ерөнхий мэдээлэл: “Эрдэнэс Оюу Толгой” ХХК нь үйл ажиллагааны оновчтой бүтэцтэй ажиллах бодлогын хүрээнд Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг Бүтээмж, засаглалын хэлтэст Дотоод хяналт, эрсдэл хариуцсан мэргэжилтэн хариуцан хэрэгжүүлж байна. Компани нь үйл ажиллагаандаа “Эрдэнэс Монгол” нэгдлийн эрсдэлийн удирдлагын бодлого, жишиг аргачлал болон компанийн “Эрсдэлийн удирдлагын журам”-ыг мөрдлөг болгон ажилладаг. Энэхүү тайланг “Эрдэнэс Монгол” нэгдлээс ирүүлсэн үлгэрчилсэн загварын дагуу боловсруулав.

Хамрах хүрээ: Газар, хэлтэс, нэгжүүд

Зорилго: Энэхүү тайлангийн зорилго нь 2025 оны бизнес төлөвлөгөөний зорилтуудад учирч болзошгүй эрсдэлүүдийг хянах, хариу арга хэмжээний хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх, эрсдэлийн удирдлагын төлөвшлийн түвшинг тодорхойлох замаар ирэх оны шийдвэр гаргалт, төлөвлөлтөд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Нэг. Эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

1.1 Эрсдэлийг хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

1.1.1 Нийт тодорхойлсон эрсдэлийн дүн шинжилгээ, анализ

Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөний зорилт бүрд холбогдох эрсдэлийн бүртгэл, үнэлгээ, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, нийт 7 зорилгын хүрээнд 49 эрсдэлийг бүртгэж, хариу арга хэмжээг төлөвлөн ажилласан. Үүнээс эрсдэлийн ангиллаар авч үзвэл санхүүгийн эрсдэл 10, үйл ажиллагааны эрсдэл 39 мөн магадлал нөлөөллөөр үнэлэн эрсдэлийн түвшинг тодорхойлсон бөгөөд бага – 4, дунд – 38, өндөр - 7 эрсдэл үнэлэгдсэн ба компанийн эрсдэлийн түвшин ДУНД түвшинд үнэлэгдсэн.

1.1.2 Эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал (бүрэн арилсан, түвшин буураагүй, түвшин нэмэгдсэн эрсдэлийн мэдээлэл, шалтгаан нөхцөлийг дурдах)

Тодорхойлсон эрсдэлийн хариу арга хэмжээний арга хэлбэрээр авч үзвэл эрсдэлээс зайлсхийх, арилгах 5 (10,4%), бууруулах 40 (81%), шилжүүлэх 1 (2,5%), хүлээн зөвшөөрөх 3 (6,1%)-аас үзэхэд нийт эрсдэлийн 91,4 хувийг хяналтад байлгаж зохих хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлсэн.

Эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр Төлөвлөгөөт ажлуудын уялдаа холбоог сайжруулж, "Эрдэнэс Монгол" нэгдлийн бодлоготой нийцүүлснээр өндөр түвшний 7 эрсдэл дунд түвшинд буурч, дунд түвшний 37 эрсдэлээс 27 эрсдэл бага түвшинд шилжиж, эрсдэлийн түвшин буурсан.

Эрсдэлийн түвшин өссөн эрсдэл гараагүй болно. Мөн зарим эрсдэлүүдийн хувьд түвшин буураагүй ч эрсдэлийн түвшний тоон утга буурсан.

Мөн 2025 оны жилийн эцсийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтээр нийт 49 эрсдэлээс түвшин буурсан- 34 эрсдэл, бүрэн арилсан- 6 эрсдэл, өөрчлөлтгүй- 9 эрсдэлд хяналтын үнэлгээ хийж ажилласан. *(дэлгэрэнгүйг Хавсралт 1)*

1.1.3 Эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн онцлох арга хэмжээ

1. Ажлын байрны цогц шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж, байгууллагын хүний нөөцийн менежментийн үйл ажиллагааг сайжруулсан.

2. Хөдөлмөрийн бүтээмж, ажиллах нөхцөлийг сайжруулахаар Компанийн дотоод хэм хэмжээ, эрх зүйн орчныг сайжруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан дүрэм, журмын төслүүдийг боловсруулан батлуулсан. Мөн байгууллагын ажилчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулахаар тусгасан.

3. Дотоод хяналт, эрсдэл хариуцсан мэргэжилтэнтэй болж, дотоод хяналт хэрэгжүүлэх журам боловсруулан, эрсдэлд суурилсан хяналтыг тогтмол сайжруулан ажилласан.

1.1.4 Хөндлөнгийн аудит, хяналт, шалгалтын тайлангаар илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцөл, алдаа зөрчил давтагдаж болзошгүй эрсдэлийн мэдээлэл

“Эрдэнэс Оюу Толгой” ХХК-д өмнө хийгдэж байсан аудит, хяналт, шалгалтын тайлангаар илэрсэн зөрчлийг залруулсан тул уг асуудлуудтай холбоотой эрсдэл бүртгээгүй болно.

1.2 Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, компанийн эрсдэлийн удирдлагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, үр дүн.

1.2.1 “Сургалтын төлөвлөгөө”-ний хэрэгжилт;

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Олон улсын стандартад нийцсэн эрсдэлийн удирдлага, эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх сургалтыг бүрэлдэхүүн компаниудыг хамруулан 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан ба уг сургалтад компанийн төлөөллийг хамруулсан. Сургалтын дараа уг сургалтад хамрагдсан төлөөлөл нь сургалтын явцад олж авсан мэдлэгийг хамт олондоо хуваалцаж ажилласан.

Мөн 09-р сарын 10-ны өдөр Эрдэнэс Монгол нэгдлийн охин, хараат компани, харьяа үйлдвэрийн газрын Эрсдэлийн удирдлага, Дотоод хяналтын чиг үүрэг хариуцсан ажилтнуудад мэдээлэл хүргэх цахим уулзалтад оролцсон бөгөөд уг уулзалтаар “нэгдлийн үйл ажиллагааны журам” дах холбогдох заалтуудын мэдээлэл, Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө болон тайлангийн үлгэрчилсэн загвар, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайлан зэрэг мэдээллүүдтэй танилцсан.

1.2.1 Бусад арга хэмжээний хэрэгжилт;

Нэгдлийн эрсдэлийн удирдлагыг бодлогын баримт бичиг, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх жишиг аргачлалыг шинэчлэхтэй холбоотой уг баримт бичгийн төслүүдтэй танилцан санал боловсруулан хүргүүлэв.

2024 оны Эрсдэлийн удирдлагын тайланг боловсруулж, “Эрдэнэс Монгол” ХХК-д компанийн үйл ажиллагааны тайлангийн хамт хүргүүлсэн.

Нэгдлийн хэмжээнд олон улсын стандартад нийцсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангах зорилгоор хөгжүүлсэн "E-control" системийг хэрэгжүүлэх боломжийг судлах, нэгдлийн бүрэлдэхүүн компаниудын хамтран ажиллах Ажлын хэсэг-т компанийн төлөөллийг хамруулан ажилласан.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичиг, эрсдэлийн бүртгэл, үнэлгээ, тайланг дундын шэйрт фолдерт нээлттэй байрлуулж, мэргэжилтнүүдийн оролцоог ханган толгой компаниас баталсан жишиг маягтын дагуу эрсдэлийн бүртгэл, үнэлгээ, хариу арга хэмжээний төлөвлөгөө, тайланг боловсруулан цагалбарын дагуу толгой компанид тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Мөн “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ий 2026 оны бизнес төлөвлөгөөнд туссан 7 зорилгын хүрээнд 50 зорилтын учирч болзошгүй нийт 92 эрсдэлийг тодорхойлсон бөгөөд эрсдэлийн ангиллаар авч үзвэл стратегийн эрсдэл 2, санхүүгийн эрсдэл 9, үйл ажиллагааны эрсдэл 69, БОНЗ эрсдэл 1, үйлдвэрлэлийн эрсдэл 5 тодорхойлогдсон.

Хоёр. Эрсдэлийн удирдлагын төлөвшлийн түвшин

2.1 Эрсдэлийн удирдлагын төлөвшлийн түвшний өөрийн үнэлгээ, тайлбар

Эрсдэлийн удирдлагын төлөвшлийн түвшний үнэлгээгээр үнэлэгдсэн үзүүлэлт.

1. Эрсдэлийн засаглал ба соёл – Ахисан буюу Дөрөвдүгээр түвшин
2. Эрсдэлийн удирдлагын хүрээ – Нийцтэй буюу Гуравдугаар түвшин
3. Эрсдэлийн удирдлагын үйл явц - Ахисан буюу Дөрөвдүгээр түвшин
4. Эрсдэлийн мэдээлэл, харилцаа холбоо, тайлагнал – Үүсэж буй буюу Хоёрдугаар түвшин
5. Эрсдэлийн удирдлагын хяналтын тогтолцоо – Ахисан буюу Дөрөвдүгээр түвшин

Нийт үнэлгээний дундаж - Дотоод хяналт байгууллагын үйл ажиллагаатай бүрэн уялдаж, тайлангийн үр дүнг гүйцэтгэлийг тогтмол сайжруулахад ашигладаг. Эрсдэлийн тайланг урьдчилан сэргийлэх, шийдвэр гаргах чухал хэрэгсэл болгож байгууллагын хэмжээнд тогтвортой ашигладаг. Дотоод аудитын үйл ажиллагаа бүх нэгжийг хамардаг, удирдлагын шийдвэр гаргах гол хэрэгсэл болж, байгууллагын хэмжээнд тогтвортой хэрэгждэг. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд тогтмол үнэлгээ хийж, тодорхой шалгуур үзүүлэлтийг ашиглан тогтмол сайжруулдаг;

Дөрөвдүгээр түвшин /Ахисан/ үзүүлэлттэй байна. (дэлгэрэнгүйг **Хавсралт 2**)

Гурав. Тулгамдаж буй асуудал

3.1 Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх санал

Тулгамдаж буй асуудал	Шийдвэрлэх санал
Мэдээллийн уялдаа: Хэлтэс хоорондын мэдээлэл солилцоо заримдаа цаг алддаг.	"E-control" системийг бүрэн нэвтрүүлж, эрсдэлийн мэдээллийг real-time хянах.
2026 оны шинэ эрсдэлүүд: Ирэх онд 92 эрсдэл тодорхойлогдсон нь ачааллыг 54%-иар нэмэгдүүлж байна.	Эрсдэлийн удирдлагыг зөвхөн нэг мэргэжилтний ажил биш, хэлтэс бүрийн өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй хэсэг болгон төлөвшүүлэх. Ажилчдыг сургалтад хамруулах.
Эрсдэлийн менежментийн тогтолцооны ISO31000:2018 стандарт"-ыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах.	ЭМГЛ ХХК-иас Эрсдэлийн менежментийн тогтолцоонд шаардлагатай арга зүйн дэмжлэг, мэдээлэл сургалтыг авах.

Дөрөв. Дүгнэлт

2025 онд байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явц, эрсдэлийн бодлого, зохицуулалт хэвийн явагдаж буй эсэхийг тогтоох, алдаа дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлагын үйл явцыг баримтжуулах, тасралтгүй сайжруулахад чиглэсэн хяналт, шалгалтын үйл ажиллагаа буюу Эрсдэлийн удирдлагын хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн. Ингэснээр тайлант хугацаанд "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь "Идэвхгүй хяналт"-аас "Идэвхтэй удирдлага"-ын шатанд амжилттай шилжсэн.

Мөн Компанийн бизнес төлөвлөгөөний зорилтуудтай эрсдэлийн бүртгэлийг уялдуулсан нь эрсдэлийг зөвхөн аюул занал гэж харахаас илүүтэйгээр, зорилтод хүрэх боломжийг нэмэгдүүлэх хэрэгсэл болгон ашиглах эхлэлийг тавьсан юм. Нийт тодорхойлсон эрсдэлийн **81,6%** буюу **40** эрсдэлийн түвшинг бууруулж, бүрэн арилгасан нь эрсдэлийн хариу арга хэмжээ оновчтой байсныг илтгэж байна. Ирэх 2026 онд тодорхойлогдсон эрсдэлийн тоо 49-өөс 92 болж өссөн нь дараах хоёр үндсэн шалтгаантай гэж үзэж байна:

1. Ажилтнуудын эрсдэлийг олж харах, бүртгэх чадавх сургалтын үр дүнд дээшилсэн.
2. Зорилтууд илүү детальчилсан шинжтэй болсноор дагалдах үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдэлүүд илүү тодорхой болсон.

Хавсралт 1. Эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Эрсдэл хариуцагч	Эрсдэл	Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн удирдлагын төрөл	Эрсдэлд авах хариу арга хэмжээ	Хийгдэх ажил	Хийгдсэн ажил	Гүйцэтгэлийн үнэлгээ	Хяналтын үнэлгээ	Хариу арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрсэн эрсдэлийн түвшин	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
№	Хийгдэх ажлыг хариуцаж хийх газар, нэгж	Тодорхойлсон эрсдэл	Бага	Урьдчилан сэргийлж болох хуйц эрсдэл, стратегийн эрсдэл, гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийн удирдлагын арга хэлбэр: эрсдэлээс зайлсхийх, арилгах, эрсдэлийг бууруулах, шилжүүлэх, хүлээж зөвшөөрөх	Тухайн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд хийгдэх ажлууд	Эрсдэл бууруулахад хийгдсэн ажил, хийгдээгүй тохиолдолд тухайн ажил хийгдээгүй шалтгаан	100%, 90%, 70%, 50%, 30%, Үнэлэлт х боломжгүй	100%, 90%, 70%, 50%, 30%, Үнэлэлт х боломжгүй	Бага	Бүрэн ажилсан, түвшин нэмэгдсэн, өөрчлөлтгүй, түвшин нэмэгдсэн
			Дунд					Дунд			
			Өндөр					12-25	Өндөр	12-25	
1	ГУУХ, СШХ	Үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулах саналыг боловсруулан хүргүүлэх ба хэрэгжих эсэх нь ОТ ХХК-аас бүрэн хамгаарах тул хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлтэй	Дунд	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Үйлдвэрлэлийн өртөг зардлыг бууруулах санал боловсруулж хүргүүлэх ба хэрэгжилтийг шаардах, хэрэгжүүлэх боломжгүй бол шалтгаан тайлбарыг авах	Оюу толгой төсөл болон үйл ажиллагааны сар бүрийн үйлдвэрлэлийн нэгж зардалд дүн шинжилгээ хийн сарын тайланд тусган ажилласан. Үйлдвэрлэлийн өртөг зардалд дүн шинжилгээ хийж, 2026 оны төсөвт санал боловсруулсан.	100%	100%	Бага	Түвшин буурсан
2	ГУУХ, СШХ	Хөрөнгийн ашигт ажиллагаа буурах, санхүүжилтийн зардал өсөх	Дунд	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	ОТ-н хөрөнгийн багтай хамтарч ажиллах, цаашид хөрөнгийн удирдлагын нэгдсэн нэг ойлголтой, хөрөнгийн удирдлагын төлөвлөгөөтэй ажилдаг болох.	ОТ-н хөрөнгийн удирдлагын багтай уулзалт зохион байгуулж, хөрөнгийн удирдлагын урт хугацааны төлөвлөгөөтэй ажилладаг болох чиглэлээр санал өгсөн. Үүний дагуу тус компани хөрөнгийн удирдлагын урт хугацааны төлөвлөгөөг боловсруулж байгаа болно. Цаашид хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. ОТ ХХК-аас ирүүлсэн хөрөнгө оруулалтын зардлын тайланд тухай	90%	90%	Бага	Түвшин буурсан

							бүр дүн шинжилгээ хийн, хяналт тавин ажилласан.						
3	СШХ	Санхүүгийн тулгуурласан шинжилгээний суурь мэдээлэл алдаатай байх эрсдэлтэй.	Дунд	9	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Санхүүгийн мэдээллүүдийг баталгаажуулж давхар нягтлан шалгалт хийхийн тулд ОТ ХХК-ийн санхүүгийн багтай тогтмол уулзалт зохион байгуулж мэдээллийн уялдааг сайжруулах Тайлангийн хувилбаруудыг харьцуулж алдаа, зөрүүг илрүүлэх	ОТ ХХК-ийн санхүүгийн багтай тогтмол уулзалт зохион байгуулж мэдээллийн уялдааг сайжруулах чиглэлээр ажилласан ба ОТ ХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт боловсруулсан.	100%	100%	Бага	4	Түвшин буурсан
4	ГУУХ, СШХ, ХХ	Антре Гоулдын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас Монголын талын хүртэх өгөөжийн тооцоолол хувилбаруудыг тодорхойлоход гол нөлөөлөгч параметруудийг дутуу үнэлэх, орхигдуулах, тооцооллын механик алдаа гаргах	Дунд	10	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Зардлыг бууруулах шийдлүүдийг үе шаттай, нөлөөллийг тооцсон байдлаар боловсруулах	1. Антре гоулд (Онтрэ) ХХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар танилцуулга, мэдээлэл боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагуудад танилцуулсан. 2. АУЭБЯ-ны ТНБД-ын 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/46 дугаар тушаалаар ажлын дэд хэсэг байгуулагдсан. Ажлын дэд хэсгийн хурлыг 4 удаа зохион байгуулж тусгай зөвшөөрлүүдийн талбайг ашиглах боломжит хувилбаруудыг тодорхойлж, холбогдох санхүүгийн тооцооллыг хийж, давуу сул тал, эрсдэлийг тодорхойлж Дэд ажлын хэсгийн тайланг боловсруулж, гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулсан, холбогдох дээд шатны байгууллагуудад тайланг хүргүүлсэн. 3. Монголын талын хүртэх өгөөжийн боломжит хувилбаруудыг тодорхойлох зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулсан. 4. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг, Дэд ажлын хэсгүүдтэй хамтран ажиллаж, Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудал, төлөвлөгөө, холбогдох танилцуулга, мэдээлэл боловсруулж, тухайн хурлын зохион байгуулалтыг хийж байна.	90%	90%	Дунд	6	Өөрчлөлтгүй

5	СШХ	Санхүүжилтийн хүүг бууруулах хэлэлцээрт хүрч чадахгүй байх, 2025 онд багтан хэлэлцээр хийж амжихгүй байх	Дунд	8	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Санал боловсруулахдаа стратегийн зорилготой уялдуулж, хэрэгжихүйц байдлаар боловсруулалт хийх	Холбогдох дэд ажлын хэсгийн хүрээнд ХНЗ-ийн хүүг бууруулахтай холбоотой суурь судалгаануудыг хийж, хэлэлцээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын зөвлөх үйлчилгээний багуудтай хамтран ажиллаж стратегийн зорилготой уялдан санал боловсруулсан. Хэлэлцээ үргэлжилж байгаа ба хэлэлцээний бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70%	50%	Дунд	6	Өөрчлөлтгүй
6	СШХ	Санхүүгийн загварын өгөгдөл, мэдээлэл, тооцооллын алдаанаас шалтгаалан буруу дүгнэлт гарах	Бага	4	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Өгөгдөл, тооцооллыг шалгах	Мэдээлэл, нягтлах, шалгах	90%	90%	Бага	2	Өөрчлөлтгүй
7	ГУУХ, СШХ, ХХ	Төсөв хэлэлцэх үеэр шаардлагатай мэдээлэл, материалыг хэрэгцээт хугацаанд багтаж ОТ ХХК-иас авч чадахгүй байх	Дунд	9	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Төсвийн хурлаас өмнө мэдээллээ ирүүлж, судалж дүгнэлт гаргах хангалттай хугацаа гаргаж өгөхийг ОТ ХХК-аас шаардах	Төсвийн хурлаас өмнө уурхайн талбарт ажиллаж 2026 оны уулын ажлын төлөвлөгөөтэй танилцсан. 2026 оны төсвийн хуралд оролцож, төсөвт дүн шинжилгээ хийн ажилласан.	100%	100%	Бага	4	Түвшин буурсан
8	ГУУХ, СШХ, ХХ	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх хүрээнд байр суурын зөрүүтэй асуудалд дийлэнх олонхын саналаар гадаад хөрөнгө оруулагчийн талд шийдвэр гарах	Дунд	9	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Шилжүүлэх	ТУЗ-д хараат бус гишүүдийг оруулах санал гаргаж холбогдох өөрчлөлт гэрээнүүдэд оруулах ажиллах	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 68 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг ОТ ХХК-ийн засаглал сайжруулах асуудлаар гадаадын хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ үргэлжилж байгаа.	50%	50%	Бага	4	Түвшин буурсан
9	ХХ, СШХ, ГУУХ	Менежментийн үйлчилгээний гэрээг заасан хугацаанд шинэчлэн байгуулж чадахгүй эсвэл одоо байгаа гэрээний зүйл заалтыг сулруулах.	Өндөр	12	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Талуудтай харилцан шийдлийг олох, МУГ-ний судалгааг нарийвчлан хийх.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 68 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг менежментийн үйлчилгээний асуудлаар гадаадын хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ үргэлжилж байгаа.	50%	50%	Дунд	10	Түвшин буурсан
10	СШХ, ХХ, ГУУХ	ОТ-н далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт болон зардалд хөндлөнгийн аудит хийлгэх аудиторыг сонгох хугацаа удаашрах	Дунд	6	Урьдчилан сэргийлж болохуйц эрсдэл	Арилгах	Талуудын шийдвэр гаргах процессыг дэмжих.	АҮЭБ-ын сайдын А/29 дүгээр тушаалаар батлагдсан Ажлын хэсэг Ажлын даалгаврыг боловсруулан Рио Тинто компани руу хүргүүлсэн. Рио Тинто компаниас ирсэн хариуг хүлээн авч хариу албан бичгийн хүргүүлсэн.	90%	70%	Дунд	6	Өөрчлөлтгүй

11	СШХ, ХХ, ГУУХ	Хөндлөнгийн дүгнэлт нь талуудын хүлээлттэй нийцэхгүй байх. Тухайн зөвлөх нь өмнө аль нэг талтай хамтран ажиллаж байсан буюу сонирхлын зөрчил үүсэх	Дунд	9	Урьдчилан сэргийлж болох хүйц эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Сонирхлын зөрчил үүсэх асуудлаас урьдчилан сэргийлж ажиллах	Сонирхлын зөрчил үүсэх асуудлаас урьдчилан сэргийлж хөндлөнгийн зөвлөхийн ажлын даалгаварт ашиг сонирхлын зөрчлгүй шаардлагыг тусган ажилласан.	100%	100%	Бага	4	Түвшин буурсан
12	СШХ, ХХ, ГУУХ	Маргаан сунжрах, нэгдсэн шийдэлд хүрэхгүй байх	Дунд	6	Гадаад хүчин зүйлийн эрсдэл	Арилгах	Талуудын хамтарсан шийдвэр гаргах процессыг дэмжих.	Талуудтай хамтран ажиллаж байна.	70%	50%	Дунд	6	Өөрчлөлтгүй
13	СШХ	Дэвшүүлсэн санал шийдвэрт нөлөөлөхгүй байх, үр дүнгүй болох.	Дунд	9	Үйл ажиллагааны эрсдэл	Эрсдэлийг бууруулах	Тухай бүрт урьдчилан сэргийлэх зорилгоор талуудад мэдээлэл өгөх, санал авах, эргэх холбоог сайжруулах, хэрэгжилтийг хянах, эрсдэлийг урьдчилан харж сайн, муу хувилбарт бэлтгэлтэй байх	ОТ ХХК-ийн сарын тайланд дүн шинжилгээ хийж, хянасан. ОТ ХХК-иас сар бүр тогтмол хийдэг үйл ажиллагааны хурлуудад оролцсон.	100%	100%	Бага	4	Түвшин буурсан
14	ГУУХ	Ил уурхайн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөлтийн тооцоо, гүйцэтгэлийн тайлан, мэдээллээр бүрэн хангагдахгүй байх	Дунд	6	Урьдчилан сэргийлж болох хүйц эрсдэл	Арилгах	ТЗЗУ-ийг боловсруулахдаа холбогдох дүрэм, журам, хууль тогтоомжийн хүрээнд тооцоо, судалгааг боловсруулж 5 жил тутамд батлуулж хүлээлгэн өгөх. ТЗЗУ-д үндэслэж тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөг боловсруулах. Төлөвлөгөөний хэрэгжилтийг уулын ажлын тайлангаар хянах.	ТЗЗУ болон жилийн уулын ажлын төлөвлөлт гүйцэтгэлтэй харьцуулалт хийж удирдлагад танилцуулав. Мөн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлангаар авав.	100%	100%	Бага	4	Түвшин буурсан
